




ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ МЭДЭЭЛЭЛ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



Сэтгүүлийн эрхлэгч: Д.Лүндээжанцан
Ерөнхий редактор: О.Амархүү
Зөвлөлийн гишүүд: Ж.Болдбаатар
Ж.Бямба
Н.Жалбажав
Ц.Эрдэнэболд
Ч.Жадамба
Нарийн бичиг:

ГАРЧИГ

- 1 Д.ЛҮНДЭЭЖАНЦАН
*Монгол улсын тусгаар тогтнол,
түүний үндсэн хуулийн баталгаажилт* 3
- 2 Н.ЖАЛБАЖАВ
*Нийгмийн байдал, төлөв, үндэсний ухамсар,
ёс суртахууны шинэчлэлтийн тухайд* 14
- 3 Ж.БЯМБАА
Мөрдөх чиг үүргийн агуулгыг шинээр авч үзэх нь 30
- 4 Р.ОЮУНБАДАМ
*Оргон зайлсан ялтан, яллагдагчийг эрэн сурвалжлах үйл
ажиллагааны зарлан мэдээлэх үйл явц* 37
- 5 Ц. ДОРЖНЯМ
*Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гүйцэтгэх ажлын
үр дүнг ашиглахтай холбогдсон зарим асуудал* 46
- 6 Ц. ЭРДЭНЭБОЛД
Дэлхийн худалдааны байгууллага 54
- 7 А.ДОРЖГОТОВ
Компанийн тухай хуулийн товч тайлбар 58
- 8 С.БАТБУЯН
Монгол Улсын чөлөөт бүсийн ирээдүй ба эрх зүйн орчин 67
- 9 П.БАЯНБААТАР
*Монгол улс дахь ардчиллын хямрал,
ардчиллыг шинэчлэх трилемма* 76
- 10 Ц.АМАРСАНАА
Эрх зүйн хөгжил, постмодерн /Захиргааны эрх зүйн хүрээнд/ 82
- 11 М.ХАТАНЗОРИГ
*Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн ажиллагааг боловсронгуй болгох нь* 90




МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГААЖИЛТ



УИХ-ын гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан

Би бээр нэгэнтээ Түмэн хэлтэн олон үндэстэн ястны өлгий болсон цэнхэр гарагаа өнгө булаалдан алаглах цэцгийн мандал лугаа зүйрлэж байснаа санаж байна. Тэр олон үндэстэн ястны хэл соёл, зан заншил, ашиг сонирхол өөр өөр, оршин тогтнох орон зай, амьжиргааных нь эх ундарга хоол хүнс, эрдэс баялаг нь хязгаартайн тул зөрчилдөн тэмцэлдэвч эх дэлхийдээ энх амгалан аж төрөхийн тулд өөр хоорондоо аяыг олж эвийг сахиж зохицолдохын арга ухаан онцгой чухал бөлгөө. Зохицлын энэхүү арга ухаан, алаг цэцэгсийн

мандлыг сэргээн тэтгэх хурын шим лугаа амин чухал ажгуу. Хэнд нь энэхүү арга ухаан түлхүү заяагдаж байна тэр үндэстэн ястны төр улсын гал голомтоос хүч чадал, мандал бадралын оч гэгээ сацарч хана туурга нь зөрчил тэмцлийн шуурганд ч үл автах бөлгөө. Ертөнцийн эрдэмтэн мэргэд үндэстэн ястны төрөлх орон гэрээ авч явах арга ухааныг тусгаар тогтнолын арга ухаан хэмээн тайлжээ. Үүнийг эдүгээчилбээс, Тусгаар тогтнол нь ямар нэг харийн улс орны эрхшээл, шахалтад орохгүйгээр зөвхөн үндэсний язгуурын эрх ашиг, ард түмний хүсэл зорилгод нийцүүлэн төрийн гадаад дотоод бодлогыг хэрэгжүүлэх боломж, энэ тухайд улс төр, эрх зүйн үндэсний болон олон улсын шинжтэй баталгаат нөхцөл бүрэлдсэн байхыг хэлдэг байна. Улсын тусгаар тогтнолын үндэс суурь нь төр, улсынхаа бүх хэрэг явдлыг өөрөө мэдэж шийдвэрлэх чадвар буюу бүрэн эрхт байдал (“суверенитэт” францаар бол *souverainete*, англиар *sovereignty* гэдэг ажгуу) болдог байна. Б.Чимид багш энэхүү уялдаа холбоог “Улсын тусгаар тогтнол гэдэг нь ... бүрэн эрхт байдлаа хамгаалах баталгааг хангаж, хүчин чадлыг ямагт нэмэгдүүлж ард түмэн эв нэгдлээ бэхжүүлэх ойлголт мөн” гэж нэгэнтээ тайлжээ. (Б.Чимид Үндсэн хуулийн мэдлэг. 2008 он 53 дахь талд)



Багш маань улс орны бүрэн эрхт байдлыг дараах байдлаар томъёолжээ.

Үүний сацуугаар орчин үеийн либералууд бүгд найрамдах засаглал, үндсэн хуульт ёс, төрийн эрх мэдлийн хуваарилалт, иргэний нийгмийн төлөвшил, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилтыг төрийн бат бэх байдал, улмаар улс орны хөгжил дэвшил, тусгаар тогтнолын баталгаа гэж үзсэнтэй санаа бодол зөрөөд байх юм алга. Төрөл төрлийн (удам угсааны, дур зоргын, нэр хүндийн (харизматик) цэрэг-цагдаагийн) тоталитар дэглэм дарангуйллын засаглал хэчнээн хэврэг, төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхэд ямар уршигтайг дорно дахин арабын ертөнцөд өрнөн буй хэрэг явдал бэлхнээ нотолсоор байна. Монгол гэрээр зүйрлэвэл унь тооно, хана, хаалга багана, бүслүүр хошлон цөм эв номондоо байж улс гэр оршино. "Ухааны чагтага" сайн байж гэрээ салхинд хийсгэчилгүй, үерт урсгачихгүй, дотроос нь нураачихгүй авч явдаг.

Хүн өмчтэй болсон хийгээд үндэстэн ястнууд өрх тусгаарлаж төр улсууд үүссэн цагаасаа л олз

омог, эрх мэдэл булаацалдсан зөрчил тэмцлийн эргүүлэгт автаж хүчирхийлэл, дайн байлдааны гамшгийг амсан, яаж энэ гамшиг зовлонгоос ангижрах арга ухааныг сийлсээр олон улсын хамтын нийгэмлэг- НҮБ, олон улсын эрх зүй хэмээх баталгааг бүрдүүлсэн түүхтэй. Гэхдээ энэхүү баталгаа нь бас төгс бусыг бид эдүгээ үзэж мэдэрч буй билээ.

Монгол улсын тусгаар тогтнол бол 2200 гаруй жилийн турш оршин тогтнохуйн эрхийнхөө төлөө хийсэн хатуу ширүүн тэмцлийн үр дүн, үе үеийн эх орончдын амь бие үл хайрлан урсгасан цусных нь үнэ цэнэ, монголын ард түмэн, монгол төрийн ашид мөнхийн юутай ч зүйрлэшгүй үнэт зүйл бөлгөө. Эрх чөлөөг эрхэмлэгч талын эрэлхэг нүүдэлчний үр сад нь дуу хуур, шүлэг найргийнхаа дээжийг тусгаар тогтнолдоо зориулж монгол ухаанаа хурцалж, монголоо гэсэн сэтгэлийн галаа бадрааж тусгаар тогтнол хэмээх эрхэм үнэт зүйлээ тээж яваа үндэстэн.

Даяаршлын гэгдэх энэ цаг дор эе эвээ улам бэхжүүлэн нэгэн санаа зоригоор үндэсний түүх, соёл, үнэт зүйлээ нийт хүн төрлөхтний хөгжилтэй хөл нийлүүлэн арвижуулах, шинжлэх ухаан, техник технологийн ололтод түшиглэхийн хамт хөрш хийгээд бусад олон улс оронтой улам бүр үр ашигтай хамтын ажиллагаагаа өргөтгөн, улс түмний энх тайван аюулгүй байдлын үйл хэрэгт идэвхтэй оролцох замаар улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын дотоод гадаад баталгааг бэхжүүлэх нь төр улсын маань



оршин тогтнохуйн ашид мөнхийн эрх ашигт нийцсэн нийгмийн эрэлт хэрэгцээ захиалга болж байна.

Монголын төрт ёс, тусгаар тогтнол 2000 гаруй жилийн түүхтэй ч дээр хэлсэн 800 гаруй жилийн тэртээ XIII зууны эхэн, билгийн тооллын гурав дахь жарны улаан барс жилд буюу 1206 онд Тэмүжин-Чингис Богд Онон мөрний хөвөөнөө Есөн хөлт цагаан тугаа залж, Их хуралдайг хуралдуулж, Алтайн мөнх цаст оргилоос Алтан Хянганы ногоон нарст даваа, Байгал эх далайгаас түмэн газрын Цагаан хэрэм хүртэлх Төв Азийн өргөн уудам нутагт тархай бутархай 30 гаруй овог, аймгийн хоёр зуугаад түмэн иргэдийг эрхшээж Их Монгол улсыг байгуулсныг зарлан тунхагласан нь Монголын буурал түүхийн хамгаас бахархалтай онцгой гайхамшигт содон үйл явдал болжээ. Тэнгэрээс тэтгэгдсэн суут Богд “хагацсан улсыг хамтатгаж бутарсан улсыг бүрдүүлж...”, “эсгий туургат улсаа шулуутгаж ...” энх амрыг тогтоон Монгол угсаатны туурга тусгаар төр улсыг байгуулсан нь монголчуудын тусгаар тогтнолын түүхэнд онцгой ач холбогдолтой үйл хэрэг байв.

Эзэн Чингисийн байгуулсан эзэнт гүрэн өгсөж, уруудах түүхийн эх нугачаанд дотоодын зөрчил тэмцлийн уршиг гайгаар бутарч сарнисаар улмаар XVII зуунд Манжийн эрхшээлд орж 220 гаруй жил тусгаар тогтнолоо алдсан билээ. Гэвч монгол түмний эх оронч сэтгэлгээ бөхөөгүй юм. Өнгөрсөн зууны эхнээс монголын ихэс дээдэс, лам хувраг, цэрэг эрс, иргэд тусгаар тогтнолоо сэргээн мандуулах хэрэгт

нэгэн санаа зоригоор босон тэмцэж 1911 оны XII сарын 29-ны билигт сайн өдөр тусгаар улсаа тунхаглан зарлаж VIII Богдыг хаан суудалд нь залав. Харин Орос, Хятад хоёр их гүрний шахалтын дор 1915 оны Гурван улсын гэрээ гэгчээр “автономит улс” болов. 1921 онд Дамдины Сүхбаатар, Догсомын Бодоо, Солийн Данзан нар журмын нөхдийн хамт “МАН” хэмээх улс төрийн анхны хүчинг байгуулж, эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө монгол түмнийхээ тэмцлийг манлайлав. Ардын хувьсгалын ялалт улс орны тусгаар тогтнолыг сэргээн мандуулах үйлсийн үндсийг тавьж улмаар тухайн үеийн ардчилсан үзэлт, номч мэргэн төрийн олон түшээ нарын хүчин чармайлтаар 1924 онд Анхдугаар үндсэн хуулиа батлаж Бүгд Найрамдах Улсаа байгуулав. Гэвч Монгол Улсын тусгаар тогтнол олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй, хоёр туйлт ертөнцийн тэмцлийн эргүүлэгт ёстой л хутганы ирэн дор байв. Ахмад үеийнхний холч мэргэн ухаан, зүйрлэшгүй их тэвчээр, монголын ард түмний милитаризм, фашизмыг эсэргүүцсэн бүх нийтийн тэмцэл, ялалтад оруулсан хувь нэмрийн ач буянаар *Монгол улсын тусгаар тогтнолыг /Де Факто/* олон улсад хүлээн зөвшөөрөх үндэс тавигдсан юм.

1946 онд өмнөд хөрш маань дайнд ялсан гүрнүүдийн шахалт, монголын бүх ард түмний санал асуулгын дүнг эрхбиш ойшоож, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд хүрсэн юм. Гэхдээ Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсын



хамтын нийгэмлэгээр бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дахиад 20 шахам жилийн нөр их хүчин чармайлт гаргах хэрэгтэй байжээ. 1961 онд БНМАУ олон улсын хамтын нийгэмлэг-НҮБ-ын бүрэн эрхт гишүүн нь болж монголын ард түмний нөр их хичээл зүтгэл, хүчин чармайлт, хүсэл эрмэлзэл биелэж монголын тусгаар тогтнол Де юри буюу олон улсын хууль эрх зүйн баталгаа нь бүрэн дүүрэн бий болсон билээ.

Өмнөх хэлснээ дүгнэхэд төр улсын маань тусгаар тогтнолын гол баталгаа нь монголын ард түмэн өөрөө бөгөөд түүний үндэс нь:

- *Ардчилсан төрийн тогтолцоо,*
- *Монгол улсын иргэний эрх, эрх чөлөөний баталгаа болсон хувийн өмч, түүнд суурилсан эдийн засгийн чадавхи, зах зээлийн чөлөөт шударга өрсөлдөөн*
- *Үндэсний эв нэгдэл, эх оронч үндэсний үзэл, хүмүүжил нь тусгаар тогтнолын оюуны үндэс суурь нь болой*
- *Үндсэн хуульд суурилсан эрх зүйн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт*
- *Үндэсний соёл, иргэншлийн өвөрмөц өнгө төрх, үнэт зүйлсээ хамгаалан хөгжүүлэх баталгаа*
- *Боловсрол, шинжлэх ухааны хөгжил, хүн ардын эрүүл мэнд,*
- *Монгол улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын нэр хүнд, байр суурь болдог байна.*

Эдгээрээс тусгаар тогтнолын үндэсний болон олон улсын эрх зүйн баталгааг онцолж байна. Учир нь олон улсын хамтын нийгэмлэг, олон улсын хүний эрхийн болон бусад түгээмэл актууд, олон улсын тавцанд улс орны эзлэх байр суурь, нэр хүнд нь төр улсын тусгаар тогтнолын гадаад орчин, гадаад хүчин зүйл нь болдог төрийн байгууламж, түүний улс төр, эдийн засгийн, нийгмийн үндсийг, иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Үндсэн хууль, түүнд суурилсан, түүнээс салбарласан эрх зүйн тогтолцоо нь төр улсын бүрэн эрхт байдал тусгаар тогтнолын дархлаа нь болдог бөлгөө.

Төр улс нь нийт иргэний сонголтоор байгуулдаг БН засаглалтай, Үндсэн хууль хэмээх гол хуультай байх түүгээр төрийн тогтолцоогоо баталгаажуулдаг, нийгмийн суурь харилцааг зохицуулдаг, бусад бүх хууль нь гол хуулиасаа салбарласан, түүнийхээ үзэл баримтлалд нийцсэн байхыг олон улсын эрх зүйд Үндсэн хууль ёс хэмээдэг.

Төр улсынхаа хэргийг хуулиар засан тохинуулдаг нь Монголын төр ёс, хууль цаазын олон зууны түүхэн уламжлал гэх бүрэн үндэстэй юм. Суут Богд Чингис хаан Хархорумыг Улсын нийслэл, худам монгол бичгийг төрийн бичиг болгож, "Их Засаг" хэмээх төрийн гол хуулийг дагаж мөрдөхийг зарлигдаж, Их хуралдай, Сэцдийн зөвлөлөөр их хэргийг хэлэлцүүлж төрийн хэрэг нуруу түвшин чин шударга байхын үндсийг тавьсан билээ. Их Засаг хууль нь Их Монгол Улсын хууль цааз эрх зүйн гол эх сурвалж болох



нь маргаангүй, учир нь уг хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, эзэн албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим журмыг тогтоож нийгмийн гол гол харилцааг эрх зүйн зохицуулалтад оруулж байжээ. Өнөөгийн үг хэллэгээр илэрхийлэхэд Их Засагт төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхийн эрх зүйн баталгааг бүрдүүлжээ. Тиймээс ч Их Засгийг Монгол төрийн бүх хууль тогтоомжийн “эцэг хууль” хэмээн нэрлэдэг билээ. Зөвхөн төрийн ашиг сонирхолд төдийгүй монголчуудын эртнээс тогтсон ёс заншилд тулгуурласан Их Засаг хуулийн ач холбогдол нь Монгол төрийн тулгуур хууль нь байж, улс орны эрх зүйн төлөвшлийг тухайн үеийн нөхцөл шаардалагатай нийцүүлж байснаараа Их Монгол улсын тусгаар төрийн багана нь орших эрхийн баталгаа болж байснаар тодорхойлогдоно. Хуулийг тогтоож батлахаас гадна ягштал даган мөрдүүлж, улс гүрэн даяараа энх амгалан тогтоож чадсан, “шулуун шударга, чадал эрдэмтэй, цэцэн ухаантай хүнийг хэн ч байсан итгэл хүлээлгэж төрийн хэргийг тушааж, улсыг засахад зүтгүүлэх нь “Бадрах төрийн бат оршихуйн нэг үндэс болдог” тухай мөн “өглөө хэлснээ үдэш нь, үдэш хэлснээ өглөө нь няцагч туйлбаргүй зантан, бусдыг бүү хэл өөрийгөө захирч эс чадагч ичгүүргүй явдалтан, эд хөрөнгө, эрх мэдэлд ташаарагч шунаг зальхай, харгис, журамгүй хэнд ч болов

төрийн хэрэг бүү даалга” гэсэн Их Засгийн үзэл санаа, эзэн Богдын зарлиг эдүгээ төрийн алба, албан тушаалтанд үнэхээр сургамжтай юм.

Жувейни (Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх), Рашид Ад Дин (Судрын чуулган), Плано Карпини (Монголчуудын түүх), Гельн Де Рубрик (Дорно этгээдэд зорчсон минь), В.А.Рязановский (Чингис хааны Их Засаг, Монголын эрх зүй), Р.Сайшаал (Чингис хааны товчоон), Жорж Вернадский, Владиморцов зэрэг Монголын түүх, соёл, хууль цаазын эх сурвалжуул (Их засаг, Нууц товчоо, Алтан товч)-ыг судласан өрнө дорнын мэргэдийн ном судраас үзэхэд эзэн богд Чингис хааны Их Монгол Улсын түүх бол эрх чөлөөг эрхэмлэгч эрэлхэг нүүдэлчдийн төр улсынхаа тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхийн төлөө, ураг хойч үеийнхээ энх амгалан оршихуйн төлөө шударгуу чанд хууль цаазыг тогтоон хосгүй баатарлагаар тэмцсэн түүх гэдгийг нэгэн санаагаар хүлээн зөвшөөрснийг түвэггүйхэн олж харах болно.

Монголчуудын хэзээний танил, “Чингис хаан өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн” бүтээлийг зохиогч Жак Уэтэрфорд абугай Монголчуудыг зөвхөн төрөлх орон гэрээ төвхнүүлсэн төдийгүй эзэн Богдын үндэслэсэн их эзэнт гүрэн дэлхийн газрын зургийг ахин шинээр үйлдэж, саланги тусгаар хаант улсуудыг нэгтгээд зогсоогүй шинэ ертөнцөд ... аргамжиж зангидаж чадсан... Монголчууд байлдан дагуулагчид төдийгүй нэгэнт эзэлсэн их гүрнээ тогтоон



барихдаа ухаалаг, тасралтгүй бодлого явуулсан суу билэгтнүүд байсныг онцолсон нь санаандгүй хэрэг биш. Монголчуудын оршин тогтнохуйн энэхүү хосгүй арга ухаан суу заль нь улс үндэснийхээ ашид мөнхийн дархлааг бүрдүүлж хүн төрөлхтөн хэмээх цэцэгсийн мандлын нэгэн содноос содон өнгө төрх, сор нь болон дэлбээлэх учир тавиланг нөхцөлдүүлжээ. *Тэрхүү их хувь тавилангийн ач буян цуснаас цусанд үеэс үед нэвчин түгсээр өнөөгийн цөвүүн цагт ч монгол түмний итгэл найдварын нэгэн ундарга нь болсоор байна.*

Өнгөрсөн зууны эхнээс дэлхий дахинаа ашиг сонирхлын хил хязгаараа тэлэх гэсэн их гүрнүүдийн зөрчил тэмцэл ширүүсч 1905 онд Алс Дорнодод Орос Японы, 1914 оноос дэлхийн их дайн дэгдэж 1917 оны Большевик хувьсгал ялж хоёр туйлт ертөнц үүсэх нь тэрээ. Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл дарангуйлалд талхигдсан их бага үндэстэн ястны дунд тусгаар тогтнол, ардчилал, шударга ёсны хийгээд үндэсний ухамсар сэргэв. Энэтхэг, Хятад, Перст үндэсний эрх чөлөөний тэмцлийн шуурга дэгдэв. Дэлхий дахины эдгээр их хэрэг явдлын нөлөөн дор Монголын ард түмний тусгаар тогтнолоо сэргээн мандуулах их зорилго, хүсэл эрмэлзэл биелэх түүхэн нөхцөл бүрдлээ. Улмаар 1911, 1921 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал мандаж монголчууд төрөө засах шинэ цагийн арга ухааны эрэлд мордож монголын уудам хээр нутагт хүн төрөлхтний төр ёс, хууль цаазын үнэт зүйл болсон Үндсэн хуульт ёс, Бүгд найрамдах Засгийн гэрэл гэгээ тусав.

Анхдугаар Үндсэн хуулиар үндэсний эрх чөлөөний тэмцлийн ялалтыг хуульчлан баталгаажуулж БНУлсаа тунхагласан нь монголын ард түмний тусгаар тогтнолоо сэргээн мандуулахын төлөө хийсэн зуун зуун жилийн хүнд бэрх тэмцлийнх нь хууль ёсны үр дүн байв.

Анхдугаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд:

“Бүх Монгол улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах бүрэн эрхт Ард улс гэж улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлж улсын аливаа хэргийг УИХ-д ба мөн хурлаас сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг сүсэглэн дагавал зохино.” “... Бидний улсын бүрэн эрхэд халдах этгээд бий ахул бүхий л хүчээр эсэргүүцэн эргүүлбэл зохино” гэжээ. Үндсэн хуулиар дундад зууны ихэд бурангуй хамжилгат ёс, хаант засгийг халж ардын эрхт Үндсэн хуульт Бүгд Найрамдах засгийг тогтоон Улсын дээд эрхийг мэдэж шийтгэх газар, нутгийн захиргааны тухай, сонгох сонгогдох эрхийн тухай, улсын орлого, зарлагын тухай, товчоор хэлэхэд Бүгд Найрамдах улсын зохион байгуулалт, эдийн засаг санхүүгийн үндсийг хуульчилан тогтоожээ. Дэлхий дахинаа ялангуяа Дорно дахины ард түмнүүдийн улс төр, эрх зүйн ухамсар, Үндсэн хуульт ёсны тухай ухаарал мэдрэмж ямар түвшинд байв, тухайн цагийн улс орны гадаад дотоод байдал зэргийг тунгааж үзвээс анхдугаар үндсэн хууль нь түүнийг тэрлэн бүтээсэн монголын ардчилсан үзэлтнүүдийн холч мэргэн ухааны



үр шим, “бидний монгол язгууртанд хэдэн зуун оноос нааш үзэгдсэнгүй гайхамшигт хэрэг...” байсныг хойч үеийнхэн нь ухаарч бахархан тэмдэглэсээр авай.

Ардчилал түгж хүний эрх, эрх чөлөө баталгаажин буй энэ цаг дор улсын анхдугаар болон 1940,1960 оны Үндсэн хуулийг хүн ардаа ялгаварласан ангич, социалист үзэл баримтлалыг шингээсэн гээд ихэд шүүмжилж буйг буруутгах аргагүй. Хүний эрх, эрх чөлөөний нэг гол батлагаа болдог хувийн өмчийг үгүйсгэсэн, үндэсний ухамсар, бахархал, түүх соёлын үнэт зүйлсээ үл ойшоосон, нэг намын ноёрхол, улс төржиж үзэл сурталжсан хүнд сурталт дэглэмийг тулгасан үзэл баримтлалыг зөвтгөх арга үгүй.

Монгол төрийн бодлогын амин чухал асуудал хүний газарт бусдын нөлөө шахалтындооршийдвэрлэгдэх нь ч цөөнгүй байв. Гэвч тусгаар тогтносон бүрэн эрхт улс байж, нийгмийн дэвшил хөгжлийн замд хүн ардаа оруулах алсын хараатай бодлого нь геополитик, түүхийн тухайн цаг үеийн том зураглал дээр авч үзэх ахул үүнээс өөр сонголт бараг байхгүйтэй адил хэлж болно. Тусгаар тогтнолыг асар их үнээр авчирсан түүнийгээ хэмжээлшгүй их үнээр хамгаалж ирсэн. Ийнхүү эдгээр Үндсэн хуулиудын төр улсынхаа тусгаар тогтнолыг бататган хөгжил дэвшилд хүрэх голч зорилго үзэл санааг хэрэгжүүлэхийн төлөө ахмад үеийнхэн амин хувийн эрх ашгаа умартан зүтгэсээр улс орныхоо тусгаар тогтнолыг “бүрэн бүтнээр нь” бидэндээ өвлүүлсэн билээ.

1990 оноос ардчиллын шинэ

давалгаанд дэлхийн их, бага улс орнууд бараг бүгд өртөв. Монголд ч ардчиллын үзэл санаа түгэн үр дүнд нь Монголын ард түмний Үндэсний зөвшилцлийн их гэрээ болсон ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдав. Нийгмийн улс төрийн дарангуйллын тогтолцоог ардчилсан төр ёсны тогтолцоогоор халж хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулснаараа, хүний эрх, эрх чөлөөний жинхэнэ баталгаа болсон хувийн өмчид суурилсан эдийн засгийн чөлөөт зах зээлийн харилцааг төлөвшүүлэх эхлэлийг тавьж, амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн баримжааг үндсээр нь өөрчилснөөрөө энэ бол хувьсгалт үйл явц болсон юм.

Энэ түүхэн үйл явцын амьд гэрч нь идэвхтэй оролцогч нь байх хувь тавилан бидний үеийнхэнд ногдсон юм. Энэ бол өвөг дээдэс, ахмад үеийнхээ бидэнд итгэж гардуулсан тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улсаа хүн төрөлхтний төр ёс, хууль цаазын орчин цагийн үнэт зүйлс болох ардчилал, хүний эрх чөлөө, зах зээлийн харилцааны жам ёсных нь хөгжлийн замаар авч явах түүхэн их хариуцлага болой. Ангаж цангасан атар хээр нутагт маань ардчилсан үндсэн хуультай ёсны үндэс соёолох нь тэрээ.

Монгол Улсад тусгаар тогтнолыг дахин сэргээн мандуулах их үйл хэргийг удирдсан, алдаж онож явж хатуужсан МАН түүхэн эгзэгтэй цаг үед улс төрийн ууган хүчний хувьд монголын ард түмний эв нэгдлийг хангах үндэсний язгуур эрх ашгийг дээдлэн уужуу сэтгэлээр хандан эвлэрэл, зөвшилцлийн замыг



сонгосноороо улс төрийн тулхтай хүчин болохоо батлан харуулсан билээ.

Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын эрх зүйн батлагаа төгс утга учрыг олов. Бүх ард түмний зөвшилцлийн гэрээ болсон ардчилсан шинэ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн” гэжээ.

Үндсэн хуулийн тэргүүн бүлгийг “Монгол Улсын бүрэн эрхт байдал” гэсэн нь гүнзгий өргөн агуулгатай юм. Учир нь төр улсын бүрэн эрхт байдал нь:

- Тусгаар тогтносон
- Бүрэн эрхт
- Бүгд найрамдах гэсэн улсын гол шинжийг агуулдаг гэжээ. (Б.Чимид Үндсэн хуулийн мэдлэг 51 дэх талд)

Ардчилсан шинэ Үндсэн хууль бол Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх зүйн гол баримт бичиг мөн. Учир нь Үндсэн хуулиар

- Монгол улсын төрийн ардчилсан тогтолцоог төрийн эрх мэдлийг хуваарилах (Legislative power, executive body (Government, President) judicial power(courts)) зарчим, үзэл баримтлалын үндсэн дээр хуульчилан тогтоосон. Төр засгийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж Үндсэн хуулийн заалт, Үндэсний аюулгүй байдлын эрх ашигт бүрнээ нийцэж байх ёстой. Ингэж байж л тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал баталгаатай хангагдах

учиртай. Үндсэн хуулиар тогтоогдсон төрийн эрх мэдлийн хуваарилалт үүнд л чиглэгдэж байдаг. Төрийн тэргүүн-Ерөнхийлөгч, Засгийн газрын зүгээс Монгол улсын оршин тогтнохуй, тусгаар тогтнолд харшилсан зүйл хийх, шийдвэр гаргах ахул Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэц, УИХ-аас гаргах ахул Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэц таслан зогсоохоор Үндсэн хуульд зохицуулалт хийж өгсөн байх жишээтэй. Тодруулж хэлбэл Үндсэн хуулиараа баталгаажуулсан бүрэн эрхт байдлыг хамгаалах механизм Үндсэн хуульдаа мөн агуулагдаж байна гэсэн үг.

- Монгол улсын иргэний эрх, эрх чөлөөг олон улсын жишигт хүртэл баталгаажуулсан (Үндсэн хууль. Хоёрдугаар бүлэг: хүний эрх, эрх чөлөө: Human rights and freedoms)
- Нутгийн удирдлага (засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага)-ын эрх зүйн үндсийг тогтоов (Үндсэн хууль. Дөрөвдүгээр бүлэг: монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага (administrative and territorial units of Mongolia and their governing bodies))
- Хүний эрх, эрх чөлөөний үндсэн батлагаа болсон хувийн өмчийг хүлээн зөвшөөрч түүнд суурилсан зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөний эрх зүйн үндсийг тавьсан.

Энэ бол төр улсын тусгаар



тогтнолын эдийн засгийн үндэс нь юм. Учир нь эдийн засгаа бие даасан байлгах нь тусгаар тогтнолын нэг гол баталгаа мөн. Энэ баталгааг эдийн засгийн жам ёсны тогтолцоо буюу шударга, чөлөөт өрсөлдөөн, тогтвортой хөгжил, төрийн ухаалаг зохицуулалтаар хангах учиртай. Эдийн засгийн өрөөсгөл, эмзэг байдлыг саармагжуулах, экспортын чадавхийг нэмэгдүүлэх, монополийн аливаа илрэл, зохион байгуулалттай гэмт хэрэг, авилгатай тэмцэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд шинжлэх ухаан технологийн ололт, инновацид түшиглэх, төрийн бодлого зохицуулалтын ил тод байдлыг хангах, төрийн оролцоог саармагжуулах зэрэг нь эдийн засгийн бие даасан байдлаа хамгаалах арга зам юм. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхийн зэрэгцээ үндэстэн дамнасан корпорацуудын шунахай сэдэлт нөлөө, оролцооноос эдийн засаг, зах зээлээ хамгаалах тогтолцоо, арга хэрэгсэл үгүйлэгдсээр л байна. Сүүлийн үед төрийн бодлогод, ялангуяа уул уурхай, эрдэс баялгийн бодлого гадны оролцоо нөлөө хэрээс хэтэрч буй, “Баялгийн хараал” тусах буюу эрдэс баялагтай холбогдсон хэрүүл тэмцэл ширүүсэх, авилга өсөх хандлага газар авч буй тухай ярьж бичих нь ч элбэгшив.

Эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулах зорилготой манай улсын хувьд Үндсэн хуулиараа даяар олноо зарлан тунхагласан энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн эдийн засгийн эрэмбэ дарааг тогтоох шаардлага тулгарч

байна. Үндсэн хуулийн эдийн засгийн бодлогыг иргэддээ хүрсэн байдлаар эрэмбэлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Тодруулж хэлбэл, нийгмийн чиг баримжаатай хөгжлийг хангахад чиглэсэн хүний хөгжил, нийгмийн суурь үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, байгал орчин, дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэр гэх мэтээр эрэмбэлнэ гэсэн үг. Үндсэн хуульд газар түүний баялаг, буянт мал сүрэг маань төр, түмний хамгаалалтад байхыг хоёрдмол утгагүйгээр заасан. Үүнийгээ сахиж биелүүлье гэсэн үг.

- Үндсэн хуулинд *Иргэний нийгэм /civil society/* төлөвшин хөгжих эх зүйн батлагаа бүрдсэн
- Үндэсний эв нэгдэл бэхжих, эх оронч үндэсний үзэл хүмүүжил төлөвших, үндэсний зан заншил, соёл, аж төрөхүй цэцэглэн хөгжих эрхзүйн орчин бүрдсэн. Энэ бол тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, *Үндэсний аюулгүй байдлын оюуны үндэс суурь нь болой.*
- Улс орноо батлан хамгаалах нь төр, иргэний үүрэг, бүх нийтийн үйл хэрэг болохыг тодорхойлон заасан (Үндсэн хууль XI зүйл) Энэ нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэгэн баталгаа болсон өөрийгөө *Батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн гол үндэс* мөн. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил, халдашгүй дархан байх, хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчийг Монгол улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглосон,



Монгол улсын Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй тухай /Үндсэн хуулийн 4, 10 дугаар зүйлүүд/ заалтууд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангахтай холбоотой суурь заалтын нэг хэсэг юм.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн Хууль төр улсын тусгаар тогтнолын улс төр, эдийн засаг, нийгэм соёлын, оюуны үндсийн бүрдэл бэхжилтийн эрх зүйн баталгааг бүрдүүлэв. Үндсэн Хуулиа бүх нийтээрээ хэлэлцэн батласан нь монголын ард түмэн, Монгол Улс "хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго" болгосныг дэлхий дахинд нотлон харуулж Монгол улсын олон улсын нэр хүнд өсч, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, батжин бэхжих гадаад цоо шинэ орчин бүрдүүлэв.

Төрийн ардчилсан тогтолцоо төлөвшин буй, Монгол Улсын иргэн өмчтэй байх эрх, эрх чөлөө баталгаажин буй, Монгол Улсын олон улсын нэр хүнд, байр суурь өсч монголын төр харьцангуй /!/ бие даасан бодлого хэрэгжүүлж байгаа гээд Үндсэн хуулиа дагаж мөрдсөөр хүрсэн ололт амжилт чамгүй. Одоогоос 10 шахам жилийн өмнө Жак Уэтэрфорд абугай "Монголын ард түмэн өнөөдөр нийгэм –эдийн засгийн аугаа их өөрчлөлтийн гараан дээр зогсож байна. Амьдрал өдрөөс өдөрт өөрчлөгдөн хөгжихийн хэрээр хүмүүс ч бас

хөгжиж байна. Монголчууд эдийн засгийн томоохон орон зай болж эхлэхийн дээр даян дэлхийн ойрх ирээдүйд чухал үүрэг гүйцэтгэгч улс болон өөрчлөгдөж байна" хэмээн чин сэтгэлийн угаасаа их л бэлэг дэмбэрэлтэй айлтгал хэлжээ. Бидний монголчууд ардчиллын их давалгаанд хөлөө олж төр, улсынхаа тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхийн төлөө эрх чөлөөтэй сэтгэл хангалуун аж төрөхийн төлөө ихэд чармайж өөрсдөө сонгож Үндсэн Хуулиараа баталгаажуулсан замаараа эргэлт буцалтгүйгээр урагшилсаар авай. Өнгөрч буй он жилүүдээсээ, урагшлахад маань учирч буй хүндрэл бэрхшээлээс, алдаа онооноосоо, Монголчууд бид ихээхэн сургамж авч байна. Энэ хорвоод төгс төгөлдөрийг олсон зүйл тун ховор билээ. Түүний дотор төгс төгөлдөр хууль гэж үгүй. Үндсэн Хуулинд маань ч засч залруулах, сайжруулах зүйл чамгүй, үүний сацуугаар Үндсэн Хуулийн маань өөрийнх нь дархлаа сулыг ч ухаарч мэдэрч буй нь бас нэгэн сургамж болой.

Монгол орноо хөгжүүлж, хүн амаа өсгөж, чадавхжуулж байж улс орны үндэсний аюулгүй байдлын дархлаа сайжирна. Энэ жил, ирэх нэг хоёр жилээс шууд нүүр тулж буй өрийн дарамтаас эхлээд тохиож мэдэх бүх хүндрэл, бэрхшээлийг даван туулах чадавхыг бүрдүүлэх, хөгжлийн зөв үндэс суурийг тавих, эдийн засаг нийгмийн хөгжилд төрийн тогтолцоо нь саатуулагч хүчин зүйл болох бус харин ч эдийн засгийн хүндрэлийн намгаас улс орноо авч гарах төрийн зөв тогтолцоог



бэхжүүлж өгөх шаардлагатай байна. Иймд парламент, Засгийн газрын хоорондын харилцааны зөв тэнцвэр, хяналтыг бий болгох шаардлагатай.

Би бээр энэ удаад Үндсэн Хуулийн юуг нь шинэчлэх, юунд нь гар хүрэхийг цээрлэх тухай давтан ярих гээгүй. Би энэ асуудалд туйлын хянуур, нямбай, ёстой л "долоо хэмжиж ..." гэсэн логикоор хандах учиртайг дуулгасаар л яваа нэгэн. Учир нь Үндсэн хуулийн үг, өгүүлбэр бүхэн нарийн уялдаа холбоотой, цаад утгаараа Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхтэй холбоотой байдаг.

Засаж залруулах, шинэчлэхдээ Үндсэн Хуулийнхаа гол чиг шугам ноён нурууг нь эвдчихгүй юмсан, үзэл баримтлалаас нь няцахгүйгээр хичээх учиртай юмсан. Уг нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулинд /2010 оны/ энэ тухай тодорхой тусгахыг хичээцгээсэн л дээ. Үндсэн хуулийнхаа Монгол Улсын ардчилсан төрийн тогтолцоо, эдийн засгийн үндсийг тодорхойлсон, хүний эх, эрх чөлөөг баталгаажуулсан зүйл заалтуудад гар хүрэх учир шалтгаан байхгүй. Харин Үндсэн хуулиа төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын дагуу төрийн эрх мэдлийн салбарууд, /олон улсын хэлээр legislative, executive, judicial/ -ын харьцангуй бие даасан байдлыг бэхжүүлж Парламент /УИХ/ нь хууль тогтоох чиг үүргээ, Засгийн газар нь гүйцэтгэх чиг үүргээ холилдон хутгалдалгүй хэрэгжүүлдэг болгох, шүүх эрх мэдлийн байгууллага /шүүхийн

/ хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, засаглалийн хэлбэрээ / Парламентын, Ерөнхийлөгчийн, холимог гэх мэт/ оновчтой тодорхой болгох, өөр хоорондоо хяналтын тогтолцоо механизмыг нарийвчлан тогтоох /тэгэхдээ бие даасан байдал ба төрийн нэгдмэл байдлын учир холбогдлыг нь алдагдуулахгүй байх/ нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах, иргэний нийгмийн оролцоо, хяналтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр хөгжүүлэх шаардлагатайг цөмөөрөө л ойлгож мэдэрч байх шиг байна.

Үүний хамт Үндсэн Хуулийнхаа үг өгүүлбэр, бүлэг зүйл заалт нэг бүрийн утга учрыг ухан ойлгож дээр дооргүй "хот хөдөөгүй" даган мөрдөх бүх нийтийн санаа зориг ч дутагдаж байна. Ойрын жишээ дурьдахад Үндсэн хууль руу хэрхэн улайран дайрч байгааг харж болно.

Үндсэн Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах /би халах солих тухай яриагүй/ нь хэн нэгний улс төрийн рейтинг /нэр төр байр суурь/-ээ өсгөх, эрх мэдэлд хүрэх зорилготой улс төрийн шоу, жүжиглэл байх учиргүй. Тийм аваас энэ бол гал голомтоороо тоглож буй хэрэг болно. Энэ бол зөвхөн төр мэдэж шийдэх бус харин ард түмнээ сонсож, ард түмнээсээ асууж, зөвшөөрүүлж шийдэх асуудал. Төр улсын маань тусгаар тогтнолын баталгаа нь болсон Үндсэн хуульд төр ёсоо бэхжүүлэхийн төлөө олноороо санаа зоригоо нэгтгэн хамтран зүтгэцгээе.

Сайн үйлс дэлгэртүгэй.



НИЙГМИЙН БАЙДАЛ, ТӨЛӨВ, ҮНДЭСНИЙ УХАМСАР, ЁС СУРТАХУУНЫ ШИНЭЧЛЭЛТИЙН ТУХАЙД



Доктор, профессор Н.Жалбажав

Монголын нийгмийн өнөөгийн төрх байдлыг их зохиолч Д.Нацагдоржийг дууриан дүрсэлбэл цагийн байдал ороо бусгаа, хүмүүсийн амьдрал эрээн бараан, хүмүүний явдал шалдар булдар ажгуу. Байдлыг харлуулах, сайныг үгүйсгэх өрөөсгөл санаа над үгүй.

Ардчилал дэлгэрч, монгол хүн өмчтэй болж, хүний эрх, эрх чөлөө баталгаажих үндэс тавигдаж, зах зээлийн харилцаа төлөвшин буй гээд сүүлийн жилүүдэд бидний ололт амжилт чамгүй. Үүнийг олон улсын хамтын нийгэмлэгт ч хүлээн зөвшөөрч төр, улсын маань нэр хүнд өсч байр суурь нь бэхжиж байна. Гэлээ ч бидний цөөн монголчууд нийгмийн хөгжлийн

эндэгдэл, завхралыг үтэр түргэнээр засч залруулан эрх чөлөөтэй, чинээлэг амьдралыг цогцлуулахаар нэгэн зэргээр зориглон хөдөлгөсний үр дүн ийнхүү нааштай хэдий ч санасандаа тэр бүр хүрсэнгүй. Дэлхий дахиныг удаа дараа нөмөрсөн эдийн засаг, нийгмийн хямрал, цаг уурын дулаарлаас үүдэлтэй экологийн доройтол, ган зудын хөнөөлт үр дагавар, төр засгийн бодлогын алдаа зэрэг хүнээс өөрөөс нь үл хамаарах, хамаарах хүндрэл бэрхшээлийн улмаас улс орны эдийн засаг нийгмийн тогтвортой хөгжилд хүрсэн нь үгүй, хүний эрх, эрх чөлөөний баталгаа төгс бүрдээгүй байна.

Үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, эдийн засгийн хараат бус байдал зэрэг Монгол Улсын үндэсний язгуур эрх ашигт уршиг тарьж мэдэх, улс орныхоо төлөө санаа тавьдаг шударга иргэн бүрийн сэтгэлийг эмзэглүүлсэн нарийн төвөгтэй асуудал шил шилээ харан ундарсаар л ... Байгалийн баялгаа жинхэнэ эзний ёсоор ариг гамтай, эх орныхоо хөгжил дэвшлийг хурдасгах, хүн ардынхаа аж амьдралыг өөд татахад зориулсан үр ашигтай ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн эмзэг байдлыг арилгах, дэд бүтцийг нь хөгжүүлэх (жишээ нь төмөр зам тавих) зэрэг улс орныхоо хөгжлийн хувь заяа, үндэсний аюулгүй байдлыг хөндсөн олон



чухал асуудалд төр, засаг, иргэний нийгмээрээ, нэгэн санаагаар хөдлөхийн оронд хэсэг бүлгээрээ талцан маргасаар цаг алдаж эдийн засаг нийгмийн хямралт байдал лавширсаар байна.

Санхүү эдийн засгийн олигархууд, гадаадын үндэстэн дамнасан бүлэглэлүүдийн нөлөө сүүдэр төрийн бодлогод тусч байгаа тухай ч ярьж бичих болов. Авлигатай тэмцэх, нийгмийн шударга ёсыг тогтоох, шударга шүүхийг төлөвшүүлэх, эрх зүйн шинэтгэл хийх тухай ихэд ярьж бас оролдсоор буй боловч алдаж онох хосолсоор ахиж дээрдсэн нь, олонд мэдрэгдсэн юм багатай хэвээрээ л байна. Энэ бүхэн Монгол Улсын иргэнийг төрөөс хөндийрүүлж, төр засагтаа итгэх итгэлийг сулруулж төрийн нэр хүнд унахад хүргэх нигууртай юм.

Нийгэм, эдийн засаг, улс төрийн энэхүү “шалдар булдар” байдал нийгмийн оюун санаа, иргэдийн ухамсар сэтгэлгээ, ёс суртахуунд хүндээр тусч нийгмээрээ бухимдсан, талцаж маргасан, уур уцаартай байна. Монгол хүний элгэн халуун эх оронч үзэл ухамсар, үндэсний бахархал бүүдгэрч буй тухай ч яриа гарах болов.

Энэ бүхэн үүнээс цааш уруудах газаргүйг нийтээрээ дээр доргүй, хот хөдөөгүй, шүүн тунгааж эрх биш ухаарч, санаа зоригоо нэгтгэж, оюун ухаанаа дайчлах цаг тулсныг хэлж буй хэрэг ээ. Монгол хүний ухамсар, ёс суртахууны хүч бүүр язгуурын мөн чанар, цаад утгаараа хүнд бэрх

цагт чангарч саадыг давах хүчин болдгийг монголын буурал түүх нотлоно. Монгол түмний оюуны энэ их хүчний эх ундарга нь юу вэ?

Хүн төрөлхтний өнөр бүл үндэстэн бүрийн өвөрмөц өнгө төрхийн цогц, зүйрлэвээс өнгө булаадан алаглах цэцгийн мандал мэт. Монголын иргэншил, соёл, ухамсар, ёс суртахуун өөрийн дахин давтагдашгүй, тансаг өнгө төрхөөрөө энэхүү мандлын нэгэн сор дээж нь билээ. Монгол ухамсар, ёс суртахуун бол талын эрэлхэг нүүдэлчдийн сэтгэлгээ бөлгөө. Уудам тэнэгэр нутагтаа өвсний соргог, усны тунгалгыг даган өөрийн эрхээр нүүдэллэн эрдэнэт мал сүргээ адуулан ирсэн нүүдэлчдийн сэтгэлгээ бол хөдөөгийн Пэрлээ абугайн тэмдэглэснээр “эрх чөлөөг эрхэмлэгч сэтгэлгээ мөн. Тал нутгийн эзэд үнэг шиг зусардаж явснаас баатарын ёсоор үхсэн дээр” гэж сэтгэдэг байжээ. Уртын сайхан дуу шигээ уужуу тайван монгол ухаан, эрс тэс, хатуу ширүүн байгаль эхтэйгээ дүйсэн тэсвэр тэвчээр, орчны хувьсал өөрчлөлтөд дасан зохицох чадвар нь ертөнцийн талыг мориноос буулгүй түвшитгэсэн эцэг дээдсийн маань ялагдашгүй хүч чадлын нэгэн ундарга нь болж иржээ.

Монгол ухамсар бол ёс суртахуунлаг ухамсар мөн. Академич С.Нарангэрэл монгол хүний ухамсар сэтгэлгээний цаад утгыг шударга ёс, эр зориг, үүрэг хариуцлага, жудаг, нинжин ба өрөвч сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр



тэвчээр, эе эв, өгөөмөр сэтгэл, холч ухааны сэтгэлгээ зэргээр тайлж энэ эрхэм нандин оюун ухаанаараа суут богд Чингис, түүний хойчийг залгамжлагчид “хорвоод ховор” удирдагч, цэргийн жанжид байж чадсаныг нь онцолсон байна. (С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир. УБ., 2014 он. I II бүлэг.)

Монгол хүний эрхэм нандин зан чанар, ёс суртахууны сайн сайхан бүхэн Чингис богдод шингэсэн нь түүнийг хорвоогийн ер бусын их хүмүүн болгожээ. Үүнийг монголын хийгээд ертөнцийн мэргэд хүлээн зөвшөөрдөг. Персийн түүхч Рашид ад дин “Судрын чуулган-даа” ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэхээр Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно. Орчлонгийн ихэс ч тэдэнд хишгээ хүртээж, дэлхийн хүн ам ч тэндээ наминчлан залбирсаар, урт удаан наслан, амьдралын сайн сайхан бүхнээр жаргах болно гэжээ. (Рашид ад дин, Судрын чуулган, УБ. 2002 он. I боть, 404 дэх талд). Чингис хаан Монгол баатарын гэр бүлд, монгол эхээс төрсөн эгэл жирийн монгол хүн байсан ч монгол хүний эрхэмсэг оршихуйн арга ухаанаараа, ёс суртахуунаараа зөвхөн өөрийн хаъяат нарын төдийгүй хорвоогийн арван зүгийн

түмэн хэлтнийг өөртөө соронзон мэт татаж нийт хүмүүнлэгийн оюун санааны үнэт өвийг үлдээжээ. Академич С.Нарангэрэл “Ёс суртахууны гэсгээл, байгаль дэлхийгээ хамгаалах, үр хүүхдээ сайн хүмүүн болгох, шүтлэг бишрэл ёс суртахуунаа хуулиар хамгаалах талаархи Чингис хааны билэг сургаалыг хүн төрөлхтөнд тустай хосгүй өв” хэмээжээ. (С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир; 2 дахь талд).

Эв зөийг хичээх нь Чингисийн Монголын ухамсар, ёс суртахууны охь дээжис нь байжээ. Монгол эх орон бол зуун зууны туршид оршихуйн орон зай, цаг хугацааны төлөө хувь заяагаа нэгтгэн мөнх тэнгэрийн хүчин дор аж төрж буй халх, буриад, дөрвөд, хасаг, уйгар, чантуу нарын арав гаруй үндэстэн ястны өлгий нутаг. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байж ариун гал голомтоо сахин хамгаалж чаддаг ард түмэн бөлгөө. Чингис богд

“Одтой тэнгэр орвож

Орчлон дэлхий хөрвөж

Орондоо унтах завгүй

Олзоллодон булаалдаж” байсан

монгол туургатны олон аймаг, угсаатныг нэгтгэн дэлхийн их гүрэн Их Монгол Улсын гал голомтыг бадраасан билээ. Тал хээр нутгийн овог аймгуудын олз омог, эрх мэдлийн төлөөх хатуу ширүүн тэмцэлд андын нөхөрлөлийн ач тус, атаа жетөө, урвах шарвахын горыг амсан нухлагдаж өссөн Тэмүүжинд эе зөийг хичээх нь яс маханд нь шингэсэн итгэл үнэмшил



болон төлөвшжээ. Бас түүний эе эвийн ухамсар, ёс суртахуунд нялх балчираасаа ой тойндоо шингээсэн Алун гуа эхийн домог, тал хээр нутагт өнө эртнээс тархсан үлгэр домог, туульс, онч мэргэн сургааль үгс ихэд нөлөөлжээ. Эе эвийн ухамсар, ёс суртахууны биелэл нь үндэсний эв нэгдэл болдог, харин үндэсний эв нэгдэл нь төр улсын хүчин чадлын эх сурвалж ажгуу. Хятад, Орос, Хорезм, Солонгос зэрэг олон улс орон Чингис хааны эрхшээлд орсон нь Персийн түүхч Жувейны "элдэв үл бүтэх амьтдаас болж дэлхий дахин далайн шуурга мэт оволзон бүхийд, ойр дөтийн хаад ноёдын биеэ тоосон, ихэмсэг зан хэрээс хэтрээд ирэх цагт ... бурхан Чингис хаанд сүр хүчийг соёрхон олгож ялалтын эзэн болгосон амой" (Дэлхийг дагуулагчийн түүх, 19 дэх тал) гэж бичжээ. Энэ сүр хүч нь эе эвийн ухамсар, ёс суртахуун болой. Тэр цагт цөөхөн Монголчууд мөнх тэнгэрийн хүчин дор эвлэлдэн нэгдэж нэгэн цул болж дэлхийн талыг байлдан дагуулжээ. Монгол хүний эе эвийн ёс суртахууны учир утгыг

Хоёр хүн эвтэй болбоос
Хорин хүрээ мэт бэх
Өнөр хүн эвгүй болбоос
Эвдэрхий хүрээ мэт хэврэг
Өнчин хүний элэг болох
Олон хүн эвгүй болбоос
Өөрцөг (зожиг хүн) хүний идэш болох" гэж

"Монголын Нууц Товчоо", "Оюунтүлхүүр" зэрэг сурвалжид тайлан өнөөг хүртэл мөрдөх авай. Монгол хэмээх нэрийн дор, нэгэн

дээвэр дор нэгэн зорилгын төлөө хувь заяагаа, эе эвийн хүчээ нэгэн Үндэсний зөвшилцлийн их гэрээ болох Ардчилсан Үндсэн хуулиа баталж эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулахаар зорин тэмцэж буй Монголын ард түмний сүүлийн хорь гаруй жилийн түүх ч үүний нэгэн нотолгоо юм. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байдаг, бас эвдрэлцэн тэмцэлдэж хэл амаа олохоо байж хэрүүл тэмцэлд автагдсаар бусдын идэш болж байсан гашуун сургамж ч бий.

Монгол ухамсар ёс суртахуун шударга ёсны ёс суртахуун юм.

Учир нь Монгол ёс суртахууны нандин чанарын тэргүүн зэрэгт шударга ёс тавигдсаар иржээ. Энэ бол монголын төр ёсны нандин уламжлал ажгуу. Үүнээс ухарвал "Шударга бус явдал газар авна. Хэн шударга бус үйлдлийг бусдаас ичгүүр сонжуургүйгээр үйлдэнэ, тэр нийгэм, төрд тэргүүлэх байр суурийг эзэлбэл улс гүрэн ямар болдог билээ? Дур зоргын авирлал газар авдаг. Эрээ цээргүй нь хийморт заларч, чадвартай нь хатавчинд суудаг. Ийм учраас Чингис хаан шударга хүнийг шударга бус хүний дээр, шударга бус хүнийг өөрийнх нь байх ёстой байранд нь тавьж чадаж байсан учраас хүмүүсийг соронзон мэт өөртөө татжээ" (С. Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун эрх зүйн шаштир. УБ., 2014, 30 дахь талд)

Төр иргэн болон иргэд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, аливаад хуульд, гагцхүү хуульд



захирагдах, йтөр нь иргэндээ эрх мэдэл, өмч хөрөнгө, гарал үүсэл, нас, хүйс, нийгэмд эзлэх байр суурь зэргээс үл хамааран алагчлалгүй хандах зарчмыг хэлбэрэлтгүй, баримтлах нь шударга ёсны үндэс нь болдог байна. Чингис хаанд хахууль өгч, эсхүл түүнээс зусардан бялдуучилж, дагалцаж өндөр албан тушаалд заларсан ноён, жанжин сайд нэгээхэн үгүй байсан нь богд эзний ялгуусан, сод удирдагчийн эрхэм шударга чанарыг илтгэн харуулсан хэрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх”, зорилго болон “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим (Монгол Улсын Үндсэн хуул. I бүлэг. 2 дахь заалт)” болох заалтууд нь шударга ёсыг чанд сахиж мөрдөх нь монголын төрийн ашид баримтлах учиртайн нэгэн илэрхийлэл нь юм.

Хууль журманд захирагдаж, төрөө дээдлэх нь хоёр мянга гаруй жилийн түүх уламжлалтай монголын төр ёсны нэг гол шинж, ноён нуруу нь болно. Үүнийг орчин цагийн хэлээр “хууль төрөө дээдлэхүй” гэнэ. Төрөө мөнх тэнгэрийн хүчний илэрхийлэл хэмээн үзэж төрийн хууль шийдэл нь гагцхүү талын нүүдэлчдийн амьдрал ахуйн бодит хэрэгцээ шаардлагаас урган гарсан, өөрөөр хэлбэл “жам ёсны” байх нь монголын хууль цаазын “амь бөхтэй”, урт настай байхын нэг эх сурвалж нь болж

иржээ. Чингис богдын “Их засаг” хууль эрин зууныг дамжин Юань гүрэн, улс төрийн бутрал задрал, Манжийн ноёрхол, Богд хаант төр, ардын засаг, ардчилсан Монгол Улсын үед ч төрийн хууль цаазын бодлогын нэгэн үндэс, ундарга нь болж байдгийн цаад учир нь монгол хүний амьдралын хэв маяг, ертөнцийг үзэхүй, ёс суртахуун, итгэл үнэмшлийг шингээж чадсан жинхэнэ жам ёсных байсанд нь оршино. Энд нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд хууль, төрөө дээдэлдэг нь зөвхөн монголынх гэвэл “Үндсэн хуульт ёс”-харийн юм гэсэнтэй агаар нэгэн болно. Үндсэн хуульт ёс, хууль дээдлэхүй нь хүн төрөлхтний эрх зүй, улс төрийн сэтгэлгээний нийтлэг үнэт зүйлс бөгөөд нэгэн юмны хоёр тал мэт салгашгүйг ойлголтууд юм. Учир нь нэгд Үндсэн хууль нь ардчилсан төрийн тогтолцооны эрх зүйн үндэс, суурь нь, бол “хууль дээдлэх ёсон бол засаг, төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга ухаан мөн” юм. (Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006 он. 150 дахь талд). Хоёрт Үндсэн хууль төр улсын гол хууль бөгөөд бусад бүх хууль түүнээс урган гардаг, түүнд нийцдэг байх зарчим үйлчилдэг учиртай. Б.Чимид багш үүнийг “Үндсэн хуульчилсан болон ердийн хуулиар үзэл зарчмыг нь гуйвуулахгүйгээр нарийвчлан тодруулах” шаардлагатай гэж томъёолоод “Монгол Усын хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагууд Үндсэн хуулиа дээдлэх шүтэх ёсыг “дээр доргүй”,



“хот хөдөөгүй” нийтээр хэвшүүлэхэд онцгой анхаарал тавьж, бүх талаас нь онц анхааралтай хандаж, энэ үйлсийг чиглүүлж байх нь “төрт ёс, хууль дээдлэх ёсны шаардлага мөн болов уу хэмээн үзнэ” гэжээ. (Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006. 149 дэх талд)

Хууль дээдлэхүйн дээд хязгаар, шалгуур нь Үндсэн хууль болох нь эндээс тодорхой байна. Үндсэн хууль жам ёсны байх, түүнийгээ бусад хууль батлан гаргах хийгээд гүйцтгэлийг нь хангах, хэрэглэхдээ нарийн чанд баримтлах нь ардчилсан эрх зүйт төр байгаагийн гол илрэл мөн гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг билээ. Ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь “Хууль дээдлэх ёс” (Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. 1 дүгээр зүйлийн 2 дах хэсэг) мөн гэж заажээ.

Монгол ухамсар, ёс суртахуун түүхийн хатуу ширүүн сорил, улс үндэснийхээ өгсөж уруудах нугачаат их замд хатуужсан, хэцүү бэрхийг ялах, бүтээн байгуулах нь их хүчийг шингээсэн ёс суртахуун юм.

Өнгөрсөн XX зуун бол монголчуудын амьдралын хэв маяг, аж төрөх арга ухаан, оюуны үнэт зүйлсийн баримжаа хэдэнтээ “хугарч”, “нугарсан” зуун байв. Эрин зууныг дамжин буянт мал сүргээ адуулж аж төрж ирсэн нүүдэлчдийн ертөнцийг үзэхүй нь нүгэлийг тэвчих, хүлцэнгүйг эрхэмлэх, хойтын буяныг хураах агуулга бүхий бурхан шашны сүсэг бишрэл байв. Тэр үед Монгол

Улсад нийгмийн хөдөлмөрийн хуваарь гэхээр юм бараг үгүй хүн амын дийлэнх нь мал маллан аж төрж байв. Сүм хийдийн санваартан хуваргууд, гол мөрний сав дагасан архаг, тархаг тариаланчид, жижиг гар урчууд, хотын наймаачид, борчуудыг эс тооцвол хүн амын бие даасан бүлэг давхарга гэхээр юмгүй байв. Нэг үгээр илэрхийлэхэд Монгол хүний оюуны ертөнц (ухамсар сэтгэлгээ)-ийн үндэс суурь нь нэгдмэл, цулыг нөхцөлдүүлсэн байв. Нэгэн хэв маягийн аж ахуй, аж төрөл (нүүдлийн мал аж ахуй), оршихуйн нэгэн орон зай-чулуурхаг хөрс шороотой (Төв азийн өндөрлөг) нутаг, эх газрын эрс тэс уур амьсгал, гадаад ертөнцөөс харьцангуй хязгаарлагдмал геополитикийн орчин, ертөнцийг үзэхүйн бараг (Хүн амын 90 шахам хувь нь бурхан шашинтан) л нэгэн чиг баримжаа нь эсгий туургатан нүүдэлчдийн оюун санааны “мах цусан” барилдлагааных нь нэгэн үндэс байв. Судлаач, нийтлэлч Баабар “Нүүдэлчдийн нийгэм бол хөдөлмөрийн хуваарьт хамгийн бага орсон орчин юм. Айл болгон айраг, тараг, мах, сүү, ноос ноолуур үйлдвэрлэдэг жижиг аж ахуй, эргэн тойрны хөршүүд нь яг ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг аж ахуй... нүүдэлчдийн дунд харилцан солилцоо бараг үл явагдана. Иймээс бүтээгдэхүүн солилцоо зөвхөн иргэншсэн өөр улс үндэстнүүдтэй хийгдэнэ. XVI зууны үеэс Монголд Төвдийн шашин нэвтэрснээр эхний хөдөлмөрийн хуваарь буй болж эхэлсэн байдаг... гэлээ ч хүн амын



90 гаруй хувь нүүдлийн мал аж ахуй эрхэлсээр байсан болохоор ХХ зууны дунд үе хүртэл нийгмийн хөдөлмөрийн нарийн хуваарьт орж чадаагүй нь явсан юм” гэжээ.

ХХ зууны эхнээс Монголчуудын амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн баримжаа, ухамсарт үндсэн өөрчлөлт гаргасан түүхэн үйл явдлууд болов. Юуны түрүүнд 1911, 1921 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал улс орны тусгаар тогтнолыг сэргээн тогтоох эхлэлийг тавив. Улмаар 1924 онд Монголын ардчилсан үзэлтнүүдийн хүч чармайлтын үр дүнд хамжлагат ёс, хаант засгийг халж Бүгд Найрамдах улсаа тунхаглаж анхдугаар Үндсэн хуулиа батлав. Гэвч Монголын тусгаар тогтнолын хувь заяа “хутганы ирэн” дээр л байв. Улс үндэстнүүд ертөнцийг хувааж эзэгнэх санаархал бүхий хүчнүүдийн тэмцлийн эргүүлэгт татагдан орсон тэр цаг үед Монгол мэт бага буурай улс үндэстэнд бие даан оршин тогтнох боломж тун тааруу байв.

Тухайн цаг дор монголын лидерүүд, улс орныг удирдах хүчин болсон МАН-ын сонголт нь Зөвлөлт Орос (Хожим ЗХУ)-ыг түших шийдэл байв. Түүхэн энэ сонголт оносон эсэхийг Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаажилт, олон зууны хоцрогдлыг туулсан хөгжил дэвшлийн зэрэгцээ большевикууд, коминтерний тулган хүлээлгэсэн коммунист үзэл суртал, 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн хар сүүдэр зэргийг түүхийн дэнсээ шүүх бизээ.

Нүүдэлчин монголчууд

хөрөнгөтний нийгмийг алгасан эв хамтыг байгуулах үзэл суртлыг баримтлах болсон нь түүхийн бас нэгэн хатуу сорил байв. Монголчуудын үндэсний ухамсар, бахархал, ёс заншил эв хамтын буюу нийтээр тэгш амьдран жаргах социалист болон пролетарийн интернационализмын үзэл суртлын дарамтан дор ихэд бүүдгэрэхэд хүрэв. Ардын ардчилсан төр ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийг зарлан тунхагласаар байсан ч тэдгээр нь хэлбэрийн төдий зүйл байв. БНМАУ-ын иргэнд үзэл бодол, амьдралын хэв маяг, баримжаалах үнэт зүйлсийг сонгох чөлөөт сонголт байсангүй. Түүнд өмчлөх эрх байсангүй.

Өмчгүй хүний эрх, эрх чөлөө бол савангийн хөөс лугаа хэврэг, Монгол хүний ухамсарт баталгаагүй, идэвхигүй, хүнийшсэн, амьдралын төлөө тэмцэх арга, ухаанаар хомс, бэлэнчлэх сэтгэлгээ давамгайлж байсан юм. Судлаач, профессор Б.Галиндэв, бидний хэлж заншсанаар хүнд сурталт захиргаадалтын үеийг “хүний мөн чанарт харш нийгэм” гээд эртний сэтгэгч Платон: “дарангуйллын үеийн хүний ёс суртахууныг өөрхийнхөө санаачлагаар ямар ч юм хийдэггүй байхаар аливаа хүний толгойг дасгах хэрэгтэй. Ажил явдал дээр ч, тэр ч атугай, тоглоомон дээр ч ялгаагүй. Дайны үед ч энх амгалан цагт ч хэн боловч хараа юугаа дарга руугаа хандуулж, түүнийг чин шударгаар дагавал зохино” гэсэнтэй ихэд дүйцүүлэн ишилжээ.



(Галиндэв. ХХ, ХХI зууны эхэн үеийн монголын нийгмийн ёс суртахууны төлөв байдал. Улаанбаатар. 2013 он. 141 дэх талд).

Гэлээ ч ХХ зууны түүхийн энэхүү нугачаат замд Монгол Улс, монголын ард түмний тусгаар тогтнол баталгаажин Монгол хүнд туурга тусгаар төр, улсынхаа эзэн байх ухамсар, үндэсний бахархалын үр хөврөл бүрдсэн билээ. Бид ахмад үеийнхээ хосгүй баатарлаг зориг тэвчээр ухаан, урсгасан хөлс цусных нь үнэ цэнэ болсон тусгаар тогтносон Монгол Улсыг хүлээн авсан юм. Ийм л хөрсөн дээр Монголын ардчиллын үзэл санаа, түгэн дэлгэрч эхэлсэн билээ. Эдүгээ ч социализмд ихэд идээшиж дассан Монгол түмэн ухамсрын төөрөгдлийн хүлээснээс ангижрах гэж ихэд чармайн зүтгэж байна. Хүний ухамсар сэтгэлгээг өөрчлөх нь хуучин тогтолцоог нураах, эдийн засгийн харилцааг халж солихоос хавьгүй хүнд хүчир асуудал.

Монгол Улс социализм байгуулах үзэл баримтлал, зорилгыг халж хүний нийгмийн жам ёсны хөгжлийн үнэт зүйл болох ардчилал, зах зээлийн харилцаа, хувийн өмч, хүний эрх, эрх чөлөөний замыг сонгосон, хүний амьжиргааны хэв маяг, үнэт зүйлсийн баримжаа өөрчлөгдсөн зэрэг нь оюун санаа, ухамсрын өөрчлөлтийн үндэс суурь нь болж байна. Монгол хүн өмчтэй болж, эрх, эрх чөлөө нь баталгаажин нийгэм, хамт олны төлөө гэсэн хүнийссэн сэтгэлгээ нь бодгальчилагдан нийгэмд

эзлэх байх суурь, амжиргааны нь чанар өөрөөс тань, өөрийн тань хүч хөдөлмөр, хичээл зүтгэл, авъяас билэгээс шалтгаална гэсэн өөриймсөг бодгаль шинжийг шингээн төлөвшиж буй нь энэ цаг үеийн сэтгэлгээний гол онцлог гэх үндэстэй байна.

Нэг үгээр хэлэхэд монгол хүнд өөртөө итгэх сэтгэлгээ төлөвшиж байна. Үүний зэрэгцээ нийгэмд социал шинэ бүтэц, давхаргажилт нийгмийн цоо шинэ нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Хувийн хэвшлийнхэн (эзэд ба хөлсний ажилчин, ажилтан нар), төрөл бүрийн менежерүүд, банк санхүүгийн эзэд зэрэг амьжиргааны чанар, нийгэмд эзлэх байр суурь, орлогын эх үүсвэрээрээ социализмын үеийн хөдөлмөрийн сэхээтэн, ажилчин ангиас эрс ялгарах социал бүлгүүд бий болов. Ажилгүйчүүд ядуучуудын бүхэн бүтэн арми бий болохын дээр нийгэмд улс төр, санхүү, эдийн засгийн олигархи буй болсон нь улс орны нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжил, аюулгүй байдалд төдий л таатай зүйл биш ээ. Хүн амын таван хувьд ч хүрэхгүй улс төр, санхүүгийн томоохон баячууд (олигархи)-ын гарт улс орны капитал хөрөнгийн 90 гаруй хувь нь төвлөрч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнх нь тэдний гарт байж тэдний эрх ашигт үйлчилж байна.

Хамгийн ноцтой зүйл бол үндэсний олигархууд гадны үндэстэн дамнасан том корпорациудтай үгсэн хуйвалдаж эх орынхоо байгалийн



баялгыг цөлмөх аюул нүүрлэх магадлалтай байна. Эд хөрөнгө, мэдээллийн эх сурвалжийг атгаж буй улс төр, санхүүгийн бүлэглэлүүд тэдний хоорондын ил далд өрсөлдөөн нийгмийн материал баялгийг шударга хуваарилах зарчмыг алдагдуулдаг, ардчилсан сонгуулийн тогтолцоо, иргэний сонгох, сонгогдох эрхийг зөрчих, улс төр, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах нигууртай. Монгол Улсын Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тогтвортой байдал, төрийн бодлогын залгамж чанар алдагдах, Оюу толгой, Таван толгой болон алтны шинэ уурхай (ноён уулын дэргэдэх), төмөр зам тойрсон зөрчил маргаан зэрэг нь ийм аюул Монголд бодитой нүүрлэн байгаагийн илрэл гэх үндэстэй байна.

Иргэний нийгмийн төлөвшил удаашралтай, иргэдийн нэлээд хэсэг (хүн амын бараг тал хувь)-ийн ядуу зүдүү амьдрал, эрх мэдэлгүй байдал, ажилгүйдэл, үнэн зөв мэдээллийн хомсдол, авлига нь олиграхуудын эрх мэдлийн төлөө тэмцлийн зэвсэг болох магадлалтайг эрдэмтэн мэргэд, судлаач нар анхааруулж сануулсан нь цөөнгүй. Бүр Рашид-ад-диний "Судрын чуулганд"... ихэс дээдэс нь албадууддаа ойр, элэгсэг дотно бус, өөрсдөөсөө гадна байгсдын зүрх сэтгэлийг татах гэж байхгүй, сайн бүхнийг ашиглаж байдаг хүмүүс улс орынхоо хүн амыг баяжуулдаггүй, түүнийг тэтгэж, дэмжлэггүй, ёс суртахуун, хууль, оюун билгийн бадрал болох байдлыг

тоомсорлодоггүй, ийм шалтгаанаар төр баригчид нь тэрслэгчид болдог тийм улс түүний гэрт нь нарыг хулгайч, худалч, дайсан, дээрэмчид халхална гэж бичжээ. (Рашид-Ад-Дин. Судрын чуулган. I боть. 404 дэх талд үзнэ үү). Утгын чимэг нь монголын өнөөгийн байдалд ихэд дүйж буйд санаа зовнихоос аргагүй. Олигархиудын өрсөлдөөний нэгэн хортой үр дагавар нь эрх баригчид улс төрчдөөс аваад эгэл жирийн иргэд хүртэл ихэд нутгархах болж буй хэрэг юм. "Тийм хүн", "ийм хүн", гэснэ үг яриа газар авах, эсхүл нутгархсан өнгө аястай улс төрийн бүлэглэлүүд (УИХ-д ч, улс төрийн нам дотор ч) үүсч буй тухай яриа олны дунд тарж байна. Сүүлийн жилүүдэд морь уралдуулах, бөхөө барилдуулахаасаа аваад зам гүүр барих, хот сууринг тохижуулах, төсөв хөрөнгө хуваарилахад хүртэл нуггийн хүчин зүйл ихэд нөлөөлөх болж болж тухай ярьж бичих болов. Ортой ч байж мэдэх бөгөөд сэрэмжилж сургамж болгомоор зүйл. Энэ бол улс үндэснийхээ эе эвийн сэтгэлгээ, ёс суртахууныг хордуулах, үндэсний эв нэгдэл ан цав үүсгэх уршигтай зүйл. Ерөөс зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, олон ургальч үзэл, нийгмийн соицал ялгарал гээд улс үндэсний эв нэгдэлд сөргөөр (муугаар) нөлөөлөх бодит хүчин зүйл цөөнгүйн дээр зуун зууны туршид төрийн "төмөр нударга"-н доор аж төрж, төрөө дээдлэх, төрд мэдүүлэх эрхэн дор идээшин дассан номхон хүлцэнгүй монголчууд төртэйгөө эрх тэгш, эн тэнцүү байх ардчилсан үзэл санаа, эрх чөлөөний



амт шимтэд автан согтуурах, дур зоргоор авирлахыг эрх чөлөө хэмээн эндүүрэх, удирдлага жолоодлогыг үгүйсгэх, сахилга зохион байгуулалт, дэг журам, хяналт шалгалтыг захиргаадалт хэмээн үгүйсгэх хандлага ч цухалзсаар буй. Энэ бол төр, нийгмийн удирдлагын нэр хүнд, хүч нөлөөг сулруулахад хүргэх ноцтой зүйл гэх үндэстэй юм. Төрд ч, иргэнд ч эрх эдлэхийн нөгөө тал нь үүргээ биелүүлэх ухамсар, ёс суртахуун, дадал нь ихэд дутагдаж байх шиг.

Үүрэг бол аливаа хүмүүний нийгэм, төр улс орныхоо төлөө, эцэг эх, төрөл садан, ах дүүс, анд нөхдийн төлөө, өөрийнхөө төлөө хийх ёстой үйлдэл мөн. Хүмүүний үйлдэл хуулийн дор, ёс суртахууны эрхэм чанарын дор болох ахул буяны (сайн) үйл болох бөгөөд агуулгыг нь үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, өвгөд хөгшид, ахас дээдэс, эцэг эхээ асран тэтгэх, хөдөлмөрлөх, хууль, дэг журам биелүүлэх, татвар гувчуур төлөх, эх орон, байгаль эхээ хайрлан хамгаалах гэж тодорхойлж болох байна.

Чингис богд “Ноёд түшмэд, цэрэг дайчид жич хөтөч зарц хүртэл тус тусын үүргээ гүйцэтгэж чадваас мөнх тэнгэрийн хүчинд их үйлс бүтээх ажгуу... (Чингис хааны товчоон., дэд дэвтэр, 397-398 дахь талд) гээд хаан хүмүүн хааны ёсоор, сайд хүмүүн сайдын ёсоор, эцэг хүн эцгийн ёсоор, хүү хүүгийн ёсоор байхыг тэр үүрэг гэж үздэг байжээ. (Күнз. “Шударга ном”. УБ., 2004 он. 117 дахь тал).

Төр, төрийн байгууллага, иүүний албан тушаалтан нар тэдгээрт хуулиар зөвшөөрсөн, үүрэг болгосон бүрийг ёс суртахууны эрхэм шаардлагын дор гүйцэтгэх, гүйцэлдүүлэх чадвар дадалтай болох ахул төр хүчтэй байх нэгэн чухал үндэс, суурь болой. Үүний сацуугаар иргэн бүр хуулийг сайтар мэдэж, хуулиар хориглож хязгаарлаагүй бүхэн түүний эрх ашигт үйлчилдгийг хууль ёсныхоо эрх ашиг, эрх, эрх чөлөөг хамгаалахад ашиглаж суралцах, дадал заншил болгох аваас төрийн албанд дур зоргоор авирлах, авлига хээл хахуульд өртөхөөс сэргийлж чадна. Эрх зүйт төрд иргэн бүр чиний эрх бусдын эрхээр, бас эх орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын эрх ашгаар хязгаарлагдах учиртайг ухаарвал зүг зүгтээ зүгэхийн гэм хор багасах, учир начиргүй хэрүүл тэмцэл намжихад ач тустай.

Ер нь зан заншил, ухамсар, ёс суртахуун нь өөлөх юмгүй үндэстэн гэж үгүй бизээ. Хүнийн нэг мөрөн дээр бурхан залардаг, нөгөө дээр нь буг чөтгөр шүглэсэн байдаг хэмээн ярьдаг шүү дээ. Удирдлага, жолоодлого сулрах, улс үндэстний лидерүүдийн нэр хүнд, нөлөө тааруухан, шударга ёс алдагдаад ирэхийн цагт нийгэмд хэрүүл маргаан, тэмцэл, залхуу хойрго, ховдог шунахай нь дэндээд ирдэг нигууртай бус уу. Цагийн байдал ороо бусгаа, хүмүүнлэг явдал шалдар булдар батгаагийн нэгэн учир шалтгааныг чухам эндээс хайвал зохистой мэт.



Эдүгээ бидний цөөн монголчуудад үндэсний ухамсар, ёс суртахуунаа ихэд хичээн дэлгэрүүлж, эе эвээ эрхэмлэн үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх нь хэзээ хэзээнээс илүүтэй, ёстой амин чухал үйл хэрэг болж байна. Иргэндээ, юуны өмнө залуустаа эх орноороо, туурга тусгаар төр улсаараа бахархан шударга, хүчтэй төрийнхөө ивээл доор, хуулийн хамгаалалтад хүний дайтай аж төрөх улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгтэй байна. Манай хойд их хөршийн нэгэн их соён гэгээрүүлэгч нэгэнтээ “бид юу хийх ёстой вэ?” гэж уулга алдсан нь бий. “Бид юу хийх вэ?” :

Нэгдүгээрт. Эрх зүйт төрөө бэхжүүлэх, нэр хүндийг өргөх нь энэ цаг үеийн хамгийн чухал зорилт мөн. Юуны өмнө Үндсэн хуулийг дээдлэх, хамгаалах бүх нийтийн санаа зоригийг төлөвшүүлэхийн хамт Үндсэн хууль жам ёсных байх шаардлага, төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалд яв цав нийцүүлэх (солих, өөрчлөх тухайд яриагүй), тухайлбал хууль тогтоогчид нь хууль тогтоогчоороо л байх, засгийн газар нь засгаараа л байх зарчмыг тууштай баримтлах, хоорондоо холилдож хутгалдах элдэв нүх сүвийг баттай хаах, шүүх, шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалах үндсэн хуулийнхаа хана хэрмийг улам бэхжүүлэх чиглэлд Үндсэн хуулиа хөгжүүлэх тухай ярьж байна.

Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны

үр нөлөө, цар хүрээ нь төрийн хүч, нэр хүндийн нэн чухал үндэс нь болой. Сүүлийн жилүүдэд мэдлэг, мэрэгшил ур чадвар, шударга ёс, хичээл зүтгэлд түшиглэсэн төрийн институтыг төлөвшүүлэх зорилготой төрийн албаны шинэчлэлийн тухай ярьсаар л .. Бодит байдалд энэхүү шинэчлэл, нам, улс төрийн бүлэглэлүүдийн нөлөө, байр суурь, рейтингийг л өргөх, бэхжүүлэхэд чиглэсэн улс төрийн шоу /түшиглэл/ болон хувирч байна гэхэд хэтрүүлэг болохгүй л болов уу. Засаг солигдмогц төрийн алба хохирдог нь гэм биш зан болов. Олигархууд улс төрчдийн нөлөө төрийн албаны бүхийл иерархийг /шатлалыг/ дээрээс нь доор нь хүртэл нэвт шувт тусч, хатуухан хэлэхэд, намууд, улс төрчдөд ил далд үйлчилдэг “ичих буйлчирхайгүй” зусар бялдууч, долигонуурууд төрийн албаны хоймор заларч, шударга ёс зөрчигдөх нь цөөнгүй. Амар хялбараар баяжих, хөрөнгөжих, эрх мэдэлд хүрэх шунахай сэдлээр төрийн албанд шургалах нь ч байна. Зарим улс төрчид ч өөрийнхаа болон намынхаа өмнө маршаашийг /сонгууль/ л бодон увайгүй аашлах нь энд тэнд цухалзсаар олныг бухимдуулж, нийгмийн ёс суртахууныг хордуулсаар л байна.

Төрийн зарим хүмүүний энэхүү шалдар булдар нь төрийн шударга, хичээнгүй албатын урмыг мохроож, хичээх зүтгэх, өсч хөгжих бүтээх гэсэн сэтгэлийн дөл рүү нь угаадас цацсан хэрэг бөгөөд төрийг хүчгүйдүүлэх, нэр хүндийг нь унагах,



олон түмнээс хөндийрүүлэхэд хүргэх уршиг тарьж байна. Учир иймд улс төрийн намууд боловсон хүчний сонголтод туйлаас хянуур нямбай хандах, төрийн хариуцлагатай албанд томилогдсон гишүүддээ намын явцуу эрх ашигт үйлчлэх дарамт шахалт үзүүлэхгүй болох, дур зоргоор адирласан нэгэнд нь хатуу хариуцлага хүлээлгэдэг байх нь төрийн албанд шударга ёсыг тогтооход үлэмж тустай бусуу. Нөгөө талаар сонгуулийн болон улс төрийн нам, төрийн албаны тухай хуулиудыг төрийн албыг улс төрийн нөлөөнөөс хамгаалах тогтолцоо, арга хэрэгслийг бүрдүүлэх, чиглэлд уялдаа холбоог нь сайжруулан шинэчлэх шаардлагатайг сануулж байна. “Дарин дээр давс” гэдэг шиг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага-засгийн газрын бүтэц, үйл ажиллагааны тогтвортой бус нь төрийн албаны төлөвшилд тус дэм болоогүй нь ойлгомжтой л доо.

Бас нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд бид уриа лоозон тавьж компаничилдаг социализмын үеийнхээ зуршлаас хараахан салаагүй л байх шиг. “Сайн засаглал”, “Ухаалаг төр”, “Институтын засаглал”, “Нээлттэй засаг” гэх мэт сайн зүйл сайхан санааг олж хардаг, хэрэгтэй чухлыг нь мэдэрдэг, зорилго зорилт болгон дэвшүүлдэг. Хэсэгтээ л шуугиж дээр доргүй л хөл хөөрцөг болцгоодог. Тэгсхийгээд намжсаар таг чиг болно. Хэн нэгний нэр хоч зүүсэн компани, улс төрийн шоу болоод л өнгөрөх нь цөөнгүй. Иймэрхүү байдал

төрийн нэр хүндэд л хортой. Нэгэнт санасан сэдсэн зүйл нийгмийн амьдралын хэвшил, дадал зуршил болтол нь тэмцэх тууштай байдал, төрийн бодлогын залгамж чанар, бүх нийтийн санаа зориг дутагдаж байна даа.

Төр өөрийн байгууллага, түүний албан тушаалтан нар тэдгээрт хуулиар зөвшөөрсөн, үүрэг болгосон бүрийг ёс суртахууны эрхэм шаардлагын дор гүйцэтгэх, гүйцэлдүүлэх чадвар дадалтай болох ахул төр хүчтэй байх нэгэн чухал үндэс, суурь болой. Үүний сацуугаар иргэн бүр хуулийг сайтар мэдэж, хуулиар хориглосон хязгаарлаагүй бүхэн түүний эрх ашигт үйлчилдгийг ухаарч хууль ёсныхоо эрх ашиг, эрх, эрх чөлөөг хамгаалахад ашиглаж суралцах, дадал заншил болгох аваас төрийн албанд дур зоргоор авирлах, авлига хээл хахуульд өртөхөөс сэргийлж чадна. Үүний сацуугаар эрх зүйт төрд иргэн бүр чиний эрх бусдын эрхээр, бас эх орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын эрх ашгаар хязгаарлагдах учиртай ухаарвал зүг зүгтээ зүтгэхийн гэм хор багасах, учир начиргүй хэрүүл тэмцэл намжихад тустай.

Хоёрдугаарт. Төрийн бүх хууль тогтоомж Үндсэн хуулийн үзэл санаа, нийгмийн амьдралын бодит хэрэгцээ, шаардлагаас ургасан, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий, давхардалгүй, элдэв онгорхой цоорхой, салаа утгагүй байхын зэрэгцээ хуулийг нэг мөр ойлгох,



хэлбэрэлтгүй дагаж мөрдүүлэх, хуулийг аливаа явцуу эрх ашиг сонирхлын үүднээс тайлбарладаг, мушгин гуйвуулахтай хатуу чанд тэмцэх тогтолцоо, механизмыг зүгшрүүлэх шаардлагатай. Ер нь улс төрчид, албан тушаалтнууд хуулийг буруу зөрүү тайлбарладаг, үзэл баримтлалыг нь мушгин гуйвуулдаг нь ёс зүйгүй хэрэг төдийгүй нийгмийн оюун санааг төөрөгдүүлсэн гэмт явдал шүү дээ.

Түүнчлэн сайтар шүүн тунгаасан, сайн хуулийг батлан гаргах нэг хэрэг, хуулийг сайтар сурталчлах, ухамсарлуулан ойлгуулах, гэхдээ зөвхөн үзэл баримтлалын хүрээнд ерөнхийлөх бус, бүр зүйл, заалт бүрээр нь тайлбарлах, хэрэгжүүлж хэвшүүлэхэд нь албан тушаалтан, иргэн бүрийн үүрэг, хариуцлагыг сайтар ухамсарлан ойлгуулахгүй, байнгын хяналтгүй орхивоос төдхөн мартагдах тийшээ болж Монголын хууль гурав хоног болох нь тэр. Мод, цэцэгсийн үрийг суулгаад орхичихтой л адил зүйл. Ухуулж ойлгуулах, итгүүлэх арга ухаан ч дутагдаж байна. Гэтэл бидний үлгэр дууриалал болгож буй барууны либерал ардчилсан үзэлтнүүд төрийн хууль, бодлогыг олон нийтэд ойлгуулах, сурталчилах, хэрэгжүүлж биелүүлэхийн төлөө бүх нийтийн санаа зорилгыг төлөвшүүлэх тогтолцоо механизм чухал болохыг ихэд ярьж бичиж байна. Энэ бол тэднийхээр, бас миний ойлгож буйгаар итгүүлэх ур ухаан ажгуу.

Гуравдугаарт. Монгол Улсын иргэн мансууруулах бодисыг

хэрэглэгч байснаа бүр үйлдвэрлэгч, тээвэрлэгч нь болж буй, Монгол Улсад хүний наймаа янз бүрийн хэлбэрээр илэрч эмэгтэйчүүд, хүүхдүүд хохирогч болсоор буй, гэр бүлийн хүчирхийлэл даамжирч байгаа, мөн Монгол Улсад санхүү-эдийн засгийн зохион байгуулалттай гэмт хэрэг өсч төрийн бодлогод гадны үндэстэн дамнасан бүлэглэлүүдийн ашиг сонирхлын нөлөө сүүдэр тусах магадлалтай болсон зэргийг харгалзан ийм төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх нь цаг үеийн нэгэн шаардлага болж байна. Монгол ухамсар, ёс суртахуун бол энэрэнгүй, нигүүлсэнгүйн ухамсар сэтгэлгээ бөгөөд монголын төрийн хуулийн бодлогод ч монгол ухамсар, ёс суртахууны энэ нандин чанар шингэх учиртай л даа. Гэхдээ “хорыг хороор” хэмээх мэргэн үг сургаал бий. “Хорт мууг сайтар засаж хотол улсыг хичээн хамгаалагтун” гэсэн суут богдын сургаал ч бий. Иргэн, нийгэм төрийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөнд, тэр тусмаа хүний амьд явах эрхэд заналхийлсэн, дээрхи төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх цээрлэл хатуу чанд, хэлбэрэлтгүй, элдэв өршөөл хөнгөлөлтгүй байх учиртай. Энэ бол нийт иргэн, нийгмээ гэмт явдлаас найдвартай хамгаалахад чиглэсэн төрийн бодлогын хүмүүнлэг, нигүүлсэнгүйн жинхэнэ илэрхийлэл юм.

Дөрөвдүгээрт. Хууль, шүүхийн шинэтгэл (шинэчлэл) зөвхөн хүний төлөө зориулагдах л учиртай. Түүнд



элдэв улс төрийн зорилго, шоу (жүжиглэл) байх учиргүй. Өнөөдөр Монгол Улсын иргэдийн дунд шүүхэд үл итгэх, учир утга багатай айдас ихтэй, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах процесст хүнд сурталд автсан хэвээр, шүүхийн зохион байгуулалт, байршил улам ч ойлгомж муутай, оновчгүй болсоор байгаа шүүмжлэл гарсаар л байна. Иргэд өргөдөл, гомдлоо шүүх, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээс айж бэргэж бас залхаж, төвөгшөөж байна.

Хууль, шүүхийн тогтолцоонд ч маргаантай асуудал цөөнгүй. Бидэнд Америкийн, өрнө дорнын туршлага, сургамж чухал байлгүй яахав. Бид бас үндэсний хууль цаазын, өөрийн их уламжлал, сургуультай (школа) улс. Бидэнд бас таван ханатаа барихдаа хүртэл гадны мэргэжилтнээр заалгах шахаж байсан сургамж буй. Одоо болохоор америкчлалыг тахиж, өрнө дорноос хуулж дууриасаар өөрийн гэх юмгүй, бас "эх газрын", аль эсхүл Англо-саксоныхуу гэдгийн учрыг олоход төвөгтэй болж байна. Засаж, залруудах зүйл энэ бусуу?

Тавдугаарт. Улс төр, ирэгний нийгмийн байгууллагуудын ардчилал, төрт ёсыг хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, үндэсний ухамсар, ёс суртахууныг төлөвшүүлэхэд үзүүлэх үүрэг, нөлөөг нэмэгдүүлэх нь цаг үеийн шаардлага болж байна. Иргэний нийгмийн байгууллага, улс төрийн намуудын төлөвшил удааширч төр, нийгмийн удирдлагад олон нийтийн

легитимчлэгдсэн, хууль ёсны оролцооны орон зай үүсч түүнийг туйлшрал, хэсэг бүлгийн явцуу ашиг сонирхлын элдэв туйлшралын зүйл дүүргэж мэдэх нь. Өнөөдөр улс төр, олигархи бүлэглэлийн ашиг сонирхлоос ангид хараат бус төрийн бус байгууллага хэр олон байна. Жинхэнэ чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллага байна уу? Үнэн зөв мэдээллийн ёс зүй гэж байна уу? Нийгэмд ард түмний нэр барьсан хэдий ч хэнийг төлөөлж буй, үйл ажиллагааны цаад зорилго зэрэг нь тодорхой бус, хүчирхийлэл (өлсгөлөн, тулган шаардалт г.м)-ыг арга барилаа болгосн хэсэг бүлэг олширч буйг хэлэхээс хулгах, эмзэглэх юмгүй. Энэ бол төр, нийгмийн удирдлагын нөлөө, нэр хүнд суларсных, төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, үйл ажиллагаанд шударга бус байдал, авлига газар авсных, шударга шүүхийн төлөвшил удааширсны уршиг. Энэ бол ардчилал, олон ургальч үзэл, нийгэм төрийн ардчилсан тогтолцооны нэн чухал субъект болох улс төрийн намуудын нөлөө нэр хүнд ихэд унасны гай гэвэл хэтрүүлэг болохгүй л болов уу. Иргэний нийгмийн институудын (юуны өмнө улс төрийн намуудын хууль эрх зүйн зохицуулалтыг иргэний ардчилсан нийгмийн шаардлагад нийцүүлэн шинэчлэхгүй бол уналт, ялзрал доройтол улам л лавширна. Иргэний нийгмийг олигархуудын нөлөөнөөс хамгаалах хууль эрх зүйн найдвартай хана хэрэм босгох хэрэгтэй байна. Улс төрийн намуудын гишүүнчлэл,



санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааны зорилго зорилт нарийн зохицуулагдсан, олон нийтэд ил тод байхаар зохицуулагдсан байх шаардлагатайг ярьсаар, цаг алдсаар байна. Монгол Улсын иргэн нийгэмд эзлэх байр суурь, хөрөнгө зорь, нас хүйс, гарал үүсэл зэргээсээ үл хамааран сонгох, сонгогдох эрхээ тэгш, шударгаар хэрэгжүүлэх, иргэн бүрийн санал, сонголт сонгууль, санал асуулгын үр дүнд нөлөөлдөг тийм л сонгуулийн хууль хэрэгтэй байна. Шударга сонгууль зөвхөн намуудын сонгууль байж таарахгүй, харин тэдний төлөвшлийн гол шүүлтүүр, шалгуур байх учиртай. Тэр утгаараа олон түмний итгэл хүлээж сонголтын нь босгыг даваагүй нам сонгуулийн дараа өөрөө тардаг нь иргэний ардчилсан нийгмийн дэг жаяг юм билээ. Энэ бол намын төлөвшилтийг “ташуурдах”, гэр бүлийн, жалга довын маягийн явцуу бүлэглэлийн наманцарууд олширохоос хамгаалах нэг л хэрэгсэл.

Зургаадугаарт. Үндэсний эе звийн ухамсар ёс суртахууны бат цул, нэгдмэл байх үндэс суурь, зарим талаар суларч олон ургальч үзэл дэлгэрч, нийгмийн социал ялгарал лавширч буй энэ цаг дор иргэний эх оронч үндэсний үзэл, бахархалыг хөгжөөн дэлгэрүүлэхийн ач холбогдол улам өсч буйг дурдах юун. Нийгэмд олон төрлийн шашин шүтлэг, ертөнцийг үзэхүй, дэлгэрч буй, дээр доргүй нутгархах нь газар авч буй, монгол хүн ихэд глобалчлагдан залуу үе

маань үндэсний зан заншил, соёлоо мартаж гээхэд хүрсэн гээд л олон хүн, эрдэмтэн судлаачид ярьж маргаж байна. Заримтай нь санаа нийлэх авч, зөрөх зүйл бас байна аа. Гэхдээ л энэ бол эх орныхоо хөгжил дэвшил, улс үндэснийхээ аюулгүй байдлын төлөө монгол хүний санаа зовнисны л илэрхийлэл билээ.

Маргах цэцэрхэх нь ихдэж, зохиогдож буй ажил арга хэмжээ маань нэг л түүхийн хоосон бардамнал, бэлэг тэмдгийн, найр наадмын шинж голлоод хүний ухамсар, ёс суртахуунд хүрч тусч ч буй нь ховор байх шиг. Энэ чухал ажилд үр дүнд суурилсан менежмент, хөрөнгө мөнгө босгох арга ухаан илүүтэй чухал байна. Идэвхи санаачлага гаргаж буй иргэд, бизнесийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудлад төрийн дэмжлэг, урам хэрэгтэй байна. UBS, Эх орон зэрэг телевизүүд, нийгмийн үүргээ ухамсарлаж боловсрол, үндэснийхээ соёл урлаг зан үйлийг хөгжүүлэх, залуу үеийнхээ авьяас билгийг нээн хөгжүүлэх үйлсэд хөрөнгө хүчээ зарж буй бизнесийн байгууллагууд олширсоор байна. Тэднээ урамшуулах дэмжлэг үзүүлцгээе.

Улс, эх орон маань хөгжил дэвшлийн нэн чухал цаг үеийг туулж байна. Ардчилсан, хүмүүнлэг иргэний нийгэм цогцлуулах үйлс түүхийн сорил, хүндрэл бэрхшээлийг туулан урагшилсаар авай. Бидний цөөн монголчууд эцэг дээдэс, эзэн богд Чингисээсээ өвлөсөн элгэн халуун эх оронч үзэл хүмүүжил,



эе эвийн ухамсар, ёс суртахуунтай ард түмэн билээ. Оюуны энэ их хүчээ нэгтгэн нэгэн зэрэг зориглон хөдөлбөөс зорьсон их хэрэг бүтэх нь эргэлзээгүй.

Ашигласан ном зохиол

1. Арне Мавлич. Үндсэн хуулийн хяналт. УБ. 2014 он
2. Батжаргал. Г. Нийгэм, улс төрийн сэтгэлгээний онолын асуудлууд. УБ. 2006 он
3. Галиндэв. Б. XX, XXI зууны эхэн үеийн монголын нийгмийн ёс суртахууны төлөв байдал. УБ. 2013 он
4. Лүндээжанцан. Д. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ. 2014 он /2 дахь хэвлэл/
5. Монголын нийгмийн өөрчлөлт. (ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ.2008 он)
6. Нарангэрэл. С. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир. УБ. 2014 он
7. Өнөрбаяр. Ч. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. УБ. 2014 он
8. Чимид. Б. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ. 2006 он
9. Шилжилтийн нийгэм: Шинэтгэл, соёл иргэншлийн (ОХУ-ын ШУА-ийн Социологийн Институт, Шихихутуг судалгааны төв) УБ. 2012 он
10. Эрдэмт. Ц. Төрийн тухайн монгол онол. УБ. 2002 он



МӨРДӨХ ЧИГ ҮҮРГИЙН АГУУЛГЫГ ШИНЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ



Доктор (Ph.D),
профессор Ж.Бямба

ЭБШ ажиллагааны чиг үүрэг нь тухайн эрх зүйн харилцааг ямар бүлд хамаарахыг тодорхойлон харуулахын зэрэгцээ зорилттойгоо ямагт уялдаж байдаг. Гарсан гэмт хэрэг бүрийг бүрэн илрүүлэх, өдүүлсэн этгээдийг илчлэн гэм буруутай эсэхийг тогтоох, улмаар шүүхээр хэлэлцүүлж эрүүгийн хариуцлага оноох эсэхийг шийдвэрлэх нь ямар ч нийгэмд ЭБШ ажиллагааны үндсэн зорилт болж байдаг учраас чухамдаа чиг үүргүүд (функци) түүнд л бүрнээ үйлчлэх учиртай.

ЭБШ ажиллагааны чиг үүргийн талаар ОХУ-ын эрдэмтэн Лупинская А.П., АНУ-ын судлаач Брэдлей. М.,

ХБНГУ-ын профессор Б.Шюнемани болон доктор Д.Баярсайхан¹ нар ном, бүтээлдээ нэлээд тодорхой тусгажээ.

Үндсэндээ, тэд уг ойлголтыг 3-22 янзаар ангилж системчлэн авч үзсэн байна. Ингэхдээ ямар ч тохиолдолд ЭБШ ажиллагааны яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх чиг үүргүүдийг бусдынхаа **суурь тулгуур нь мөн** гэж үзжээ. 70-80-аад оноос Ром-Германы гэгдэх эрх зүйн бүлд мөрдөх, мөрдөн мөшгөх гэсэн бие даасан ойлголтууд процессын бүхий л хэлбэрүүдэд гарч ирсэн нь "инквизици"-ийн гэгдэх төрийн эрх бүхий субъектүүд голлодог ажиллагаа "акусаци" буюу мэтгэлцүүлэн шийдвэрлэх процессын зарим хувилбарт байр сууриа тавьж өгөх болсны нэг илрэл биз.

Ялангуяа эрүүгийн мөрдөн мөшгөх онцлог ажиллагаа нь яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх гол тулгуур гэгдэх чиг үүргүүдийн **эхлэл үндсийг** тавигч хэмээн нэрлэгдэж улам бүр шийдвэрлэх ач холбогдолтой болсоор байна.

Ер нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны чиг үүргүүд, түүний дотор "мөрдөх" нь нотлох баримт

¹ Эрх зүй сэтгүүл. 2010 он. УБ., №1. Проф Б.Шюнеманий тавьсан илтгэлээс. Уголовно-процессуальное право, под.ред. Лупинской М. 2008 г. Стр 74-78; Criminal procedure a worldwide study, Second edition ... М. Bradley. Carlina press. 2004. P. 37-43. Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2014 он. 66-68 дахь тал.



бүрийг илрүүлэхийг гол зорилгоо болгосоор ирсэн. Тиймээс ч (аливаа баримт, мэдээллийг тухайн хэргийн бодит байдлыг тогтоох зорилгын үүднээс) яллаж зэмлэхээс гадна өмгөөлөн хамгаалах процесс ажиллагаа мөрдөн мөшгөлтийн үед явагдсаар л байдаг нь нууц биш.

Мөрдөн мөшгөх гэсэн субстанцын утга учрыг ойлгож мэдэх, онол, арга зүйн үндсийг тавихтай нягт уялдаж байр суурь нь улам бүр бэхжиж процессын шинжлэх ухааны бие даасан судлагдахуунд тооцогдох болов.

Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон мөрдөн мөшгөлт гэдэг ойлголт мөрдөн байцаалт, эрүүгийн эрэн сурвалжлах ажлын цогц шинжийг өөртөө агуулдаг бөгөөд зорилго нь эрүүгийн хэргийг илрүүлэх гэмт этгээдийг илчлэн гэм бурууг тогтоож, улмаар хөндлөнгийн, хараат бус шүүхэд

шийдвэрлүүлэхээр шилжүүлэн өгөхөд чиглэгддэг юм. Тийм учраас мөрдөлт, байцаалт хоёрын салгаж болдоггүйтэй нэгэн адил мөрдөн байцаалт, эрүүгийн эрэн сурвалжлах ажлыг (үйл ажиллагааны хувьд ч, удирдлага зохион байгуулалтын үүднээс) бие биеэс нь салангид авч үзэх боломжгүй.

Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т Цагдаагийн байгууллага хуулиар өөрт нь харъяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлгэж байгаа тухай хуулийн үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга, хэрэгслээр шалгах боломжгүй

/11.2.1/, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй /11.2.2/, энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1.5-д алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхит, мансууруулах бодис, түүх соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрх олох /11.2.5/... зэрэг тодорхой үндэслэлийн аль нэг нь байвал, мөн энэ хуулийн 11-р зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,4,5,6-д заасан үндэслэлээр Тагнуулын байгууллага эрэн сурвалжлах гүйцэтгэх ажил явуулах эрхийг тус тус эдэлж ирсэн.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба мөнхүү хуулийн 9 дүгээр зүйлийн 1.4-д заасан хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаалах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх үүднээс, Хилийн тагнуулын алба хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,5,6-д заасан үндэслэлээр, Авилгатай тэмцэх газар мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаар ЭБШ хуулиар харъяалуулсан хэрэгт энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,5,6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах гүйцэтгэх ажил тус тус явуулах эрхтэй гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, тагнуулын ба гүйцэтгэх, эрэн сурвалжлах зэрэг өөр өөрөөр нэрлэгдсэн зорилго нэгт



дээрх ажиллагаануудыг ноцтой гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлж, таслан зогсоох, зайлшгүй шаардлагатай мэдээллийг олж тогтоох, түүнийг зохих журмын дагуу бэхжүүлэхийн тулд явуулна. Улс төр, эрх мэдэлт олигархи бүлэглэлийн ивээлд багтан эрүүгийн хариуцлагаас зайлсхийхийг оролдсон бүлэг этгээдүүдийн хэд хэдэн ноцтой хэргийг шалгахдаа гүйцэтгэх ажлын мэдээ мэдээллийг үндэслэн прокурорын хяналтын дор эрүүгийн эрэн сурвалжлах ажиллагаа явуулж хангалттай баримт бүрдүүлж чадсан гэх зэрэг тодорхой жишээ олон бий. Тэр хэргийн талаар прокурор яллах дүгнэлтэндээ "... Нууц, далд аргаар илрүүлэх олж тогтоох чиглэлээр төрийн тусгай албадын хүчийг дайчилж ашигласан"² гэж жичлэн тэмдэглэж байсан бөгөөд тэр нь шүүхийн эцсийн шийдвэр гаргахад үнэмшихүйц үндэслэл болсон гэдэг.

Эрэн сурвалжлах чиглэлээр ил, далд аргаар явагддаг энэхүү ажиллагаанууд нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд, ихэнх тохиолдолд прокурорын хяналтын дор хэрэгждэг боловч тэнд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, зөрчих эрсдэл ихтэй, бас нийгэм, олон нийтийн хараа хяналтанд төдийлөн өртдөггүй, тэгээд ч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны, ялангуяа өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэх боломж, нөхцөл тун хязгаарлагдмал гэдгийг хэлэх нь зүйтэй.

² Е.Сэгсай. ГЕГ бол МАХН-ын саалийн үнээ биш. Зууны мэдээ, 2006.06.06, №24 болон Н.Энхбаяр нарын хэргийн талаар 2014 онд Үндэсний шуудан сонини №54,56 дугаарт өгсөн ярилцлагууд.

Ер нь, эрүүгийн мөрдөн мөшгөх ажиллагаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт голлох үүрэг гүйцэтгэдэг болох нь төвөггүй ойлгогдоно. Гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож, хэрэгт ач холбогдол бүхий баримт, сэлт, мэдээллийг цуглуулахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас явуулж буй ЭБШ тодорхой болон бусад ажиллагааг мөрдөн байцаалтын хэмээн нэрлэдэг³.

Мөрдөн байцаалт нь ЭБШ ажиллагааны зарчмуудыг ямар ч алагчлалгүйгээр чандлан баримтлахыг гол зорилго болгоно. Тийм боломж нөхцөл хэрэг дээрээ зөвхөн шүүхийн өмнөх шатанд л бүрдсэн байдаг юм.

Тухайлбал, Монголын эрүүгийн шүүн таслах ажиллагаа мэтгэлцэх зарчимд тулгуурлах дүрэмтэй бол яллах, өмгөөлөх талуудын маргаан мэтгэлцээний зүйлийг (объектыг) мөрдөн байцаалтын шатанд л тодорхойлон тогтоохоос өөр замгүй.

Энэ нь хүссэн, эс хүссэн ч ЭБШ хуулийн 16 дугаар зүйлийн дагуу хар цагаан баримтын аль алиных нь хойноос мөрдөн байцаагч уйгагүй хөөцөлдөх учиртайг харуулж байна.

Манай ЭБШ хуульд мөрдөн байцаах үйл ажиллагааны зайлшгүй баримтлах дүрэм журмыг тод томруун, ямарч эргэлзээгүйгээр тусгаж өгсөн эсэх нь эрдэмтэн судлаачид, практик ажилтны дунд маргаантай хэвээр байна.

"Шинжлэх ухаан техникийн хөгжлийн өнөө үед нийгмийн

³ Уголовный процесс. Под ред. Гученко. КФ. М. 2012г. с 236



харилцаа үргэлж өөрчлөгдөн урагшилж байдаг бөгөөд ямарч парламент төгс төгөлдөр, эргэлзээгүй хэрэглэх хууль гаргаж чадахгүй” гэж ХБНГУ профессор, МУИС-н хүндэт доктор Юрген Харбех онцолсон байдаг. Энэ нь бидний хувьд материаллаг буюу Эрүүгийн, Гүйцэтгэх ажлын, Прокуроын байгууллагын тухай хуулийн заалтууд ЭБШ эрх зүйн хэмжээний хөг аятай тэр бүр сайн нийцүүлээгүйг шуудхан хэлсэнтэй адил санагддаг.

Цөөн жишээгээр дээрх асуудлыг тусгайлан авч үзье.

Улсын мөрдөн байцаах газрын холбогдох хэлтэст төвлөрдөг мэдээнд хийсэн дүгнэлтээс үзэхэд ноцтой, ээдрээ төвөгтэй хэргүүдийг мөрдөн байцаах, эрүүгийн албадын нягт хамтын ажиллагаагүйгээр илрүүлэх, гэмт этгээдийг илчлэх хамтын үзүүлэлт тун чамлалттай хэвээр байгаа нь ажиглагддаг.

Гэтэл мөрдөн байцаагчид гүйцэтгэх ажлын хүч, арга хэрэгслийг дутуу үнэлж хүнд хэрэг үйлдсэн этгээдийг өнгөц ил аргаар (мөрдөлт, байцаалтыг хослолгүйгээр) шалгаж гэм бурууг хангалттай нотолж чадахгүй эцэс дүндээ мухардах явдал гарсаар байна.

Банк санхүү, газрын наймаа, авилга, албан тушаал, залилангийн улстөржсөн ноцтой гэмт үйлдлүүдийг өдүүлэгчид нь өндөр боловсрол мэдлэгээ буруугаар ашиглахад гаршсан, зохион байгуулалттай, өмгөөлөх бэлэн багтай, улс төржүүлэн хамгаалуулахдаа сүрхий

мэргэшсэн, орон гүрэн дамжсан, бас техник, технологийн өндөр түвшний тоноглол хэрэгслээр өвч зэвсэглэсэн тун айхтар этгээдүүд гэдэг нь ойлгомжтой.

Иймд хэргийн холбогдогчдыг мөрдөн байцаалт, эрүүгийн албадыг зөв хослуулан ашиглаж цаг хугацаатай өрсөлдөн оновчтой, зорилго нэгтэй баг бүрдүүлж шалгахгүй бол тэдний гэмт үйлдлийг таньж илрүүлэхэд төвөгтэй болжээ.

ЭБШ хуулийн 92.2-т заасны дагуу ... мөрдөн байцаагч нь ... гүйцэтгэх ажил эрхэлж байгаа байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримт, бусад баримт сэлтийг гаргуулах авах ... эрхтэй гэж заасан байдаг. Энэхүү мэдээ, мэдээллийг

- Эрүүгийн хэрэг үүсгэхэд үндэслэл болгох
- Эрүүгийн хэргийн нотолгоонд ашиглах
- Шүүх болон мөрдөн байцаах ажиллагааг явуулах, бэлтгэхэд хэрэглэх хэмээн үндсэнд хувааж болно.

ЭБШ хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3-д “эрүүгийн хэргийн талаар хуульд заасан нөхцөл журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт, сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ уг баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална” гэжээ.

Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн 23.3-д хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд эрх бүхий



байгууллагаас явуулсан гүйцэтгэх ажлын зарим ажиллагаанд прокурор зөвшөөрөл өгөхөөр заасан байдаг.

Дээр дурдсан хуулийн заалтуудаас учир зүйн дүгнэлт хийхэд анхны мэдээ шалгах, гүйцэтгэх ажлын хэрэг боловсруулах зэрэг ажиллагаануудаар олсон мэдээ, материал нь хичнээн үнэ цэнэ, ач холбогдолтой байсан ч, харамсалтай нь, нотлох баримтын хэмжээнд шууд үнэлэгдэх боломжгүй юм. Мөрдөлтөнд харьяалагдах учиртай гүйцэтгэх ажлын арга хэмжээний явцад нотлох процессыг хангах зорилгоор:

Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй бүхий гэмт хэрэг бүрийн бүрэлдэхүүний бүх элементийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах шаардлага тулгардаг.

ЭБШ болон бусад холбогдох хуулийн уялдаа, үйлчлэлд цуглуулж авсан тэрхүү мэдээ, мэдээлэл нь хуулийн эх сурвалжид заавал тусгагдах /бэхжигдсэн/ нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Тэгэхдээ ЭБШ ажиллагаан дахь нотолгооны болохуйц байдлын шалгуурыг хэзээ ч орхигдуулж болохгүй.

Мөрдөн байцаалт нь гүйцэтгэх засаглалын хүрээнд хэрэгждэг төрийн онцгой чиг үүрэг мөн. Эрх мэдэл хуваарилах хүрээнд субъектүүдийн хооронд тавигдах хяналтыг дур зоргын хэлбэрээс ангид байлгах учиртайг ЭБШ ажиллагаан дахь мөрдөн байцаагчийн эрх зүйн байдал харуулж байна. Манай ЭБШ хуулиар эрүү үүсэхээс татгалзах,

эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх зэрэг 20 шахам ажиллагааг 2002 оноос хойш мөрдөн байцаагч зөвхөн прокурорын /лиценз/ зөвшөөрлөөр явуулдаг үндэслэл юундаа байгааг судлаачид гайхашран сонирхдог юм.

Энэ нь эрүүгийн мөрдөн мөшгөх, улмаар яллах чигүүргийг прокурорын өдөр тутмын удирдлагын дор хамтдаа хэрэгжүүлдэг ром-германы нийтлэг жишгийг өнгөц харвал дагасан мэт боловч Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд заасан "хөндлөнгийн шинжтэй хяналт" маань, тэр тусмаа шүүх эрх мэдэл хэмээх бүлэгт багтсан мөнхүү үйл ажиллагаа нь гүйцэтгэх эрх мэдэлтэй байнга холилдон хорших учир шалтгаан нь юу вэ? гэсэн эргэлзээ тээнэглэлзэлийг төрүүлэхэд хүрнэ.

Эрдэмтэн мэргэд, улс төр судлаачид мөрдөх чиг үүргийг ихэд сонирхож түүнтэй холбоо бүхий олон янзын санал дэвшүүлж үзэл бодлоо илэрхийлсээр байна. Тухайлбал, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж, түүний судалгааны баг "Монгол улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь" (Бодлогын судалгааны тойм. 2010) бүтээлдээ "Эрүүгийн процессын хувьд яллагдагчийн өмгөөлөгч, гэрч (онцлов)" нотлох баримтыг цуглуулах, гаргах эрхгүй байгаагаас мэтгэлцэх нэг тал хэрэг дээрээ байхгүй байна" хэмээн дүгнэжээ. (үг бүтээлийн 75-р хуудас). Зөвхөн эндээс л гэхэд мөрдөх (байцаах бас орох биз) чиг



үүрэг бүхий хэд хэдэн асуудлууд хариулт шаардан хөндөгдөж байна. Тухайлбал, “нотлох баримт” гэсэн суурь ойлголтыг өнөө үйлчилж буй ЭБШ хуулиар тодорхойлох уу? Аль эсхүл хэрэгт ач холбогдолтой гэж ЭБШ ажиллагааны оролцогч, бусад оролцогч үзсэн баримт, сэлт, мэдээ бүхнийг түүнд хамааруулан авч үзэх үзэл баримтлалд тулгуурлах уу?

Нотлох баримт **цуглуулах** эрх, үүргийг ЭБШ ажиллагааг эрхлэн явуулагч нэр бүхий субъект л эдлэж биелүүлэх үү, аль эсхүл эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн хэн боловч хэрэгжүүлэх үү? (Ж нь: гэрч)

Дээрх хоёр асуудалтай холбогдуулж профессор Н.Лүндэндорж нарын онцолсон “нотлох баримт гаргаж өгөх эрх” нь (ЭБШ хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3, 36 дугаар зүйлийн 36.3.4, 41 дүгээр зүйлийн 41.3.2, 42 дугаар зүйлийн 42.2.3) ЭБШ хуульд тусгайлан заасан баримт, сэлт, мэдээ гаргаж өгөхөөс зарчмын эрс ялгаатай болох нь төвөггүй ойлгогдоно. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч, гэрч нь чухамдаа **яллагдагчийнх** учраас л нотлох баримт цуглуулах эрх эдлэх юм байна. Гэхдээ профессорын команд яллагдагчийн өмгөөлөгч, гэрч нар нотлох баримтыг **чухам яаж** (онцлов) цуглуулах вэ? гэдгийг тодорхойгүй орхигдуулсан мэт юм шиг санагдах юм. Ер нь яллах, өмгөөлөх, аль ч талын субъектэд процессын эрх хуульчлан олгохоос илүүтэй түүнийгээ хэрхэн эдлэх арга зам, нөхцөл боломжийг сайтар бүрдүүлж өгөх нь чухал.

Бас яллагдагчийн өмгөөлөгч,

гэрч бие дааж нотлох баримт цуглуулвал хохирогчийн өмгөөлөгч, гэрч нарт тийм эрх олгох уу? үгүй юу? гэдэг асуулт гарцаагүй тавигдаж таарна. Дашрамд дурдахад, аливаа гэрч нь эрх зүйн аль ч бүлийн процесс ажиллагаанд аль болохоор **хөндлөнгийн шинжтэй** байвал хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд эерэгээр нөлөөлдөг зүй тогтолтой.

ЭБШ ажиллагаанд оролцогчдын хүрээ хязгаар объектив, субъектив (магадлалын онолын үйлчлэл, бодит үнэнийг тогтоох тухай зарим эрдэмтдийн санал гэх мэт ойлголтууд энд орох биз) олон хүчин зүйлийн үүднээс улам олширч янз бүрийн мөрдөгчдийн эгнээ эрс өргөжиж ЭБШ ажиллагаанд зохицуулах боломжгүй “арми” бий болох вий дээ.

Манайд дагнасан мөрдөх албыг (урьдын мөрдөн байцаахаас ихээхэн өөр зорилго бүхий) бий болгох бодлого биелэгдэхийн даваан дээр зогссон. Уг нь тэр байгууллага дан ганц мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлэхнээ хэмээн эерэгээр ойлгогдож байснаа манайд “муу нэртэй луу данстай” байцаалтаас бүрмөсөн салах, зөвхөн “35 нас хүрээгүй цог золбоот” хүмүүсээр энэхүү албыг бүрдүүлэх, ингэхдээ “Оросод төгссөн” хүмүүсээс ангид байлгах гэх мэт улс төрийн үл ойлгогдох үзэлд автаж замдаа төөрөлдсөн нь харамсалтай. Тэр хуулийн төсөлд Эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр хүний эрхэнд халдах, мөрдөн мөшгөж болох зүйл заалт бүхий олон зохицуулалт орсон



нь судлаачдын дэмжлэг авахаас илүү түгшүүр төрүүлж байсныг нь тэмдэглэх нь зүйтэй биз.

Чухамдаа, мөрдөгч гэдэг маань хаана ямар сургууль төгссөн, онол, номыг чухам хэн зааснаас хамаарал багатай, амьдралын шалгуураар ихэвчлэн бэлтгэгддэг ур ухаан, авъяас, тэсвэр хатуужил, авхаалж самбаа шаардсан тун ноцтой мэргэшил. Бид үзэхдээ: одоогийн мөрдөн байцаах албаны мөрдөх чиг үүргийг онол, арга зүйн үүднээс оновчтой болгох асуудал юуны түрүүн тусгайлан тавигдах цаг болсон. Тухайлбал, эрүүгийн хэрэг өдүүлэгдэн гармагц мөрдөн байцаах албаны хүрээнд эхлээд яллах, дараа нь сэжигтэн тогтоогдсон үеэс цагаатгах, хөнгөрүүлэх бүхий л үйл баримтыг цуглуулдаг зэрэгцээ хоёр субъектыг **төрийн нэрийн өмнөөс** ажиллуулах нь зүйтэй санагддаг.

Энэ **хоёр мөрдөгчид** яллах, өмгөөлөх талынхан ЭБШ хуулийн хүрээнд бүхий л "нөлөөллөө үзүүлэх", хүсэлт гомдлоо шалгуулан шийдвэрлүүлж байх учиртай. Тэгээд ч өнөөгийн Үндсэн хуулийн үйлчлэлийн дагуу прокурор нь холбогдох хууль тогтоомжид заан тодорхойлсон **хяналтаа** тавьсаар байх боломж нь хэвээр үлдэнэ. Ингэснээр орчин цагийн чиг хандлагаас сүрхий гажих нь юу л бол. Манайд шүүхийн өмнөх

шатанд бүх хэргийн 2/3-ын хувь заяа шийдвэрлэгдэж байна. Чухам энэ ажиллагааг мэдэж зохицуулах эрх хэмжээтэй (прокурорын үйл ажиллагаанд "төвийг сахьсан") хяналтын тулгуур нь "хар цагааныг" зэрэгцүүлэн мөрдөх төрийн эрх бүхий байгууллагын цуглуулсан нотлох баримт болох биз! Түүгээр ч зогсохгүй ийм мөрдөх үйл ажиллагаа нь ЭБШ ажиллагааны бусад чиг үүргүүдийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх **эхлэл суурь** болох бүрэн үндэстэй.

Тэгэх аваас мөрдөх байгууллага нь яллах талын тууштай баримтласан процессын аливаа шийдвэр урьдчилан гаргадаг биш, нотлох баримтыг алагчлалгүй цуглуулдаг төрийн эрх, үүрэг бүхий субъект гэдгээ улам бүр харуулах ёстой.

Дашрамд дурдахад хар цагааныг алагчилгүй ялгах ихээхэн чухал үүрэг хүлээсэн мөрдөгчийн маань ажлын ачаалал дэндүү их, авдаг цалин нь шүүгчидтэй харьцуулахад 3 дахин бага. Тэгсэн атлаа эрх, үүргээ хэрэгжүүлэх боломж улам бүр бүдгэрч, дотоод итгэлд тулгуурлан явуулах үйл ажиллагаа нь хумигдах хандлагатай байгаа нь нууц биш гэдгийг төр засаг маань анхаарч шийдвэртэй арга хэмжээ авах цаг болсон. Ингэж чадваас мөрдөх **чиг үүрэг** жинхэнэ утгаараа нийгэмдээ үйлчлэх нөхцөл бүрдэх учиртай.



ОРГОН ЗАЙЛСАН ЯЛТАН , ЯЛЛАГДАГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ҮЙЛ ЯВЦ



Монгол улсын гавъяат хуульч, хууль зүйн ухааны доктор /Ph.D./
Р.Оюунбадам

Эрүүгийн хуулийн 262.1-д зааснаар таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн яллагдагч шүүгдэгч ялтан прокурорын хяналт шүүн цагдан хорих, хорих ангиас оргосон хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ. 261.2 хэргийг давтан буюу бүлэглэж түүнчлэн онц аюултай 2 гэмт хэрэгтэн үйлдсэн эсвэл харууд манаанд зэвсэг хүч хэрэглэж хорих ангийн барилга байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмжийг эвдэж оргосон бол таваас дээш арван таван жил хүртэл

хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан.

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэмт хэрэг үйлдэж гэм бурууг нь шүүхээр тогтоож, хорих ял оногдуулсан этгээдийн ялыг эдлүүлэх мөн шүүхийн өмнөх шатанд сэжигтэн яллагдагчийг цагдан хорих чиг үүргийг хэрэгжүүлдэг. ШШГБ-ын харьяа жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги гянданд баривчлах болон хорих ялыг албадан эдлүүлэх, ялтан яллагдагчийн аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журамыг сахиулах ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийн төрийн тусгай алба юм. Иймд дээр дурьдсан төрөл дэглэмийн хорих ангиас болон цагдан хорих төвүүдээс яллагдагч, ялтан оргон зайлах асуудлыг тус байгууллага онцгой учралын хэмжээнд үзэж нэн яаралтай түгшүүрийн байдалд шилжиж, шуурхай ажиллагаа зохион байгуулдаг юм. Учир нь оргон зайлсан яллагдагч, ялтан бусдын аюулгүй байдалд халдах, давтан гэмт хэрэг үйлдэх, хорлон сүйтгэх, галдан шатаах, тээврийн хэрэгсэл болон хүн барьцаалах зэрэг нийгэмд аюултай эрсдэл дагуулдаг. Өөрөөр хэлбэл замдаа таарсан бүхэнд хор аюул учруулах магадлалтай гэсэн үг. Яллагдагч, ялтан оргон зайлсан нөхцөлд:



- нэн даруй зарлан мэдээллэх,
- эрэн сурвалжлах,
- олж тогтоох,
- баривчлах зэрэг ажиллагааг зохион байгуулна.

Эдгээр цогц ажиллагааны дүнд аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж чадна.

Мөн оргон зайлсан яллагдагч, ялтаныг эрэн сурвалжлах ажиллагаа нь маш өргөн хүрээнд явагддаг бөгөөд их хэмжээний хүн хүч, хөдөлмөр, хөрөнгө мөнгө шаардагдсан ажиллагаа байдаг.

Энэ бүхэн хорих байгууллага, цагдаагийн байгууллага, тахарын албаны ажилтнуудын мэргэжлийн өндөр түвшинд хийгддэг онцгой ажиллагаа юм. Оргон зайлсан ялтан, яллагдагчийн хаана байгаа газрыг олж тогтоох, баривчлах ажиллагаа нь мөн адил өөр өөрийн онцлогтой мэргэжлийн ажиллагаа юм.

Энэ сэдвийн хүрээнд зөвхөн оргон зайлсан яллагдагч, ялтныг зарлан мэдээллэх үйл явцын тухай өгүүлэх болно.

Хорих анги болон цагдан хорих төвүүдээс оргон зайлсан яллагдагч, ялтныг хурдан шуурхай олж баривчлах нь зарлан мэдээллэх үйл явцаас шалтгаална. Хууль зөрчиж оргож яваа этгээд бусдыг амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх; иргэд байгууллагад хохирол учруулах, булаах, дээрэмдэх, хулгайлах, хүчиндэх зэрэг гэмт хэрэг үйлдэх галдан шатаах хорлон сүйтгэх тээврийн хэрэгсэл дайчлах, галт зэвсэг ашиглах хүн барьцаалах гэх мэт олон олон аюул учруулахад

хүргэдэг болохыг дээр дурьдсан билээ. Оргож яваа этгээдийн өөрийнх нь амь нас, эрүүл мэнд эрсдэлд орох магадлал өндөр байдаг тул оргосон этгээдыг эрсдэлээс хамгаалах шаардлагатай. ШШГ тухай Монгол улсын хууль; Монгол улсын Хууль зүйн сайдын 2013 оны А/76 дугаар тушаалаар батлагдсан хорих ангийн дотоод журам, хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтан хяналт тавих журам, чанга онцгой гяндангийн дэглэмтэй хорих ангиудын гадна болон доторхи хамгаалалтыг зохион байгуулах журам, эрэн сурвалжлах ажлын заавар, галт зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэх заавар, Сэжигтэн, ялтан, яллагдагч оргохыг завдсан нөхцөлд гүйцэтгэх ажиллагааны заавар, тел-хяналтын систем дохиоллын ситемийг боловсронгуй болгох ялтан яллагдагчийг хуяглан хүргэх заавар гэх мэт хууль эрх зүйн актууд нь ялтан яллагдагчийг орлуулан алдахгүй байхад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтууд болно.

ОРГОН ЗАЙЛСАН ЯЛЛАГДАГЧ, ЯЛТНЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЛЭХ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тахарын албаны тухай хууль 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан ба энэ хууль батлагдсантай холбогдуулан дараах хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Монгол Улсын Шүүхийн тухай, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Монгол Улсын хилийн тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Цагдаагийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан



шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна. Эдгээрийг тус бүр нь товч авч үзье.

ШШГБ: Цагдан хоригдож байгаад оргосон ялтан, яллагдагчийг шуурхай зарлан мэдээлэх үүрэгтэй. Учир нь

- Хорих ангиудаас ялтныг оргуулах нөхцөл байдал үүсдэг.
- Яллагдагчийг аймаг нийслэлийн цагдан хорих төвүүдээс оргуулах нөхцөл нэгэн адил үүсдэг. Энэ үед Ялтан, яллагдагчийг оргуулан алдсан хорих анги, **"ЯА ХО"** нэртэй өөрийн санд цугларсан багц мэдээг зарлан мэдээлнэ. Зарлан мэдээлэх ажиллагаа дараах бүрэлдэхүүнтэй. Үүнд:
- Харуул хамгаалалтын тусгай гүйцэтгэх бүлэг түгшүүр авч ажилтнууд түргэн цугларна.
- ШШБГ мэдээллийн **"Яа хо"** сангаас аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хорих анги бусад салбарт 1-р лавлагаагаар мэдээллэнэ.
- 2-р лавлагаа гаргаж ажилтнуудад тараана.
- 3-р лавлагаа гаргаж олон нийтэд мэдээллэнэ.
- Тахарын албанд мэдээллэнэ.
- Цагдаагийн байгуулагад мэдээллэнэ.

ШШГБ-ын тусгай алба байгууллагын холбооны техник хэрэгслэлээр зарлан мэдээлэл авна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Тахарын албанд зарлан мэдээлэхдээ эрэн сурвалжлах лавлагааг холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ. Ялтан оргон зайлсан тохиолдолд тухайн хорих байгууллага Тахарын албанд нэн даруй мэдэгдэж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх эрхтэй.
- Галт зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэх заавар
- Сэжигтэн яллагдагч оргохыг завдсан нөхцөлд гүйцэтгэх ажиллагааны заавар

Тел-хяналтын систем дохиоллын системийг боловсронгуй болгох ялтан яллагдагчийг хуяглан хүргэх заавар гэх мэт хууль эрх зүйн заавар гэх мэт хууль эрх зүйн актууд нь ялтан яллагдагчийг оргуулан алдахгүй байхад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтууд орно.

Цагдаагийн албаны тухай хуульд:

- Эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар мэдээллийн сан үүсгэж ашиглах,
- Эрэн сурвалжлах, зарлан мэдээллийг нийт цагдаагийн албан хаагчдад хүргэх, эрэн сурвалжлах ажлыг тасралтгүй шуурхай явуулах, мэдээллийн нэгдсэн стандарт дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх, улсын хэмжээний зарлан мэдээллийн дүн мэдээ тайлан гаргах зорилгоор цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах **"ASAP"** сан үүсгэн ажиллаж



байна. Цагдаагийн Байгууллага нь зарлан мэдээлэх эрхийн дагуу мэдээлэх ажиллагааг явуулдаг.

- Хорих анги, цагдан хорих төвүүдээс оргосон ялтан, яллагдагч: гэрч хохирогч, гэр бүлийн гишүүд болон бусад хүн, байгууллагийг занал хийлэн оргосон байвал нэн даруй тахарт мэдээлнэ. Тахарын алба тэднийг хамгаалалтанд авна.
- Цагдаагийн байгууллага мэдээлэл авсан даруйдаа албаны шугамаар **ASAP** сангаас зарлан мэдээлэл явуулна. Шаардлагатай үед цагдаагийн хэвлэл, мэдээллээр зарлана.
- Шаардлагатай тохиолдолд эргүүлд явж буй албаныханд хэвлэл, мэдээлэл

Интернет, олон нийтийн самбар дээр мэдээлэх болон мэдээллийг олшруулан нийтэд тараана.

- Эрэн сурвалжлах **"ASAP"** сан нь цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд байршдаг бөгөөд нийт алба хаагчид өдөр тутам нэвтрэн орж тухайн сангаар дамжуулан улсын хэмжээнд явагдаж буй зарлан мэдээллүүдийг /фото зураг, дүрс бүхий бичлэг/ авч ашиглан ажиллаж байна. Гэмт хэрэг, захиргааны зөрчил, эрүүлжүүлэгдсэн хүн, судалгаа хяналт зэрэг нь дотоод бүртгэлийн санд мэдээлэл оруулахад **"ASAP"** сангийн мэдээлэлтэй давхар хайлт хийх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Цагдаагийн албаны 2010 онд гаргасан кодын номны зарлан мэдээлэх цагдаагийн байгууллага хариуцлагатай ирсэн мэдээллийг цагдаагийн бие бүрэлдэхүүндээ кодын номоор зарлан мэдээлнэ. Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн талаархи мэдээллийг 5412 маягаар **"ASAP"** санд оруулна. Мөн **"ASAP"** санд эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн оршин сууж байсан газрын хаяг байршлыг тогтоон мэдээлэл авагдана.

Цагдаагийн байгууллагын шуурхай ажиллагаа хангах өөр нэг хэрэгсэл бол замын цагдаагийн станцууд юм. Эдгээрийг замын цагдаагийн хар төхөөрөмж гэж нэрлэдэг.

- "Хар төхөөрөмж" сан нь ASAP сантай холбогдсон тусгай цонхны сүлжээ юм.
- Цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын алба нь: ноцтой гэмт хэргийн талаарх мэдээлэл авмагц, дарга нь цагдаагийн төв байгууллагын даргад нэн даруй мэдээлнэ. Хүнд хэрэгт сэжиглэгдсэн, давтан хэрэг үйлдсэн этгээд баривчлах, цагдан хорих байр, хорих газар, шүүхээс оргосон тухай гэмт хэргийн талаар цагдаагийн төв байгууллагад мэдээлнэ.

Цагдаагийн байгууллага нь мэдээллэхдээ:

- **ASAP** сангаараа мэдээллэнэ.
- Цагдаагийн Байгууллага нь



зарлан мэдээлэх эрхийн дагуу мэдээлэх ажиллагааг явуулдаг.

- Хорих ангиас оргосон ялтан, яллагдагч, гэрч, хохирогч, гэр бүлийн гишүүд болон бусад хүн, байгууллагийг занал хийлэн оргосон байвал нэн даруй тахарт мэдээлнэ
- Цагдаагийн байгууллага мэдээлэл авангуут албаны шугамаар ASAP сангаас зарлан мэдээлэл явуулна. Шаардлагатай үед цагдаагийн хэвлэл, мэдээллээр зарлана.
- Шаардлагатай тохиолдолд эргүүлд явж буй албаныханд хэвлэл, мэдээлэл
- Интернет олон нийтийн самбар дээр мэдээлэх болон мэдээллийг олшруулан нийтэд тараана.
- Мөн замын цагдаагийн станцаар мэдээллэнэ.
- Замын цагдаагийн газрын тусгай сан хар төхөөрөмж сангийн сүлжээгээр зарлан мэдээллэнэ.
- “Хар төхөөрөмж” сан нь ASAP сантай холбогдсон тусгай цонхны сүлжээ юм.

Шүүхэд шилжсэн яллагдагч оргон зайлсан нөхцөлд зарлан мэдээлэх процесс

- Мөрдөн байцаалтанд ирэхгүй утсаа салгаад хаягаа өөрчлөн алга болсон нөхцөлд цагдаагийн байгууллага зарлан мэдээлнэ.

- Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын шатанд оргон зайлсан этгээдийг цагдаагийн байгууллагань өөрийн эрхийн дагуу зарлан мэдээлнэ.
- Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нь алдсан хүнээ олох талаар өөрөө арга хэмжээ авч хөөцөлдөнө.
- Цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагийн албань: ноцтой гэмт хэргийн талаарх мэдээлэл авмагц, дарга нь цагдаагийн төв байгууллагийн даргад нэн дариу мэдээлнэ.
- Ноцтой мэдээлэл хүргэх

Замын цагдаагийн газрын тусгай сан болон хар төхөөрөмж сангийн сүлжээгээр зарлан мэдээллэнэ.

“Хар төхөөрөмж” сан нь ASAP сантай холбогдсон тусгай цонхны сүлжээ юм.

Цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагийн алба нь: ноцтой гэмт хэргийн талаарх мэдээлэл авмагц, дарга нь цагдаагийн төв байгууллагийн даргад нэн дариу мэдээлнэ. Онц хүнд хэрэгт сэжиглэгдсэн, давтан хэрэг үйлдсэн этгээд баривчлах, цагдан хорих байр, хорих газар, шүүхээс оргосон тухай гэмт хэргийн талаар цагдаагийн төв байгууллагад мэдээлнэ. Эрэн сурвалжлах “ASAP” сан нь цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд байршдаг бөгөөд нийт алба хаагчид өдөр тутам нэвтрэн орж тухайн сангаар дамжуулан улсын хэмжээнд явагдаж буй зарлан мэдээллүүдийг /фото



зураг, дүрс бүхий бичлэг/ авч ашиглан ажиллаж байна. Гэмт хэрэг, захиргааны зөрчил, эрүүлжүүлэгдсэн хүн, судалгаа хяналт зэрэг нь дотоод бүртгэлийн санд мэдээлэл оруулахад "ASAP" сангийн мэдээлэлтэй давхар хайлт хийх боломжийг бүрдүүлсэн байдаг..

"оргон зайлсан болон гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг эрэн сурвалжлах",

"хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн талаархи мэдээллийг 5412 маягтаар "ASAP" санд оруулна ",

"эрэн сурвалжлах "ASAP" сан "

"эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн оршин сууж байсан газрын хаяг байршлыг тогтооно" гэх мэт.

Тахарын албаны тухай хуульд:

- Оргон зайлсан яллагдагч ялтаныг эрэн сурвалжлах. Монгол Улсын шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, ялтан шилжүүлэх, яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх
- Оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр гэмт хэрэг хянан шийдвэрлэлтийг сайжруулна.
- Тахарын алба шүүгч, улсын ялагч, гэрч, хохирогчийг

хамгаалах зорилгоор оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

- Тахарын алба хаагч нь эрэн сурвалжлах ажиллагааны үед боомт, хилийн зурвас, гааль, төрийн тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэн ажиллах эрхтэй. Тахарын алба: ШШГБ-аас гүйцэтгэх албаны шугамаар гэрч хохирогч, шүүгч прокурорт заналхийлсэн талаар мэдээлэл авсан тохиолдолд тэдгээрт шууд мэдэгдэн хамгаалалтандаа авна.

- Тэднийг нэн даруй хамгаалах, хамгаалалтанд авах арга хэмжээг авна

- Мэдээлэл авангуут тахарын алба цагдаагийн байгууллагад мэдээлээх үүрэгтэй.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд:

тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, шүүх, шүүгч, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй байхаар холбогдох өөрчлөлт оруулсан,

Монгол улсын хилийн тухай хуульд:

- Шүүн таслах ажиллагаа болон хорих анги, цагдан хорих байрнаас оргон зайлж улсын хил нэвтрэхийг завдсан, эсхүл



нэвтэрсэн яллагдагч, ялтны талаарх мэдээлэл, лавлагааг тахарын албанд гаргаж өгөх, хамтран ажиллах,

- Хилийн бүс орчимд эрэн сурвалжлагдаж байгаа яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагаанд оролцох, хүн хүч, автомашин, техник хэрэгслээр хангах тухай өөрчлөлт орсон байна.

Оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагааны зарлан мэдээлэх үйл явц дахь хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоо ямар байгаагийн цөөн баримтаас дурьдвал

ШШГБ ын зарим удирдлагатай хийсэн ярилцлагаас \2014 оны 10 сарын 14 / ны өдөр / үзвэл

Одоогоор тахар болон цагдаагийн байгууллагатай Хөтөлбөр, мэдээлэл солилцох хамтын ажиллагааны гэрээ байдаг эсэх тодорхойгүй байгаа учраас хууль сахиулах байгууллагын босоо удирдлагын тогтолцооны улмаас эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх чиг үүрэг бүхий ажилтнууд хамтран ажиллаж мэдээлэл солилцох боломж зарим талаараа хязгаарлагдмал байдаг.

2014/07/03 цагдан хорих 461-р ангиас оргон зайлсан 2 яллагдагчийг эрэн сурвалжилсан практик ажиллагааны байдлаас харахад ШШГБ-ын эрэн сурвалжлах үүрэг авсан ажилтнууд мэдээлэхэд

авагдсан хаяг байршлыг шалгаад явсны дараа өмнө нь хойно нь Тахарын албаны ажилтнууд мөн. Уялдаа холбоо муутай байгааг харуулж байна. Ийм жишээ олныг дурьдаж болно.

Тахарын алба хэрэгцээтэй мэдээлэл олж чаддаг талаар бодит жишээ: 2014 оны 7 р сарын 3 нд цагдан хорих 461 р хорихоос оргосон 2 яллагдагчийг эрэн сурвалжлах ажиллагаанд ШШГГ, тахарын ерөнхий газар, цагдаагийн байгууллага хамтран ажилласан байдал.

- Хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцохдоо ихэвчлэн бичгээр харилцдаг.
- Харилцан дэмжлэг үзүүлэх хэлбэрүүд байна.

Тахарын албаны зарим удирдлагатай хийсэн ярилцлагаас

- Одоогоор дээрх 2 яллагдагчаас өөр оргон зайлсан ялтан, яллагдагчийн талаар төдийлөн мэдээлэл аваагүй байна
- Үйл ажиллагаа доголдолтой өнөөгийн түвшинд зарлан мэдээлэх техникийн нөхцөлд хүрч чадаагүй байна.
- Цагдаагийн албаны зарим удирдлагын ярилцлагаас
- Одоогоор Тахарын албыг сайн ойлгоогүй байна.

Одоогийн байдлаар :

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага "ЯА ХО" сан
- Цагдаагийн байгууллага "ASAP"



сан

- Замын цагдаагийн “Хар төхөөрөмжийг” **“ASAP”** зэрэг саналуудад тулгуурлаж
- Тахарын алба өөрийн гэсэн зарлан мэдээлэх сантай болох тэрхүү сангаа **“ASAP”** сантай холбох
- Улсын бүртгэл мэдээллийн санг **“ASAP”** сантай холбох
- Шүүх, прокурорын шугамаар өөр өөрийн гэсэн мэдээллээ **“ASAP”** сантай холбох. Энэ нь зөвхөн Эрүүгийн хэргийн журмаар биш ИХШХШХ, ЗХШХШХ-иудад 2013.07.05 Тахарын албаны хууль гарсантай холбоотойгоор өөрчлөлт орсон байдаг.
- ШШГБ, Цагдаагийн байгууллага, Тахарын албаны уялдаа холбоог сайжруулах

Зарлан мэдээлэх гэдэг нь: олон нийтийн газарт ил самбарт тавих радио, телевизор, сонин гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийлгэж байгаа нь нэг талаар учир дутагдалтай хуучин арга барил юм. Иймд хуулийн байгууллагууд нэгдсэн мэдээллийн сантай болсон нөхцөлд одоо хэрэгжүүлж байгаа мэдээллийн хэрэглээ улам боловсронгуй болгох. 2014 оны 2-р улиралд цагдан хорих 461-р хорих ангиас оргосон 2 яллагдаж орон даяар зарлагдаж бүтэн 3 сарын туршийн үйл ажиллагааг хүн бүхэн мэдэх нэг ил зарлан мэдээллийг энд жишээ болгов.

Эрэн сурвалжилж байна



Олон нийтэд зарлан мэдээлэх лавлагаа
Өлзий Амарбаясгалан /хоч Хаба, Дэлдээ/

Нас: 22 өндөр: 165см, Жин: 62кг

Содон шинж тэмдэг: Онигор нүдтэй, монхор хамартай, дэлдэн чихтэй, уруулын зүүн дээд талд жижиг хар мэнгэтэй, буржгар хар үстэй, зүүн гарын эрхий долоовор хурууны голд “А” үсэг шивээстэй. Дээрх хүн нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байхдаа цагдан хорих 461-р дүгээр ангиас оргон зайлсан тул эрэн сурвалжилж байна. Түүний галаарх мэдээлэл өгсөн хүнд 1.000.000 төгрөгийн шагнальтай. Мэдээллийн нууцыг чандлан хадгална.



Харилцах утасны дугааруудыг тэмдэглэсэн байв.



Энхсайханы Вантөмөр

Нас: 23, Өндөр: 175см, Жин: 65кг

Содон шинж тэмдэг: Өтгөн хар хөмсөгтэй, жартгар нүдтэй, барзгар бор царайтай, зүүн дал, баруун мөрөн дээрээ хээ шивээстэй, зүүн нүдний дор хацар дагасан цагаан сорвитой, баруун хөл, баруун хавиргаандаа сорвитой, онигор нүдтэй, баруун нүд хялардуу. Дээрх хүн нь бусдыг залилан мэхлэх, бусдын биед хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байхдаа цагдан хорих 461 дүгээр ангиас оргон зайлсан тул эрэн сурвалжилж байна. Түүний талаарх баттай мэдээлэл өгсөн хүнд 1.000.000

төгрөгийн шагналтай. Мэдээллийн нууцыг чандлан хадгална. Харилцах утасны дугааруудыг тэмдэглэсэн байв.

Энэ бүхнийг дүгнэн үзвэл: Оргон зайлсан ялтан, яллагдагчийг эрэн сурвалжлах ажиллагааны зарлан мэдээлэх эрх зүйн орчин бүрдсэн байна. Оргон зайлсан ялтан, яллагдагчийг эрэн сурвалжлах ажиллагааны зарлан мэдээлэх гэдэг нь маш их ач холбогдолтой шуурхай цаг хугацаа хэмнэсэн үйл явц болж байна. Иймд зарлан мэдээлэх үйл явцыг улам төгөлдөржүүлж хуулийн байгууллагуудын нэгдсэн сантай болох шаардлагатай байна. Тухайлбал: замын цагдаагийн "Хар төхөөрөмжийг" "ASAP" сантай холбож өгсөн нь мэдээллийн нэг цонхтой болсон шилдэг жишээн дээр тулгуурлаж ШШГБ-ын "ЯА ХО" санг "ASAP" сантай холбох, Тахарын алба өөрийн гэсэн зарлан мэдээлэх сантай болох тэрхүү сангаа "ASAP" сантай холбох шаардлагатай байна. Мөн улсын бүртгэл мэдээллийн санг "ASAP" сантай холбох зэрэг зохицуулалт байх шаардлагатай байна.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРИМ АСУУДАЛ



Хууль зүйн ухааны доктор(Ph.D) Ц. Доржням

Түлхүүр үг: гүйцэтгэх ажил, гүйцэтгэх ажлын арга хэмжээ, гүйцэтгэх ажлын үр дүн, эрүүгийн хэргийн нотлох баримт

Товч агуулга: Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэхэд гүйцэтгэх ажлын баримт, мэдээллийг ашиглах асуудлаар судлаачдын маргаан болон практикийн тулгамдсан асуудлыг хөндөхөд зориулагдсан болно.

Гэмт хэргийн нөхцөл байдал улам бүр хүндэрч байгаа өнөө үед нууц далд аргаар, зохион

байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэх, мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг бодитой тогтоох нь үндсэндээ гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиохгүй, түүний үр дүнг ашиглахгүйгээр боломжгүй юм. Монгол Улсад анх 1994 онд гүйцэтгэх ажлын мэдээ баримтыг нотлох баримтын эх сурвалж болохоор ЭБШ хууль (1963 он)-д нэмэлт өөрчлөлтөөр оруулж байсан бөгөөд одоогийн мөрдөж буй хуульд хэвээр мөрдөж байна.

Гүйцэтгэх ажлын үр дүнг эрүүгийн хэргийн нотолгоонд ашиглах асуудал нь онол, практикийн хувьд үргэлжийн маргааныг өрнүүлж ирсэн. Энэ нь гүйцэтгэх ажил нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад ихээхэн үүрэг гүйцэтгэх төдийгүй, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас эрх зүйн агуулгаараа эрс ялгаатай байдагтай холбоотой юм. Гүйцэтгэх ажил нь юуны өмнө байцаан шийтгэх ажиллагаанд хамаарахгүй бөгөөд гүйцэтгэх ажил явуулахад зөвхөн Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан зарчим, шаардлагуудыг мөрдлөг болгодог онцлогтой.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зааснаар эрүүгийн хэргийг нотлох ажиллагаа нь хэргийг хуулийн дагуу шударга, үндэслэлтэйгээр хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий



байдлыг тогтоохын тулд нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаанаас бүрддэг билээ.

Гүйцэтгэх ажлын үр дүнг ЭБША-нд ашиглах тухай асуудлыг хөндөхийн тулд гүйцэтгэх ажлын арга хэмжээ гэж юуг хэлэх, гүйцэтгэх ажлын үр дүн гэж юуг хэлэх талаар авч үзэх шаардлагатай юм. Одоогийн мөрдөгдөж буй Гүйцэтгэх ажлын тухай хуульд гүйцэтгэх ажлын үр дүнгийн талаар хууль зүйн тодорхойлолт өгөөгүй боловч гүйцэтгэх ажлын явцад авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоог зөвхөн үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн төрийн бодлого боловсруулах, тухайн байгууллагад хууль тогтоомжоор оногдуулсан үүргийг шийдвэрлэх, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох, Төрийн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан албан тушаалтнуудад танилцуулах зорилгоор ашиглана гэж заасан. Энэ нь гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах асуудлыг тагнуул, сөрөх тагнуул, эрүүгийн тагнах ажиллагааны (эрүүгийн гүйцэтгэх ажил) хүрээг бүхэлд хамруулан заасан нь тодорхой байна.

Гүйцэтгэх ажил буюу тагнах ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах, иргэний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгод чиглэгдсэн өөрийн гэсэн онцлогтой тул гүйцэтгэх ажлын

үр дүнгийн тухай ойлголт нь өргөн хүрээтэй ойлголт юм. Харин эрүүгийн гүйцэтгэх ажлын үүднээс авч үзвэл, гүйцэтгэх ажлын үр дүн гэж тодорхой гэмт этгээдийн нууц далдаар гэмт хэрэгт бэлтгэж, үйлдэж байгаа буюу үйлдсэн шинж тэмдгийн тухай, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан этгээдийн тухай гүйцэтгэх ажлын арга хэмжээний явцад олж авсан баримт, мэдээ гэж тодорхойлж болох юм. Гэхдээ зохиосон гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүн нь гол төлөв мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, урьдчилсан нөхцөл болж ашиглагддаг онцлогтой. Энэ талаар ОХУ-ын доктор Е.А.Доле "Гүйцэтгэх ажлын үр дүнг зөвхөн гэмт хэргийн нотлох баримт бий болох урьдчилсан нөхцөл болгон ашиглаж болох юм"¹, "Гүйцэтгэх ажлын үр дүн (гүйцэтгэх ажлын ач холбогдол бүхий мэдээ) нь гүйцэтгэх ажлын арга хэмжээний хүрээнд бүрэлдэн буй болдог. Гэхдээ энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь нотлох баримт биш юм. Эрүүгийн хэргийн нотлох баримт нь зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад л бүрэлдэх болно. Тиймээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хэлбэрийг гүйцэтгэх ажлын хэлбэрт

¹ Шамардин А.А К вопросу об использовании результатов оперативно-розыскной деятельности в доказывании. Труды Оренбургского института МПОА (выпуск 9) – Оренбург, 2008. С.342-356



шилжүүлэх боломжгүй”² юм. Хятадын эрдэмтэн Фан Чонг-и “... хэргийг нууцаар мөрдөн шалгах ажиллагаа нь илээр мөрдөн шалгах ажиллагаанд захирагдаж дутууг нь нөхдөг... хэргийг нууцаар мөрдөн шалгах ажиллагаа илээр мөрдөн шалгах ажиллагааны нэг тал нь болж нэгдүгээрх нь хоёрдугаардаа захирагдаж үйлчлэн мэдээ бэлтгэн замыг нь зааж өгдөг”³ гэсэн санал, дүгнэлтүүд нь үндэслэлтэй юм.

Гүйцэтгэх ажлын үр дүнгийн талаар манай эрдэмтэд, судлаачдын үзэл баримтлалыг судалж үзвэл хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан асан “Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлт нь нотлох баримтын эх сурвалжид хамруулж болох нотолгооны шинэ төрөл”⁴, доктор (Ph.D) Т.Оюунчимэг “Гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт сэлт нь гүйцэтгэх ажлын үр дүнгийн нэгээхэн хэсэг”⁵ гэж үздэг ба зарим судлаачид гүйцэтгэх ажлын үр дүн нь зөвхөн нотлох баримт бий болгох

урьдчилсан нөхцлийг бүрдүүлдэг гэсэн хандлагыг баримталж ирсэн.

Гүйцэтгэх ажлын шугамаар цуглуулсан мэдээ баримт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах нь зохистойг тодорхойлж, уг ажиллагааны үндэслэл болох бөгөөд ажиллагааг явуулах дэс дараалал, тактикийг тодорхойлох, мөрдөн байцаалтын хамгийн оновчтой аргачлалыг боловсруулахад тусалдаг.

Гүйцэтгэх ажлын үр дүнг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглах асуудлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох талаар заасан.

Дээрх хуулийн заалттай холбогдуулан доктор (Ph.D) Б.Баг-Эрдэнэ “Онцгой тохиолдолд гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ... ийм баримт сэлтийг шүүгдэгчийн гэм бурууг нотлох, эцсийн шийдвэр гаргахад бусад нотлох баримтын хамт үнэлнэ” гэж үзсэн байдаг.

Энэ асуудлаар доктор (Ph.D) Д.Зүмбэрэллхам “Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт, сэлтийг нотлох баримт гэж үнэлж болохоор

² Доля Е.А. О доказательствах, доказывании и использовании в доказывании результатов оперативно-розыскной деятельности по УПК РФ. Научно-практическая конференция «Правовая и криминалистическая оценки нового УПК РФ» // Государство и право. 2002. №10. С. 113.

³ Фанг Чонг-и. Коррупцын хэргийг нууцаар мөрдөн шалгах ба илрүүлэх ажиллагаа, нотолгоо болох үр дүн. Авилгатай тэмцэж байгаа гадаад орнуудын туршлага эмхэтгэл. 2000.УБ,29-30 дахь тал.

⁴ Жанцан С. Гүйцэтгэх ажлын явуулахтай холбоотой Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтуудын ЭБШЭЭ-ийн онолын үндэс, хэрэгжилтийн байдал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ.,2006 №4(18) 27 дахь тал

⁵ Оюунчимэг Т. Гүйцэтгэх ажлын үр дүнг үнэлэх асуудал. “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэл-1 УБ.,2013, 40 дэх тал



Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан нь нэг талаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мөн чанарыг эргэлзээтэй болгож, нөгөө талаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ил тод байдал, гүйцэтгэх ажлын нууцлалын эрх ашигт хохиролтойгоос гадна энэ хоёр ажиллагааны ялгаа зааг бүдгэрснээс ямар аюулд хүрч болдгийг хэлмэгдүүлэлтийн гашуун сургамж бидэнд сануулдаг”⁶ гэж онцлон тэмдэглэснийг анхаарууштай асуудал билээ.

Гүйцэтгэх ажлын шугамаар олсон мэдээ баримт нь эрүүгийн процессын хуульд заасан нөхцөл, журмын дагуу авагдаагүй бол нотлох баримт болохгүй. Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг шинжилбэл, эдгээр хууль нь аль алин нь гүйцэтгэх ажлын үр дүнг гэмт хэргийн нотлогоонд ашиглах боломжийг олгож байгаа боловч тэдгээрийг нотлох баримтын хэмжээнд ашиглах нь хязгаарлагдмал хүрээтэй болох нь ойлгогдож байна.

1997 онд батлагдсан Гүйцэтгэх ажлын тухай хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, шуудан харилцааг хянах, орон байр, барилга байгууламж, газар орон, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлд нууц үзлэг хийх, нууцаар ажиглалт явуулах, хяналтын худалдан авалт

хийх, нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах зэрэг гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиоход прокурорын зөвшөөрөл авахаар хуульчилсан. Мөн хуулийн заалтаас үзвэл хүн эх сурвалжийг гүйцэтгэх ажилд ашиглах эрх зүйн үндэслэлийг заасан байдаг. Гэтэл зарим гүйцэтгэх ажлын арга хэмжээг эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаас өмнө шаардлага гардаг, тийм практик байдаг нь прокурорын зөвшөөрөл, хяналтгүй явагдахад хүрдэг.

Харин ОХУ-ын Шуурхай эрэн сурвалжлах ажлын тухай хуульд дараах арга хэмжээг хуульчилсан байдаг Үүнд:

1. Гүйцэтгэх ажлын асуулга
2. Лавлагаа авах
3. Харьцуулсан шинжилгээнд дээж, загвар цуглуулах
4. Хяналтын худалдан авалт (зэсвэг галт хэрэгсэл, мансууруулах бодис, үнэт зүйлс зэргийг худалдан авах, солилцох, дэнчин тавих, түрээслэх хэлбэрээр)
5. Эд зүйл баримт бичиг шинжлэх
6. Нууцаар ажиглалт явуулах
7. Хүнийг нууцаар таниулах
8. Орон байр, барилга байгууламж, газар орон, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлд нууц үзлэг хийх
9. Шуудан харилцааг хянах
10. Утсан харилцааг нууцаар хянах
11. Гүйцэтгэх ажлын нэвтрэлт

⁶ Дам ишлэв. Бямбаа Ж. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онол, практикийн тулгамдсан асуудал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2003, №4(33), 31дэх тал



12. Хяналттай нийлүүлэлт (зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи мансууруулах бодисын эргэлт, түүх-соёлын үнэт зүйлс, үнэт металлын хууль бус наймаа). Энэ арга хэмжээг зохиоход НҮБ-ын конвенци гол эх сурвалж болдог.

13. Гүйцэтгэх ажлын туршилт

14. Холбоо, мэдээллийн сувгаас мэдээлэл олзворлох.

ХБНГУ, АНУ зэрэг зарим орнуудад Эрүүгийн процессын хуульд нууц далд үйлдэгдсэн гэмт хэрийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын ямар арга хэмжээг зохиох талаар хуульчилж өгсөн байдаг онцлогтой. Иймээс арга хэмжээний үр дүн нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглах боломжтой болдог байна.

Одоогийн мөрдөж буй Гүйцэтгэх ажлын тухай хуулийн заалтыг судалж үзвэл, гүйцэтгэх ажлын арга хэмжээг хэрэгжүүлэх дараах үндэслэл байна:

1. Эрүүгийн хэрэг үүсгэсэн материалтай байх
2. ҮАБ-д хор хохирол учруулах үйл явдал, гэмт үйлдлийн талаар мэдээлэл авагдсан байх
3. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдэж байгаа болон үйлдсэн гэмт хэргийн шинж тэмдгийн тухай мэдээлэл, эсхүл дээрх үйлдлийг хийж буй тодорхой этгээдийн тухай мэдээлэл байгаа, мөн эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл

хангалттай бус байх

4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс эсхүл ял эдлэхээс оргон зайлсан этгээдийн мэдээлэл авагдсан

5. Хэн нь тодорхойгүй үхдэл олдсон

6. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгавар (шалгаж буй хэргийн талаар).

Гүйцэтгэх ажлын үр дүнг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглахын тулд:

1. Гүйцэтгэх ажлын үр дүнг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд танилцуулах талаар Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хэм хэмжээг мөрдлөг болгох. Гүйцэтгэх ажлын үр дүнг танилцуулах нь одоогоор байгууллагын эрх зүйн актаар зохицуулагддаг.
2. Гүйцэтгэх ажлын мэдээ баримтыг олж авсан эх сурвалж нь хууль ёсны эсэхийг сайтар нягтлан шалгах
3. Гүйцэтгэх ажлын үр дүнг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглахын тулд нотлох баримтыг хэрхэн хэлбэршүүлэх журмыг тогтоосон байх шаардлагатай юм.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд гүйцэтгэх ажлын арга хэмжээнд оролцогчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй,



гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл, арга, ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл задрах бодит нөхцөл байдал үүсч болзошгүй тохиодолд гүйцэтгэх ажлын үр дүнгийн тухай мэдээ, баримт сэлтийг бусад байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхийг хориглосон. Энэ нь гүйцэтгэх ажил нууцлалын зарчимд үндэслэсэн байдгаараа байцаан шийтгэх ажиллагаанаас ялгаатайгаар тайлбарлагдана.

Дараах тохиолдолд гүйцэтгэх ажлын мэдээ, баримтыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад танилцуулж болох юм. Үүнд:

- Гүйцэтгэх ажлын материал нь эрүүгийн байцаан шийтгэх харилцаа үүсгэх үндэслэл болж байгаа өөрөөр хэлбэл, тодорхой нөхцөл байдалд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт танилцуулсан гүйцэтгэх ажлын мэдээ баримт нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болж байгаа, мөн байцаан шийтгэх ажиллагаанд бэлтгэх, түүнийг хэрэгжүүлэхэд болон нотлох баримтын хувьд ашиглагддаг.
- Гэмт хэргийн шинжтэй тодорхой үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэхэд гүйцэтгэх ажил, мөрдөн байцаах ажиллагаатай зэрэгцэн явагдаж байгаа. Энэ нөхцөлд гүйцэтгэх ажил эрхлэх байгууллага нь мөрдөн байцаах байгууллагад зөвхөн байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд бэлтгэх, хэрэгжүүлэхэд болон зарим

нотлох баримтын хувьд ашиглаж болох боломжтой гүйцэтгэх ажлын мэдээ баримтыг шилжүүлж болно.

Хэргийн нотлох баримтын ач холбогдол бүхий мэдээллийн эх сурвалж, эсхүл мэдээлэл тээгч эд зүйлийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын арга хэмжээ чухал ач холбогдолтой. Тухайлбал, гэмт хэргийн халдлагын зүйл, гэмт хэргийн замаар олсон орлого, эд зүйл, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг олж илрүүлэх нь тодорхой гэмт хэргийн зүйлчлэл төдийгүй нотлох баримтын ач холбогдолтой. Зохион байгуулалттай болон нуугдмал гэмт хэргийг гол төлөв гүйцэтгэх ажлын арга хэрэгслээр илрүүлдэг, ялангуяа тухайн гэмт хэргийн гэрч болзошгүй хүмүүс, хохирогчийг олж тогтооход гол үүрэг гүйцэтгэдэг. Зарим тохиолдолд гэмт хэргийн хохирогчийг тогтоох нь эрүүгийн хэрэг үүсгэхэд ач холбогдолтой байдаг. Мөн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагчийг тодорхойлсон бүхий л нөхцөл байдлыг судалж мэдэх нь гүйцэтгэх ажлын төдийгүй мөрдөн байцаалтын таамаглал дэвшүүлэх, байцаалтын тактик боловсруулах, мэдүүлгүүдийг үнэлэх, улмаар мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа явуулахад ач холбогдолтой.

Гүйцэтгэх ажлын эрх зүйн үүднээс авч үзвэл, гүйцэтгэх ажлын үр дүнг нотлох баримтын хэмжээнд ашиглахын тулд дараах нөхцлийг хангасан байх шаардлагатай : Үүнд:

1. Гүйцэтгэх ажлын үр дүн нь гүйцэтгэх ажлын хуульд заасан



гүйцэтгэх ажлын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад олж авсан байх.

2. Гүйцэтгэх ажлын арга хэмжээ нь эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохиогдсон байх.
3. Зохиосон гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүн нь гүйцэтгэх ажлын албан ёсны баримт бичигт тусгагдан бэхжсэн байх
4. Гүйцэтгэх ажлын үр дүн нь байцаан шийтгэх тодорхой ажиллагаагаар батлагдсан, бодит шинжтэй байх зэрэг нөхцөл бүрдсэн байх.

Хамгийн гол нь гүйцэтгэх ажлын баримт бичигт бэхжүүлсэн гүйцэтгэх ажлын үр дүн зөвхөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан байцаан шийтгэх ажиллагаа явуулсны эцэст хэрэг хянан шийдвэрлэхэд нотлох баримт баримтын хэмжээнд үнэлэгдэнэ гэж үзэх хандлага байдаг. Энэ нь зөвхөн нэг талыг барьсан хандлага юм. Гэхдээ гүйцэтгэх ажилд хууль ёсны байх зарчмыг үгүйсгэхгүйгээр тэмдэглэхэд, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэм хэмжээ нь эрүүгийн байцаан шийтгэх харилцааг зохицуулдаггүй. Иймээс зөвхөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан аргаар олж авсан мэдээ баримт нь нотлох баримт болохуйц байдлыг хангана гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Нотлох баримт болохуйц байдлын шаардлага нь зөвхөн гүйцэтгэх ажлын баримт бичиг,

эд мөрийн баримтаар бэхжсэн гүйцэтгэх ажлын үр дүнгийн хувьд тавигдаж болох юм. Тухайлбал, зарим үед шүүх, мөрдөн байцаалтын ажлын практикт хяналтын худалдан авалтын арга хэмжээний явцад иргэний хэрэгцээнээс хураан авсан эдийн мөрийн баримт болох эд зүйл, мансууруулах бодис нь тухайн арга хэмжээг явуулсан тогтоол нь эрх бүхий субъектээр батлагдсан нөхцөлд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх учиртай. Гүйцэтгэх ажлын арга хэмжээний явцад хэрэгт ач холбогдол бүхий эд зүйлийг илрүүлэх явдал багагүй гардаг. Эдгээр нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар эдийн мөрийн баримт хэмжээнд үнэлэгдэнэ.

Ялангуяа гүйцэтгэх ажлын үр дүнг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд танилцуулах, шилжүүлэхдээ мэдээллийн эх сурвалжийн аюулгүй байдлыг хангах шаардлагын үүднээс эх сурвалжийг нууцлах зарчмыг мөрдөх учиртай. ОХУ-ын судлаач М.Поляков, Р.Рыжков нар гүйцэтгэх ажилтантай нууцаар хамтран ажиллаж хэргийн тухай тодорхой мэдээлэл өгсөн хүний аюулгүй байдлыг хангах үүндээс түүний оронд гүйцэтгэх ажилтныг байцаах асуудлын талаар эрүүгийн байцаан шийтгэх хуульд зохицуулалт оруулах нь зүйтэй гэж үздэг. Тэдний үзлээр гүйцэтгэх ажилтанг хуурамч нотлох баримт бүрдүүлбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулах нь гүйцэтгэх ажлын мэдээ, баримтын үнэн зөв байдлын шалгах батлагаа нь болох ёстой ажээ.



Энэ нь гүйцэтгэх ажлын нууцлал, "мэдээлэгчийн" аюулгүй байдлыг хангах, гүйцэтгэх ажлын мэдээллийн үнэн зөвийг шалгахаасаа илүү гүйцэтгэх ажлын арга хэмжээг хариуцсан ажилтны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Гэхдээ гүйцэтгэх ажлын арга хэмжээнд оролцсон гүйцэтгэх ажилтан, "мэдээлэгч"-ийг онцгой тохиолдолд өөрийн нь зөвшөөрлөөр аюулгүй байдлыг сайтар хангасны үндсэн дээр шүүх хуралдаанд гэрчээр оролцуулах тохиолдол байхыг үгүйсгэх аргагүй билээ.

Ер нь цорын ганц гүйцэтгэх ажлын мэдээллээр хэн нэгнийг гэмт хэрэгт буруутган яллах нь хүнийг хилс хэрэгт хэлмэгдүүлэх аюултай. Иймээс гүйцэтгэх ажлын мэдээ баримтыг нотлох баримтын бусад эх сурвалжаар ил болгон гэмт хэргийн нотолгоонд ашиглах зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн хүнд болон зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах хүрээг өргөжүүлэх талаар зарим судлаачид санал бодлоо илэрхийлж ирснийг дэлхийн нийтийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн нийтлэг хандлагатай уялдуулан анхааралтай судалбал зохистой асуудал юм.

Дүгнэлт, санал:

1. Гүйцэтгэх ажлын үр дүн гэж юуг хэлэх, түүнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрхэн ашиглах асуудал онол, практикийн хувьд нь маргаантай

хэвээр, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалт нь өнөөгийн шаардлагыг төдийлэн хангаж чадахгүй байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинэчлэлттэй уялдуулан гүйцэтгэх ажлын үр дүнг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаад ашиглах зохицуулалтыг орчин үеийн олон улсын нийтлэг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай.

3. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд гүйцэтгэх ажлын буюу тагнах ажиллагааны үүрэг, ач холбогдол улам өсөн нэмэгдэж байгааг харгалзан хууль зүйн дээд сургуулиудад гүйцэтгэх ажлын эрх зүй хичээлийг судалдаг болох нь ирээдүйн хуульчдыг гүйцэтгэх ажлын эрх зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, эрүүгийн эрх зүй чиглэлээр мэргэшүүлэхэд чухал ач холбогдолтой байх болов уу.



ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА



Хууль зүйн ухааны
доктор(Ph.D) Ц. Эрдэнэболд

Дэлхийн Худалдааны Байгууллага /ДХБ/ нь үндэстэн хоорондын худалдааны дүрэм журмыг зохицуулагч олон улсын ганц байгууллага бөгөөд үндэстэн хоорондын худалдааны гол хэсэг болох худалдааны гэрээ хэлэлцээр хийхэд гарын үсэг зурах, хэлэлцэх, тэдгээр улс орны парламент хооронд худалдааны гэрээ хэлэлцээр хийхэд оршино.

ДХБ-ын гол зорилго нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэгч, экспортлогчид, импортлогчид болон тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааг холбоход дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь худалдааны аюулгүй байдал буюу өөрөөр хэлбэл, худалдааны урсгалыг саадгүй, аль болох чөлөөтэй нэвтрүүлэхэд оршдог юм. Мөн түүнчлэн, худалдааны гэрээг удирдан явуулах, хэлэлцээрийг шинэчилж өөрчлөх, маргааныг зохицуулах, үндэсний худалдааны бодлогод хариу дүн шинжилгээ хийх, олон улсын байгууллагууд техникийн дэмжлэг болон өөр бусад сургалтын хөтөлбөрүүдтэй хамтран худалдааны бодлогын асуудлаар хөгжиж буй улс орнуудыг дэмжих явдал юм. Олон улсын худалдааны хуулийн шинэчлэлт нь ДХБ-тай салшгүй холбоотой.

Өнөө үед, худалдааны мэргэжилтнүүд тулгарч буй төвөгтэй асуудлуудыг мэдээллийн арга замаар хязгаарлаж шийдвэрлэж байна. ДХБ-тай байнгын хамтран ажилладаг ХХҮБХ /Худалдаа Хөгжлийн Үндэсний Бага Хурал/, ОУХТөвд байдаг ДХБ-ын гишүүн 150 орон, тэдний хоёр талын үнэлгээний баримтаас мэдээлэл хайх боломжтой юм. Мөн өөр бусад орнуудад олон талын ашигтай үзүүлэлт байдгаас үүнд гаалийн үзүүлэлт, нэмэлт нөхцлүүд, болон олон улсын түвшинтэй адилтгамаар үзүүлэлтүүд багтдаг. Эдийн засгийн аргаар үнэ бүрдэлтийг ил гаргахын тулд голчлон экспортын зах зээл дэх нөхцлөөр зах зээлийн арга замыг нэмэгдүүлдэг байна.



Олон улсын худалдааны дэс дараалал, технологийн шинэчлэлтэй холбоотой худалдааны хууль шинэчлэл хийхэд чухал ач холбогдолтой. Яагаад гэдгийг тайлбарлаад зогсохгүй ашиг сонирхлын тэнцвэрт байдлын асуултууд гэх мэт дүгнэлт гаргахад юу дутаж байна гэдэг талаар олон судлаачид өөр өөрсдийн таамаглалуудыг гаргаж ирсэн.

Шинэчлэл дэх худалдааны нөлөө хамгийн доод тал нь гурван хэтийн төлөвийн үнэлэлт өгч болно.

Эхнийх нь Смит-Рикардогийн жишээ загвар. Энэ нь зах зээлүүд нээж, өрсөлдөөний гол хүчнүүд бүтээмж болон илүү сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмждэг байна. Өрсөлдөөн хүчтэй байх тусам зөвхөн дотоодын үйлдвэрлэгчид бус бусад улс орнуудын үйлдвэрлэгчид илүү олон шинэчлэл хийдэг.

Хоёрдугаарт, зах зээлд экспортлох найдвартай байдал нь өөрийн гэсэн шинэчлэл болон технологийн дэвшлийн урамшууллын системтэй болно. Дотоод зах зээл дэх өрсөлдөөн нь бүтээмж болон шинэчлэлийг авчрахаас гадна хүчин чадлын хувьд том, өрсөлдөх чадвартай зах зээлүүдийг илүү хөгжүүлнэ. Зах зээлд аюулгүй байдлыг хангасан зүй зохистой байх тусам бид экспортлогч үйлдвэрүүдийг илүү шинэ, боловсронгуй бүтээгдэхүүнүүд гаргана гэдэгт найдаж болно. Энэ нь худалдааны хориг саад тэглэсэн нөхцөлд (худалдааны

хуулиар хэрэгжиж, хүчин төгөлдөр болсон эд хөрөнгөөр дамжуулан тэр хэмжээгээр үлдэх) бүхэл бүтэн дэлхийн зах зээл, дэлхийн хэмжээний дээр дурдсан өрсөлдөөнд оролцогч талуудын давуу талуудтай цуг нэг зах зээл гэж тооцогдоно.

Гуравдугаарт, Олон Улсын Мөнгөний Сангийн Судалгаа худалдаа нь өөрийн өрсөлдөөний давуу талуудын технологийн шинэчлэл тусгай үүрэг хариуцлага бий болгодог гэдгийг харуулсан.

Смитийн зах зээл дэх үл үзэгдэгч гарын энгийн хээнцэр байдал түүний сайжруулалт хэд хэдэн үндэслэл, зах зээлд үндэслэсэн үнэнч байдлыг нууцалдаг байна. Бүтээгдэхүүнүүдийг өрсөлдүүлэхийн тулд эхлээд үйлдвэрлэх хэрэгтэй. Дотоод болон гадаад зах зээлд зориулан бүтээгдэхүүнүүдийг бөөнөөр үйлдвэрлэхэд үйлдвэрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болдог бөгөөд хэрвээ хөрөнгө оруулалт хийсэн бол түүний өмчлөлийг хамгаалах хэрэгтэй. Хамгийн эхэнд бүтээгдэхүүнүүдийг боловсронгуй болгох хэрэгтэй. Бүтээгдэхүүнийг удаан хугацааны их хэмжээний хөрөнгө оруулалтаар сайжруулж үйлдвэрлэхэд хөрөнгө оруулалтын цаг хугацаа, бүтээлч эрч хүчтэй үр ашгийг хуулбарлах болон хулгайлахаас хамгаалах чухал болж байна.

Нийгэмд өөрчлөлт шинэчлэлийн маш олон мод тарьж болох боловч модоо хайрлан хамгаалахгүйгээр үр жимс авах боломжгүй юм. Чөлөөтэй сэтгэж бодох эрх чөлөө, хийж бүтээх, худалдаж арилжих,



хэн нэгний хөдөлмөр болон уран сэтгэмжээр бүтсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх эрх нь эрч хүчтэй, шинэлэг үйлдвэрлэл, эцсийн үр дүндээ нийгмийн хэрэгцээг хангах боломжтой бүх нөхцөл байдлыг бий болгох найдвартай орчин юм.

Сэтгэж бодох, бүтээх, худалдах эрх чөлөө

Дэлхийн II дайнаас хойш дэлхийн худалдааны журам Ерөнхий тариф болон Худалдааны гэрээний дөрвөн үндсэн тулгуур болох дөрвөн тулгуур үзүүлэлтүүд дээр тулгуурлажээ. Энэхүү заалтууд нь Ерөнхий тариф болон Худалдааны гэрээний хамгийн чухал үүрэг даалгавар болон дэлхийн худалдааг удирдаж буй хууль дүрмийн гол зүйл болсон худалдааны эрх чөлөөг хангадаг.

Эдгээр заалтууд нь:

-Нэгдүгээр заалтын дагуу клубын гишүүн бүрт өгөх ёстой хөнгөлөлт нь клубын бүх гишүүдэд өгөгдөнө;

-Хоёрдугаар заалтанд дурдсанаар улс орон бүртэй хэлэлцэж тохирсон импортын бүтээгдэхүүнд оногдуулсан тарифыг хязгаарлах;

-Гуравдугаар заалтанд чухал бүтээгдэхүүнүүдийг ижил төстэй дотоодын бүтээгдэхүүн зохицуулалтын дүрэм журам, татварын дагуу авч үзэх;

-Арваннэгдүгээр заалт импортыг хязгаарлах арга хэмжээнүүдийг хориглох тухай асуудлуудыг тус тус тусгажээ.

Дэлхийн Худалдааны байгууллагын гэрээний үлдэгдэл хэсэг эдгээр үндсэн үүргүүдээс урган гарна. Өөр бусад олон гэрээнүүд үндсэн шаардлагуудын мөн чанарыг илэрхийлж, өөр бусад хэрэгсэл шаардахгүйгээр үндсэн эрх, үүргийг биелүүлэх дэглэм бий болгодог.
Жишээ нь:

1. Ижил төстэй заалтууд Үйлчилгээн дэх Худалдааны ерөнхий гэрээнд байдаг;
2. Худалдааны техникийн саад бэрхшээлийн гэрээ нь тариф болон Худалдааны ерөнхий гэрээний гуравдугаар зүйлд дурдагдсан дэг журмын тухай асуудлыг улам сайжруулсан;
3. Эрүүл ахуйн болон Эрүүлжүүлэх арга хэмжээний гэрээ нь 20-р зүйлийн заалтууд мөн Тариф болон Худалдааны ерөнхий гэрээний байгаль орчин, эрүүл мэндийн тайлбаруудыг илүү тодорхой болгож, өргөжүүлдэг;
4. Мөнгөн тэтгэмж болон Нөхөн төлбөрийн гэрээ нь худалдааны хэлбэр болон хөрөнгө оруулалтын шийдвэрийг гуйвуулах хүчин чадалтай тэтгэмжийн дэг журмыг бий болгох;
5. Тэтгэмжийн гэрээ болон Демпингийн эсрэг арга хэмжээний гэрээ нь нөөцийн өрсөлдөөнийг дэмждэг нөхөн төлөх, демпингийн эсрэг үүрэг ноогдуулдаг дүрэм журмыг бий болгодог.



6. Эдгээр дэг журмуудыг тогтоох гол зорилго нь олон улсын түвшинд их ч бага ч болсон худалдаа, үйлчилгээг чөлөөтэй худалдаалах оновчтой хүрээний үйл ажиллагааг хангах юм.

Хэн нэгний хөдөлмөр, уран сэтгэмжээр бүтсэн бүтээгдэхүүнээс таашаал авах эрх

Худалдаа хийх эрх чөлөө нь шаардлагатай зүйл боловч шинэчлэл хийхэд төдийлөн хангалттай бус. Хэрвээ титаны хайлшаар үйлдвэрлэсэн хулганы хавхыг бусад үйлдвэрлэгчид хууль ёсны дагуу бусад үйлдвэрлэж, эдгээр нь зах зээлд нийлүүлэгдмэгцээ борлуулагдаж байсан бол сая сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж байгаа Маустрап Интернэшнл компанид бага асуудал гарах байсан. Судалгаа болон хөгжилд их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг боловч зах зээлд нийлүүлэхэд олон жил шаарддаг бүтээгдэхүүнтэй холбоотойгоор нөхцөл байдал илүү хүндэрдэг.

Худалдааны саад бэрхшээлүүд арилахад бүтээгдэхүүнүүд зах зээлийн хооронд илүү чөлөөтэй байдаг нь хачирхмаар зүйл биш бөгөөд оюуны хөрөнгө олон улсын худалдааны хуулийн өсөн нэмэгдэж буй бүхэл хэсэг болсон. Энэхүү байдал нь Уругвайн Оюуны өмчийн худалдаатай холбоотой гэрээ,

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой хандлагуудын гэрээн дэх хамгийн сонирхолтой хууль ёсны шинэчлэлийг авч үзэх хэрэгтэй болж байна.

Дотоодын патентуудыг хамгаалах хамгийн гол шаардлагуудын үндсэн зарчмын болон оюуны өмчийн тухай ном төдийлөн байдаггүй.

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой хандлагуудын гэрээ нь газарзүйн зориулалтаар хувилах эрхээс эхлээд патентын эрх хүртэлх өргөн хүрээтэй дэг журмын асуудлуудыг хамаардаг.

Бидний зорилтонд хамгийн чухалд тооцогдох зүйлүүд нь:

1. Патентын эрх олгож болохуйц бүтээл, патент эзэмшигчийн эрх (нөхцөл байдал болон онцлог зүйлс), патентын төсөл зохиох нөхцөл байдал;
2. Бүхэл тойргийн эх бэлтгэлийн дизайныг хамгаалах;
3. Нууц мэдээллийг хамгаалах гэх мэт асуудлуудыг хамарна.

Иймээс олон улсын худалдааны хуулийн шинэчлэлт болон хэрэгжилт улс орон бүрт чухал байна. Манай улсын хувьд бид худалдаатай холбоотой хуулиудыг боловсруулахдаа аль болох худалдааны шинэ хэлбэрүүдийг дэмжин урамшуулах арга хэлбэрүүдийг илүү тусгаж өгөх шаардлагатай юм.



КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТОВЧ ТАЙЛБАР /НЭГДҮГЭЭР БҮЛЭГ/



А.Доржготов Шихихутуг
ХЗДС-ийн багш

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1 Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компаний удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Компанийн хуулийн зорилт нь дараах харилцааг зохицуулахад оршино.

- Компани үүсгэн байгуулах
- Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх
- Компанийг өөрчлөн байгуулах
- Компанийг татан буулгах

Компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэцтэй холбоотой харилцаа

- Хувьцаа эзэмшигчийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Гүйцэтгэх удирдлага
- Компаний эрх бүхий албан тушаалтан

Их хэмжээний хэлцэл

Сонирхлын зөрчил бүхий этгээд сонирхлын зөрчил бүхий хэлцэл

Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

Дээрх хүснэгтийг бичгээр тайлбарлавал Компанийн тухай Монгол улсын хуулиар дараах харилцааг зохицуулна гэдгийг тодорхойлжээ. Үүнд:

- **Компанийг үүсгэн байгуулах:** Энэ талаарх харилцааг Компаний тухай хуулийн 11 дүгээр зүйлээс 17 дугаар зүйлд зааснаар зохицуулагдана. Хуулийн этгээдийг байгуулах талаар Иргэний хуулийн 30 дугаар зүйлд¹ хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын

¹ Бүртгэлийн хууль.Төрийн мэдээлэл эмхэтгэл 2002 оны №7



дагуу үүсгэн байгуулж болно гэжээ. Мөн тэнд чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтарсан хуулийн этгээд байгуулж болохыг тодорхойлсон бөгөөд хуулийн эдгээр заалт бол компанийг үүсгэн байгуулах талаар компаниас хуулийн гадна баримталбал зохих эх сурвалж болно.

- *Компанийг бүртгүүлэх:* Хуулийн 15 дугаар зүйлд зааснаар улсын бүртгэлд бүртгүүлнэ. Компанийг байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоног дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгөх ёстой.
- *Компанийг өөрчлөн байгуулах:* Компанийг өөрчлөн байгуулах тухай ойлголт, түүнийг хэрхэн зохицуулах талаар хуулийн дөрөвдүгээр бүлэгт 18-24 дүгээр зүйлд тодорхойлсон байх бөгөөд компанийг өөрчлөн байгуулах гэдэгт компанийг нийлүүлэх, компанийг нэгтгэх, компанийг хуваах, компанийг тусгаарлах, компанийг өөрчлөх асуудлыг хамруулан авч үзжээ.
- *Компанийн удирдлага, зохион байгуулалт:* Компанийн удирдлага, зохион байгуулалтын асуудлын асуудлыг хуулийн есдүгээр бүлэгт 59-83 дугаар зүйлд

тодорхойлжээ. Энд хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний бүрэн эрх, хуралд оролцох журам, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, эрх хэмжээ зэргийг зохицуулна.

- *Хяналтын бүтэц:* Компанийн тухай хуулийн аравдугаар бүлэгт компаний эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлагыг тодорхойлжээ. Мөн их хэмжээний хэлцлийн талаар хуульд зохицуулсан явдлыг хяналтын тогтолцоонд оруулан үзэх үндэслэлтэй юм. Харин компаний санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих талаар хуулийн арвангурав дугаар бүлэгт 94-99 дүгээр зүйлд зохицуулсан улмаар компанийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай 100 дугаар заалтад тодорхойлсон байна.
- *Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох:* Хуулийн дийлэнх заалтууд, түүнээс хувьцааны хяналтын багц, хувьцаа эзэмшигчдийн хурал, хуралд оролцох эрх, хуралдаанд оролцох журмыг тогтоосон заалтуудад энэ асуудал тусгагджээ.
- *Компанийг татан буулгах:* Компанийг татан буулгах талаар хуулийн 26-29 дүгээр зүйлд журамлан зохицуулсан. Түүнчлэн, Иргэний хуулийн 32 дугаар зүйлд хуулийн этгээдийг татан буулгах талаар зохицуулсан байдаг. Эдгээр



зохицуулалтыг Компаний тухай хуулийн зорилтод товч тодорхойлсон байна. Хуулийн зорилт нь компани, түүний үйл ажиллагаатай холбоотой ямар харилцааг зохицуулахыг заасан бол компаний хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх хязгаарыг "хуулийн үйлчлэх хүрээ" гэсэн хуулийн 2 дугаар зүйлд тодорхойлжээ.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

- 2.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө.
- 2.2. Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг бусад хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар тус тус зохицуулна.
- 2.3. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг энэ хуулиар, түүнийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.
- 2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.
- 2.5. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.
- 2.6. Энэ хуулийн 2.5-д заасны дагуу үүссэн төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын их хурал, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн хурал байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь засгийн газар болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас эрх олгосон этгээд байж болно.
- 2.7. Компаниас өөр хэлбэрийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг байгуулахтай холбогдон харилцаа, түүний үйл ажиллагааг бусад хуулиар



зохицуулна.

1. Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа компани Компанийн тухай Монгол улсын хуулийг дагаж мөрдөнө. Гагцхүү тухайн компанийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын талаар хуульд өөрөөр заагаагүй бол Компанийн хуулийг мөрдөж сахин биелүүлнэ. Компанийн хуулийн зохицуулалт нь тухайн компанийн өмчийн хэлбэр, эд хөрөнгийн хэмжээ, үйлдвэрлэлийн хэмжээ, түүний дотоод зохион байгуулалт, зэргээс хамаарахгүй. Тухайлбал: эдгээр байдал нь Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа компани бол Компанийн хуулийг дагаж мөрдөхгүй байх шалтгаан болохгүй юм.
2. Үйл ажиллагаа, салбарын онцлог бүхий компанийн нийтлэг харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна. Харин үйл ажиллагааны онцлогтой холбогдох харилцааг бусад хуулиар зохицуулна. Энд банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны онцлогтой холбоотой харилцааг тус тусын хуулиар зохицуулна. Жишээлбэл: Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга, 2010 он/, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль /2002 он/, Даатгалын тухай хууль /2004 он/, Даатгалын

мэргэжлийн оролцогчийн тухай хууль /2004 он/, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль / шинэчилсэн найруулга, 2013 он/ гэх мэт бусад хуулиар онцлог харилцааг нарийвчлан зохицуулна.

3. Хуулийн 2.3 заалтад Компанийн хуулиар зохицуулах харилцаа, төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар зохицуулах харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ хязгаарыг тодорхойлжээ. Компанийн хуулиар: төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг **хувьчлах замаар** байгуулагдсан компанийн үйл ажиллагааг зохицуулна. Энэ зохицуулалттай холбогдуулан эрх зүйн нийтлэг эх сурвалжаас дурдах хэрэгтэй. Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хуульд эд хөрөнгө, өмч, түүний эрх зүйн үндсэн зохицуулалтыг баталгаажуулжээ. Монгол улсын Үндсэн хуулийн зургаа дугаар зүйлд “Монгол улсын газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтанд байна. Монгол улсын иргэнд өмчлүүлэхээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заажээ. Монгол улсын Иргэний хуульд эдийн болон эдийн бус баялагт хамааруулан хөрөнгө, эд хөрөнгө болон, эдийн бус



хөрөнгө, эзэмшлийн эрх зүйн үндсэн ойлголтыг тодорхойлжээ. Түүнчлэн **өмч** гэсэн бүлэгт өмчийн төрөл хэлбэр, өмчлөгч, өмчлөх эрхийг тодорхойлон зохицуулсан байдаг. Монгол улсад нийтийн ба хувийн өмч байна. Нийтийн өмчид: а) төрийн өмч, б) орон нутгийн өмч, в) шашны өмч, г) олон нийтийн өмч гэсэн хэлбэртэй байна. Иргэний өмч нь иргэний болон дундын байж болно.

Өмчлөгч: төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн, хуулийн этгээд байна. Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах, түүнийг аливаа халдлагаас хамгаалах эрхтэй байдаг. Эрх зүйн эдгээр зохицуулалтыг дурьдахын учир болбоос Компанийн хуульд заагдсан өмчлөх эрх, компанийн өмчийг шилжүүлэх, хувь нийлүүлсэн хөрөнгө зэрэг ойлголттой амин холбоотойн учир билээ.

Төрийн өмч: Төрийн өмчийн нарийвчилсан зохицуулалтыг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас үзэж болно. Хуульд төрийн өмчийг төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч гэж хоёр хэлбэрт ангилсан байдаг.

Төрийн нийтийн зориулалттай өмч: Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар

ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ. Төрийн нийтийн зориулалттай өмчид дараах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарна. Үүнд: иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, түүний доторх баялаг, ой, түүний дагалдах баялаг, ургамал, ан амьтны нөөц, түүх соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал, археологийн болон патентологийн олдвор, хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө. Төрийн нийтийн зориулалттай өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Монгол улсын Их хурал хэрэгжүүлнэ. Төрийн нийтийн зохицуулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн/, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болдог.²

Төрийн өөрийн өмч: Төрийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад төр эзэмшиж, ажиглаж, захиран зарцуулж болох дараах эд хөрөнгө хамаарна. Үүнд: төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө, төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө, улсын

² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 4 дүгээр зүйлээс



төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан, төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц, хуульд заасан бусад үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар нь Нөхөрлөл, Компанийн тухай хуульд заасны дагуу үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэж хуваадаг. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалтай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх журмыг хуулиар тогтооно. Төр өөрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоон зохицуулна. / Мөн хуулийн 5 дугаар зүйл/

Төрийн өмчийг хувьчлах арга: Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дараах аргыг дангаар буюу хослуулан хэрэглэхээр хуульд заажээ. Үүнд: дуудлагаар худалдах, уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/, төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах, төрийн өмчит хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах, татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах, менежментийн үр дүнг харгалзан хувьчлах, давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах, төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийн тодорхой хувиар бууруулж хувьчлах. Эдгээр найман аргыг хуулиар тодорхойлжээ. Төрийн өмчийн тодорхой эд

хөрөнгийг энэ зүйлд заасан аль аргаар хувьчлахыг Засгийн газраас баталсан жагсаалтад урьдчилан, түүний дагуу шийдвэрлэдэг. Түүнчлэн төрийн өмчит үйлдвэрийн компанийн хэлбэрт оруулан хувьцаа /ногдол хувь/ худалдах замаар худалдах /55/, төрийн өмчлөлийн хувьцаа, ногдол хувийг бусад этгээдийн өмчлөлд шилжүүлэх, чөлөөтэй болон богцолсон хэлбэрээр, биржээр болон биржээс гадуур арилжиж худалдах /56/, хамтарсан үйлдвэрийн газар байгуулах замаар хувьчлах /57/, удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах /58/, давуу эрхийн тусгай хувьцаа гаргах /59/, хуулийн этгээдийг татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах /60/, зохицуулалтыг хуульд тодорхойлжээ.³

Төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, бүртгэх:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заахдаа "төрийн өмчит үйлдвэрийн газар ба албан газрыг Засгийн газрын буюу хуулиар тусгайлан олгосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр байгуулах бөгөөд уг шийдвэр гарсан өдрөөр байгуулагдсанд тооцож бүртгэхээр зохицуулжээ.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани:

Төрийн болон орон нутгийн

³ Мөн хуулийн 34 дүгээр зүйлээс үзэж болно. Мөн хуулийн 55-60 дугаар зүйлээс үзэх.



өмчийн тухай хуульд зааснаар төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрхийг журамлан зохицуулсан байдаг. Төрийн өмчийн үйлдвэрийн газар гэсэн эрх зүйн ойлголт бий. Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчит үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.

- Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.
- Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

Тэгэхлээр Компанийн тухай хуульд зааснаар **төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдах харилцаа** бол: а) төрийн өмчийн оролцоотой компани, б) орон нутгийн өмчийн оролцоотой компани тус тусын төлөөллийг хэрэгжүүлэхэд хамаарч байна. Энэ нь төрийн

өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогтой шууд холбогдоно. Төрийн өмчийн оролцоотой буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилдог. Үүнд: Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих байгууллага болох Гишүүдийн /хувьцаа эзэмшигч буюу хувь нийлүүлэгчдийн/ хуралд төрийн өмчийн төлөөлөгчийг Төрийн өмчийн хороо томилж оруулна. Төрийн өмчийн оролцооны хэмжээтэй хувь тэнцүүлэн төрийн өмчийн төлөөлөгчийг Төрийн өмчийн хорооноос томилж тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон байна. Компанийн тухай хуулийн 79.4-д төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрх үүргийг тодорхойлсон. Төрийн өмчийн төлөөлөгч дараах үүрэгтэй: 1) гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд таслах эрхтэй оролцох, 2) төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж Төрийн өмчийн



хороонд оруулах, 3) олгогдсон эрх хэмжээний дотор төрийн өмчийн хороонд оруулах. Төрийн өмчийн төлөөлөгч Төрийн өмчийн хорооноос баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллах бөгөөд удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохоор хуульчилсан байна. Төрийн болон орон нутгийн оролцоотой компанид үйл ажиллагаанд **Компанийн тухай хуулиар зохицуулагдах харилцаанд**

- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох
- Гүйцэтгэх удирдлагыг сонгох
- ТУЗ-ийн дэргэдэх хороо байгуулах
- ТУЗ-ийн нарын бичгийн дарга томилох асуудлууд хамаарна.

Эдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар төрийн өмчит болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулж болно. Ийм арга замаар үүссэн компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар зохицуулна. Тухайлбал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 55 дугаар зүйлд Төрийн өмчит

үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан хувьцаа, ногдол хувийг нь худалдах замаар хувьчилж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргахаар, мөн эдийн засаг нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс төр зарим хувьцааг нийтэд санал болгохгүй, өөрийн өмчлөлдөө авч үлдэн төрийн өмчийн оролцоотой этгээд үүсгэж болохоор тус тус зохицуулсан байна. Төрийн өмчит үйлдвэрийг өөрчлөн зохион байгуулах ажлыг Төрийн өмчийн хороо эрхэлж, Компанийн тухай хуулийн 11,12 дугаар зүйлд заасан үүсгэн байгуулагчийг төлөөлсөн эрх үүргийг гүйцэтгэнэ. Төрийн өмчийн хороо нь хувь нийлүүлэгчдийн зохион байгуулах хурлыг хувьцаа, ногдол хувь нь зохих журмын дагуу борлогдож дууссанаас хойш 3 сарын дотор зохион байгуулж өөрийн хариуцаж байсан эрх, үүргийг шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн удирдлагад шилжүүлэхээр зохицуулсан байна.

6. Өмчлөгч, түүнийг төлөөлөх субъектын тухай заасан байна. Дээр дурьдсанаар компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн өмчлөгч нь:

а) Төрийг төлөөлж Улсын Их Хурал байна.

б) Улсын их хурлыг төлөөлөх хувьцаа эзэмшигч нь засгийн



газраас эрх олгосон этгээд байж болно. Орон нутгийн өмчит компани бол тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал төлөөлнө. Харин түүнийг төлөөлсөн хувьцаа эзэмшигч нь иргэдийн төлөөлөгчдийн хурлаас эрх олгосон этгээд байж болохоор тус тус зохицуулсан байна.

Хуулийн 2.6 заалтын зохицуулалт ийм байдлаар ойлгогдож байна.

7. Компанийн өөр хэлбэрийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг байгуулах, түүний үйл

ажиллагаатай холбоотой асуудлыг бусад хуулиар зохицуулна. Тухайлбал: Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хоршооны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банкны тухай хууль зэрэг хууль тогтоомжийг дурьдаж болно.

ҮРГЭЛЖЛЭЛ БИЙ...





МОНГОЛ УЛСЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ИРЭЭДҮЙ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН



С.Батбуян СЭЗДС-ийн ахлах багш,
докторант

Чөлөөт бүсийн түүхэн хөгжил, ойлголт: Дэлхийн эдийн засгийн тогтолцоонд олон улсын бараа эргэлт, эдийн засгийн интеграцийн идэвхжилт, эдийн засгийн хөгжлийн түвшинг хурдасгах гол үзүүлэлт бол эдийн засгийн чөлөөт бүс юм. Эдийн засгийн чөлөөт бүс нь хөнгөлөлттэй болон урамшууллын онцгой системийг багтаасан тухайн улсын бусад хэсэгт үл хэрэглэгдэх, үндэсний эдийн засгийн орон зайн хэсэг юм.¹

Худалдааны чөлөөт бүсийн ойлголт 2000 гаруй жилийн өмнө бий болсон. Тухайлбал, одоогийн Турк улсын нутаг дэвсгэрт оршиж байсан "Эфесус" боомтод худалдаачдыг

найрсаар хүлээж авдаг байсан нь тус бүс нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан² гэж үздэг. Далайн боомтуудыг чөлөөт боомт болгох ашиглах туршлага хэдэн зуун жилийн өмнөөс бий болсноор барааны эргэлтийг эрчимжүүлсэн төдийгүй Гонгконг, Сингапур зэрэг хот улс бий болоход нөлөөлсөн. Худалдааны чөлөөт бүсийн тухай орчин үеийн ойлголт нь Ирландын Шаннон (*Shannon*)-ны чөлөөт бүсээс үүдэлтэй. Ирландын засгийн газраас Шанноны нисэх онгоцны буудлын орчимд аж үйлдвэрийн бүс бий болгох либерал бодлогыг 1950-иад онд хэрэгжүүлсэн байна.³ Энэ нь дээрх нисэх буудлын ашиглалтыг сайжруулах зорилготой байсан ч Шанноны худалдааны чөлөөт бүс бий болсон нь Ирланд улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулсан. Шаннонын чөлөөт бүсийн бодлогыг 30 гаруй жилийн турш тогтвортой сайжруулж, хүрээг нь өргөжүүлснээр Ирланд улс 1990-ээд онд Кельтийн бар улс болж чадсан.

Худалдааны чөлөөт бүсийн уламжлалт үзэл баримтлал нь экспортыг дэмжихэд чиглэж байсан ба дотоодын эдийн засгийн бусад салбаруудтай харилцаа холбоо

² Хосе Серон. Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл: "Монгол улсын худалдааны чөлөөт бүс хөтөлбөрийн үнэлгээ, чөлөөт бүсийн байдалтай танилцсан дүн шинжилгээ"-ний тайлан. УБ., 2004 он, 13 дахь нүүр

³ <http://www.shannonproperty.ie/shannon-region/shannon-free-zone-sfz/>

¹ Foreign Trade Zone Corporation. Retrieved April 1, 2013



тогтооход төдийлөн анхаарахгүй, тусгаарлагдсан бүс нутгийн хэлбэрээр оршин тогтнож байсан. Худалдааны чөлөөт бүс нь гол төлөв алслагдсан газар нутагт байгуулж, төрийн удирдлаган доор хөгжүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь 70-80 хувийг экспортонд гаргах шаардлага тавьж байсан. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж, шинэ технологи, ноу-хауг татварын хөнгөлөлт, хямд ажиллах хүчээр солих зорилготой юм.

Өнөөгийн чөлөөт бүсүүд нь газар зүйн байршлынхаа давуу талуудыг бүрэн ашиглах бололцоог дотоод гадаадын үйлдвэрлэгчдэд санал болгож, бизнесийн таатай орчин Чөлөөт бүсийн түүхэн хөгжил, ойлголт: Дэлхийн эдийн засгийн тогтолцоонд олон улсын бараа эргэлт, эдийн засгийн интеграцийн идэвхжилт, эдийн засгийн хөгжлийн түвшинг хурдасгах гол үзүүлэлт бол эдийн засгийн чөлөөт бүс юм. Эдийн засгийн чөлөөт бүс нь хөнгөлөлттэй болон урамшууллын онцгой системийг багтаасан тухайн улсын бусад хэсэгт үл хэрэглэгдэх, үндэсний эдийн засгийн орон зайн хэсэг юм.

Худалдааны чөлөөт бүсийн ойлголт 2000 гаруй жилийн өмнө бий болсон. Тухайлбал, одоогийн Турк улсын нутаг дэвсгэрт оршиж байсан "Эфесус" боомтод худалдаачдыг найрсгаар хүлээж авдаг байсан нь тус бүс нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг. Далайн боомтуудыг чөлөөт боомт

болгох ашиглах туршлага хэдэн зуун жилийн өмнөөс бий болсноор барааны эргэлтийг эрчимжүүлсэн төдийгүй Гонгконг, Сингапур зэрэг хот улс бий болоход нөлөөлсөн. Худалдааны чөлөөт бүсийн тухай орчин үеийн ойлголт нь Ирландын Шаннон (Shannon)-ны чөлөөт бүсээс үүдэлтэй. Ирландын засгийн газраас Шанноны нисэх онгоцны буудлын орчимд аж үйлдвэрийн бүс бий болгох либерал бодлогыг 1950-иад онд хэрэгжүүлсэн байна. Энэ нь дээрх нисэх буудлын ашиглалтыг сайжруулах зорилготой байсан ч Шанноны худалдааны чөлөөт бүс бий болсон нь Ирланд улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулсан. Шаннонын чөлөөт бүсийн бодлогыг 30 гаруй жилийн турш тогтвортой сайжруулж, хүрээг нь өргөжүүлснээр Ирланд улс 1990-ээд онд Кельтийн бар улс болж чадсан.

Худалдааны чөлөөт бүсийн уламжлалт үзэл баримтлал нь экспортыг дэмжихэд чиглэж байсан ба дотоодын эдийн засгийн бусад салбаруудтай харилцаа холбоо тогтооход төдийлөн анхаарахгүй, тусгаарлагдсан бүс нутгийн хэлбэрээр оршин тогтнож байсан. Худалдааны чөлөөт бүс нь гол төлөв алслагдсан газар нутагт байгуулж, төрийн удирдлаган доор хөгжүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь 70-80 хувийг экспортонд гаргах шаардлага тавьж байсан. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж, шинэ технологи, ноу-хауг татварын хөнгөлөлт, хямд ажиллах



хүчээр солих зорилготой юм.

Өнөөгийн чөлөөт бүсүүд нь газар зүйн байршлынхаа давуу талуудыг бүрэн ашиглах бололцоог дотоод гадаадын үйлдвэрлэгчдэд санал болгож, бизнесийн таатай орчин бүрдүүлэхийг эрмэлзэж байна. Мастер төлөвлөгөөнд тулгуурлан олон талт үйл ажиллагаа явуулах болсноор тэнцвэртэй хөгжлийг хангаж, төрөл бүрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих боломж нээгдсэн. Хамгийн гол нь тууштай, ил тод, урьдчилан таамаглах боломжтой бодлогоор дамжуулан хөрөнгө оруулагчдыг татаж болдог.

Монгол улсын чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт: Манай улсын хувьд УИХ-ын 1995 онд батлагдсан 87 дугаар тогтоолоор “Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг анх баталж, чөлөөт бүс байгуулах үндэслэл шаардлага, онцлог зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгснөөр чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэн гэж үздэг.⁴ Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилгын хувьд тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэд технологи оруулах

замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршиж байв.

Улмаар 2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль, 2002 онд “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн тухай, 2003 онд “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд, түүний хэрэгжилттэй холбоотой дүрэм, журмыг баталсан. Эдгээр журам нь хуулийн хэрэгжилтэнд дөхөм болохын зэрэгцээгээр зохицуулалтын арга хэмжээнүүдийн дэс дарааллыг тодорхойлж өгөх ач холбогдолтой.

Мөн Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт⁵ “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах талаар заажээ.

Өнгөрсөн хугацаанд улсын төсвөөс нийтдээ 23 тэрбум 84 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж бүсийн үерийн хамгаалалтын далан, суваг, Алтанбулаг-Сүхбаатарын 25 км бохир усны шугам хоолойн цахилгаан хангамж, 800 шоо метр усан сан, гааль, худалдааны зам талбай зэрэг дэд бүтцийн ажил хийж гүйцэтгэсэн байна. Мөн 2010 оноос БНХАУ-ын Засгийн газрын

⁴ Монгол улсын Их хурлын 1995 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн “Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын тухай” 87 дугаар тогтоолын хавралт

⁵ “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их хурлын 2012.09.28-ний өдрийн 37 дугаар тогтоолын хавралт



хөнгөлөлттэй зээлийн 58.8 сая долларын хөрөнгөөр "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл" хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд Замын-Үүд сум болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуурга, авто зам, харилцаа холбооны байгууламжуудыг шинээр барих буюу шинэчлэлтийг ажил явагдсан.⁶

Бүгд Найрамдах Солонгос Улсын чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, онцлог: БНСУ-д эдийн засгийн чөлөөт бүс гэж гадаадын хөрөнгө оруулалттай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин болон гадаад иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор хөгжүүлж буй хуульд заасны дагуу төлөвлөсөн, нэрлэсэн бүсийг ойлгоно.⁷ Чөлөөт бүстэй холбоотой аливаа харилцааг "Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай хууль"-иар голлон зохицуулдаг бөгөөд түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журам, түүнчлэн бусад салбарын хуулиудаар зохицуулдаг байна. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль,

Төрийн өмчийн менежментийн тухай орон нутгийн журам, Газрын тухай хууль зэрэг салбарын хуулиудад шаардлагатай зохицуулалтыг тусгаж өгсөн.⁸

БНСУ-ын Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай хуулийн зорилго нь эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментээр дамжуулан гадаадын хөрөнгө оруулалттай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин, гадаад иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үндэсний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, бүс нутаг хоорондын тогтвортой хөгжлийг хангахад оршино⁹ гэж заажээ.

БНСУ-ын хувьд эдийн засгийн чөлөөт бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд тухайн улсад хөрөнгө оруулсных нь төлөө дараах төрлийн урамшуулал эдлүүлдэг байна. Үүнд, татварын үр ашиг, бизнесийн дэмжлэг, төрийн зохицуулалтыг халах, амьдрах нөхцөл, захиргааны дэмжлэг зэрэг ерөнхий таван төрлийн урамшуулал эдлүүлдэг байна. Тус бүрд нь дэлгэрүүлж авч үзвэл,

⁶ <http://www.parliament.mn/news/open/categories/2453/pages/14697>

⁷ Special Act on Designation and Management of Free Economic Zones, article 2, April 15, 2010

⁸ <http://www.fezone.go.kr/en/fez-act.jsp> (Korean

Economic Free Zone)

⁹ Special Act on Designation and Management of Free Economic Zones, article 1, (Amended by Act No. 9366, Jan. 30, 2009)



Татварын дэмжлэг (Tax Benefits) ¹⁰

Ашиг хүртэх зүйл	Урамшуулах 5 жил	Урамшуулал 7 жил
Хууль зүйн үндэслэл	Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тусгай хууль (Special Act on Designation and Operation of Free Economic Zone)	
Ажлын байр бий болгосны урамшуулал авах болзол хангасан хуулийн этгээд	Дотоодын компани, 100% гадаадын хөрөнгө оруулалттай фирм, гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрийн 10-аас дээш хувийг эзэмшигч	
Татварын ашиг хүртэх болзол хангасан хуулийн этгээд	Эдийн засгийн чөлөөт бүсэд ажлын байр бий болгосон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд	
Улсын татвар (State Tax)	1. Гаалын татвараас 5 жил чөлөөлнө (импортолж буй үйлдвэрлэлийн хэрэгсэл) 2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3 жилийн хугацаанд 100%, дараагийн 2 жил 50% чөлөөлнө.	1. Гаалын татвар, Тансаг хэрэглээний татвараас (Special consumption tax), НӨАТ 5 жил чөлөөлнө. 2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3 жилийн хугацаанд 100%, дараагийн 2 жил 50% чөлөөлнө.
Орон нутгийн татвар (Local Tax)	Хуримтлалын татвар (Acquisition tax), Үл хөдлөх хөрөнгийн татвараас 15 жил 100% чөлөөлнө.	

Бизнесийн дэмжлэг (Business Support)

Хөнгөлөлт, чөлөөлөлт	
Хууль зүйн үндэслэл	1. Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль 2. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль 3. Төрийн өмчийн менежментийн тухай орон нутгийн журам
Түрээс	Гадаадын хөрөнгө оруулагч төрийн болон олон нийтийн өмчийг 50 жил хүртэл хугацаанд түрээслэж болно.
Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт	<ul style="list-style-type: none"> Гадаадын хөрөнгө оруулагчид 10-20 сая долларын хөрөнгө оруулбал, Өдөр бүр дунджаар 200-300 ажилчид тогтмол ажилладаг бол, Нийт бүтээгдэхүүний 50 хувийг экспортолдог болон бүтээгдэхүүний эд анги, орц, материалын 75 хувийг дотоодод үйлдвэрлэсэн бол, Нийт бүтээгдэхүүний 75 хувийг экспортолдог бол түрээсийн төлбөрөөс тус тус 75% чөлөөлнө. Гадаадын хөрөнгө оруулагчид 5-10 сая долларын хөрөнгө оруулбал, Өдөр бүр дунджаар 100-200 ажилчид тогтмол ажилладаг бол, Нийт бүтээгдэхүүний 50 хувийг экспортолдог болон бүтээгдэхүүний эд анги, орц, материалын 50-75 хувийг дотоодод үйлдвэрлэсэн бол, Нийт бүтээгдэхүүний 50-70 хувийг экспортолдог бол түрээсийн төлбөрөөс тус тус 50% чөлөөлнө.

¹⁰ <http://www.fez.go.kr/en/investment-incen-tives-tax-benefits.jsp>



Худалдан авалт	Гадаадын хөрөнгө оруулагч нь улсын болон хувийн хөрөнгийг хувийн тохиролцооны гэрээгээр өмчийн бодит өртөгтэй тэнцэх үнээр авч болно.
Санхүүгийн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> Худалдан авалтын төлбөрийг хэсэгчлэн төлөх болон төлбөрийг тодорхой хугацаагаар хойшлуулж болно. Үүнд: төрийн өмч (төлбөр төлөх хугацааг дээд тал нь нэг жил хойшлуулж болох бөгөөд 20 жилд хэсэгчлэн төлж болно), нийтийн өмч (20 жилийн турш хэсэгчлэн төлж болох бөгөөд жил бүр 3 хувийн хүү тооцно) Үйлдвэрлэлийн паркард татаас олгож болно. Боловсролын болон сургалтын тэтгэлэг 100-500 мянган воныг сар тутамд шинэ ажилтанд бүрт олгоно.

Төрийн зохицуулалтыг халах (Deregulation):

Хууль зүйн үндэслэл	Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тусгай хууль (Special Act on Designation and Operation of FEZ)
Хотын захиргаанаас үзүүлж буй бодлогын дэмжлэг	Эдийн засгийн чөлөөт бүс дэх ямар ч гадны хөрөнгө оруулалттай компани нь Сөүл хотын хэт суурьшлын бүсийн хяналтын журмыг дагаж мөрдөх шаардлагаас чөлөөлөгдөн.
Санхүүгийн орчин дахь дэмжлэг	Гадны хөрөнгө оруулалттай компаний бизнесийн үйл ажиллагааг тодорхой болгохын тулд гадны мөнгөн тэмдэгтээр гүйлгээ эрхэлж болно (10 000 доллар хүртэл).
Бусад	Гадны хөрөнгө оруулалттай компани нь улсын болон олон нийтийн өмчийг хамгийн дээд тал нь 50 жилээр түрээслэх боломжтой бөгөөд тохижилтын ажил хийж болно.

Амьдрах нөхцөл (Living Conditions)

Хууль зүйн үндэслэл	Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тусгай хууль (Special Act on Designation and Operation of FEZ)
Гадаад хэлний үйлчилгээ (Foreign Language Service)	Олон нийтийн бичиг баримтууд нь гадаад хэл дээр гардаг ба олон нийтийн агентлагууд нь бичиг баримтуудыг гадаад хэл дээр хүлээн авч боловсруулдаг.
Боловсролын орчин (Educational Environment)	Шинжлэх ухаан болон Боловсролын яамны зөвшөөрлөөр гадны боловсролын хүрээлэнгүүд байгуулагдаж болно.
Эмнэлэгийн орчин (Medical Environment)	1. Гадаадын эрүүл мэндийн хүрээлэн эсвэл гадаадын иргэний эмийн сан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж болно. 2. Гадны эрүүл мэндийн байгууллагуудад зориулсан тусгай хууль хэрэгжинэ.



<p>Бусад (Others)</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зөвхөн гадаадын иргэдэд зориулсан казино гадны хөрөнгө оруулагчдад (500 сая доллараас дээш хөрөнгө оруулсан) зөвшөөрөгдөнө. 2. Гадны телевизийн сувгууд орон нутгийн кабелийн сүлжээгээр цацагдах, 3. Эдийн засгийн чөлөөт бүс нь орон сууцны нийлүүлэлтийн нийт тооны 10 хүртэл хувьд тэнцэх хэмжээний орон сууцны газрыг гадаадын иргэдэд зориулсан орон сууцны барилгын ажилд гаргаж өгнө.
---------------------------	--

Захиргааны дэмжлэг (Admin Support) : Эдийн засгийн чөлөөт бүсийг төлөвлөх үед хотын хөгжлийн бүс, хотын хөгжлийн төлөвлөгөөний дэд төлөвлөгөө; ложистикийн цогцолборын төлөвлөлт; нийтийн усан хангамж, менежментийн суурь төлөвлөгөөг өөрчлөх; гол мөрний менежментийн ерөнхий төлөвлөгөө; бохир усны менежментийн ерөнхий төлөвлөгөө зэргийг хамтад нь төлөвлөж, баталдаг байна.

FEZ Living Environment





Дүгнэлт, санал:

Манай улсад чөлөөт бүсийн үзэл баримтлал, хууль эрх зүйн орчин бүрэлдээд арав гаруй жил өнгөрч, энэ хугацаанд улсын төсвөөс нэлээд хөрөнгө оруулсан ч олигтой үр дүнд хүрч чадахгүй байна. Иймд чөлөөт бүс нь улсын төсвөөр тэтгүүлдэг биш өөрөө өөрийгөө санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг газар болгож өөрчлөх зарчмын үндсэн дээр эрх зүйн орчинг нь улс орны хөгжлийн өнөөгийн шаардлага, хэтийн чиг хандлага, тэргүүлэх туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна. “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын чөлөөт бүсүүдэд тус бүр бие даасан хууль баталсан хэдий ч чөлөөт бүсийн хөгжил, түүнийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, амьдралын нөхцлийн талаар ямар ч зохицуулалт хийгээгүй байна. Энэ нь чөлөөт бүсүүд үр ашиггүй ажиллах нэг хүчин зүйл болж байна. БНСУ-ын хууль тогтоомжыг судалж үзэхэд эдгээр асуудлыг цогцоор нь тусгаж шийдвэрлэсэн бөгөөд чөлөөт бүс байгуулах шийдвэр гарч, төлөвлөгөө батлагдсан бол нэг жилийн дотор үйл ажиллагаагаа эхлэхийг хуульчилсан нь нэн оновчтой зохицуулалт юм. Иймд судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Татвар, гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллын асуудлаас илүүтэйгээр чөлөөт бүс үүсгэн байгуулах болон түүнийг дагасан

хотжилт, бүтээн байгуулалт, газар зохион байгуулалт, оршин суугчдын ажил эрхлэлт, амьдрах орчин, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бүсийн өөрийгөө санхүүжүүлэх чадвар зэрэг асуудлыг шийдэх эрх зүйн болон бүтцийн тогтолцоог бий болгох шаардлагатай.

2. Уул уурхай төдийгүй бусад экспортын бүтээгдэхүүний эргэлтийг нэмэгдүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх, түүхий эд, ашигт малтмалд технологийн боловсруулалт хийж экспортлох хамтарсан үйлдвэрүүдийг хил орчмын бүс нутагт байгуулах зорилтыг хуульчлах шаардлагатай байна. Үүний тулд хилийн бүст байгуулах худалдааны болон эдийн засгийн чөлөөт бүсүүдийг хөрш орнуудын засгийн газар хоорондын хэлэлцээр, урт хугацааны хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын баталгаа гаргах замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж байгуулах нь оновчтой юм. Тухайлбал, “Алтанбулаг”, “Цагааннуур” зэрэг чөлөөт бүсийг ОХУ-тай; Замын-Үүд, Гашуун Сухайт зэрэг өмнөд хилийн дагуу орших боомтуудад суурилсан чөлөөт бүсийг БНХАУ-тай засгийн газрын түвшинд хэлэлцэн байгуулах, хөрөнгө оруулагчдад засгийн газруудын хамтарсан баталгааг гаргах зэргээр дэмжвэл үр дүнтэй юм.

3. Чөлөөт бүсийн менежментийн чиг үүргийг гол төлөв хувийн хэвшилд шилжүүлдэг.



Иймд манай улсад мөн адил менежментийг хувийн хэвшилд шилжүүлэхийг зөвшөөрч, дэмжих нь зүйтэй.

Манай улсын эдийн засгийн өсөн нэмэгдэж байгаа хурдцыг гүйцэхгүй байгаа хил орчмын бүс нутгийг онцгой бодлогоор дэмжиж

хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлэх замаар хөгжлийн бодлого боловсруулах нь ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Түүнчлэн чөлөөт бүсийн дэд бүтцийн хөгжилд онцгой анхаарал хандуулах цаг болжээ.





МОНГОЛ УЛС ДАХЬ АРДЧИЛЛЫН ХЯМРАЛ, АРДЧИЛЛЫГ ШИНЭЧЛЭХ ТРИЛЕММА.¹

“Ардчилал бол хүний төлөө, хүнд үйлчилдэг,
хүн өөрөө асуудлыг шийддэг засаглал юм” А. Линкольн



*П.Баянбаатар Шихихутуг ХЗДС-ийн
ахлах багш, докторант*

**Нэг: Монгол Улс дахь ардчилал
түүний хямрал өнгөрсөн, одоо...**

Ардчиллын тухай товчхон

Ардчилал гэдэг нь ард түмний засаг гэсэн утгатай грек үгнээс гаралтай гэж судлаачид тайлбарласан байдаг. Эртний грекийн Афин, Ромд улсын чухал асуудлыг ард нийтийн санал хураах асуудлаар шийдвэрлэдэг байсан нь шууд ардчиллын сонгодог хэлбэр

гэж үздэг. Төлөөллийн ардчилал нь иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах, ард түмний тусын тулд зохих хөтөлбөрийг биелүүлэх үүрэг бүхий албан тушаалтныг сонгож, түүгээрээ дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэрийг хэлнэ гэж ерөнхий байдлаар тодорхойлж болно.

Төлөөллийн ардчилал нь үндсэн хуультай нийцэж, засаглал бүрэн эрхийнхээ хүрээнд иргэний үндсэн эрхийг баталгаажуулна. Ийм нийгэмд төр засгийг олонх барьж, цөөнхийн эрхийг хуулиар хамгаална. Төлөөлөгчид шийдвэр гаргахдаа ард түмний хүсэл зоргийг илэрхийлнэ. Ардчиллын нөхцөлд төлөөлөгчид тогтмол явагдах сонгуулиар ард түмний өмнө ажлаа тайлагнана. Ийм сонгуулиар ард түмэн дэмжиж байгаа, эсэргүүцэж байгаагаа санал өгч илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл бидний “шинэ” гэж нэрлэх дуртай Үндсэн хуулийг батласан цагаас хойш бид энэ замаар явж иржээ.

Монголын Ардчилалын мөн чанар

Ардчилал бол хүний төлөө, хүнд үйлчилдэг, хүн өөрөө асуудлыг шийддэг засаглал байх ёстой гэж бид ойлгодог, зарим нь ойлгосоор ч байгаа.

¹ Трилемма- Хүлээж авах аргагүй, тааламжгүй гурван хувилбараас сонгох хүндрэл



Үүний талаар маш олон эрдэмтэд тайлбар хийсэн байдаг. Бидний сайн мэдэх Ж. Бэнтам "засаглагч этгээд нь засаглуулагч этгээдийн ашиг сонирхолыг хамгаалахын тулд" эрх мэдлээ хэрэгжүүлэх ёстой буюу хүнд үйлчилдэг байх талаар дурьдсан байдаг.

Орчин үед Самуэль Хантигтон, Ф.Фукуяма, Дэвид Лэйтэн зэрэг судлаачид хүний аюулгүй байдлын суурь нөхцөлийг бий болгоогүй бол Төрөө бэхжүүлэх шаардлагатай ба хүний төлөө засаглалаа эргэн харахыг зөвлөжээ.

Харин улс төр, эдийн засаг, төрийн мэдлийн хуваарилалт зэрэг олон асуудлын голд төр өөрөө хүний төлөө, хүнд үйлчилдэг байх тухай онолыг дэвшүүлэн тавьж гаргалгаа хайсаар ирсэн хэдий ч хүн өөрөө асуудлаа шийдэх / зөвлөлдөх/ талаар дурьдахаас зайлсхийж ирсэн.

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжин 26 жил болсон хэдий ч яг ардчилсан нийгэмд шилжиж чадсан эсэх нь эргэлзээтэй талаар судлаачид санал нэгдэх болжээ.

Өнгөц нүдээр харвал төрийн тоталитар тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжиж буй үйл явц дүр зураг ажиглагдсан.

1990 оны 9 дүгээр сарын 03- ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын анх дугаар чуулганаар байгуулагдсан Улсын Бага Хурал 9 дүгээр сараас 1992 оны 3 дугаар

сар хүртэл 5 удаагийн чуулганаар нийт 61 хууль 149 тогтоол хэлэлцэн батласан байдаг.

Үүнд Үндсэн хууль тэргүүтэй Өмч хувьчлалын тухай, Банкны тухай, Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аж ахуй нэгжийн тухай, Хөдөлмөрийн тухай гээд нийгмийн харилцааг нэн тэргүүнд зохицуулах шаардлагатай гол хуулиудыг батлан гаргасан нь нэн саашаалтай.

Хэрэв хэм хэмжээний буюу норматив талаас авч үзвэл манай Үндсэн хууль болон түүнийг даган гарсан материаллаг хуулиудад өөлөх зүйл үгүй бөгөөд харин зохицуулалтын механизм талаасаа хэрхэн том, жижиг дугуйтай тэрэг лугаа байгааг харж болно.

Энэ нь улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд амьдрал, хөрсөнд буусан зүйлс тун цөөхөн байсан ба сонгосон тогтолцооны мөн чанарыг орхигдуулсан, эрх зүйн конвергенци, рецепцийг органик байдлаар хийж чадаагүй, монгол хүний өвөрмөц онцлог-менталетитийг харгалзан үзээгүй гэж шууд дүгнэж болохоор байдаг.

Тухайлбал:

Монгол Улсын Үндсэн хууль 16 дугаар зүйл

1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас



бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

б/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно

18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй... гэх мэт.

Дээрхээс дэд дүгнэлт хийвэл бид зөвхөн Эрүүгийн хуулиар цаазаар авах ял ногдуулахаас бусад тохиолдолд амьд явах эрхэнд халдахыг төрийн зүгээс хориглосон. Гэтэл 2016 оны 9 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөх Эрүүгийн хуулинд цаазаар авах ялыг халж, бүх насаар нь хорих ялыг хамгийн хүнд төрлийн ялаар тооцсон. Ингэснээр амьд явах гэдэг агуулыг амьдрах эрхтэй гэх агуулгаар ойлгох хэрэгцээ шаардлага гарсан .

Эмнэлгийн төлбөргүй тусламж авах ёстой асуудлыг Үндсэн хуулиар нарийвчлан зааснаар эрүүл мэндийн тогтолцоог хуучин социалист / дайны зохион байгуулалт бүхий/ хэв маягаас одоог хүртэл салгаж чадаагүй.

Түр буюу байнга оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй гэх хуулийн ганцхан заалт нь өнөөгийн Улаанбаатар хотын төлөвлөлт, хөрсний болон агаарын бохирдолт, хэт их төвөлрөл гээд олон асуудлыг

дурьдаж болно. Энэ нь эцсийн дүнд холбооны улсын хэрэглэдэг зарчмын мөн чанарыг үл ойлгон рецепци хийсэнтэй шууд холбоотой.

Улс төр ба эрх зүйн хүрээндэх ардчиллын мөн чанар

1983 онд Жан Франсуа Ревель "Ардчилал эцэстээ түүхийн нэгэн зол болж, нүдний өмнө аяндаа замхрах түр зуурын төөрөгдөл байсан болж таарах ч байсан юм билүү гэж халаглаж байв. Үүн лугаа хэрэг дээрээ ардчилал гэж дүр эсгэн Үндсэн хуулиар жад хийж төрийн эрх мэдлийг хөх тэнгэрт залан, хүний эрхээр лоозон хийх үйл явц нь эцэстээ урагшлах бус ухрах замруу жолоодож болохыг сануулж байна.

Иймд Ардчилсан улсаас Ардчилалын үнэрийг үнэртэхийн тулд юун түрүүнд хүний эрхийг хэрхэн хангаж хамгаалсан байдал, төрийн эрх мэдлийг жинхэнэ ёсоор хуваарилаж, Үндсэн хууль сонгодог байдлаар орших тэр нөхцлийн гүнрүү нэвтрэх явдал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 3-р зүйлийн 1-дэх хэсэгт "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" гэсэн нь төр нь ард түмнээс хамааралтай, түүнээс сонгож байгуулагдахын сацуу ард түмэнд "ард нийтийн



санал асуулгаар” өөрсдийн алив үндсэн хуульд харш бус асуудлыг шийдвэрлэх боломжийг баталгаажуулжээ.

Үндсэн хуулийн 20-р зүйлд: “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн үндсэн хуулийн 38-р зүйлийн 1-дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудаас үзэхэд ард түмнээс эх сурвалжтай төр нь ардчилсан, шудрага ёсны зарчмыг өөртөө шингээж түүнээс салгаж болшгүй гэх төрийн эрх мэдэл үндсэн хуулийн түвшинд хуваарилагдсан байна гэж хэлбэрийн төдийд дүгнэж болохоор байна.

Эрх мэдэл хуваарилах онолын хүрээнд улс төрийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх явдал нь Ардчиллын туйлын зорилго гэж хэлэхэд хэлсдэхгүй.

Эл зорилгыг хангахын тулд хуулийг дүр эсгэсэн хэм хэмжээгээр эвлүүлэн тавих бус зохицуулалтын механизм талаас нь тунгаан шүүж бүтээх явдал юм.

Гэвч бид хуулиар засаглах үр дагаварыг ойлгохыг хүсээгүй учир доорх хананд тулан шийдэл хайж эхлэсэн байна.

1.Төрийн дээд эрх мэдэл эрх зүйгээр удирдагдах бус олонхийн үзэл бодол төдийд ганхах байр суурьтай болсон. Учир нь Парламент бол гүйцэтгэх эрх мэдэлд хүрэх шат гэж үзэн, гүйцэтгэх эрх мэдэл хүчтэй байх тусам хууль бүтээх ажиллагааг удирдах боломжийг бүрдүүлсэн.

2.Үэстминстерийн систем² үл тохирох үнэн царай ил гарах тусам тогтолцоондоо бус улс төрийн соёлын төлөвшил муу байгаад хэмээн итгүүлэх оролдлого хийсээр байна.

Учир нь элит нимгэн манай Монгол шиг жижиг улсын хувьд ялсан намын дарга гүйцэтгэх эрх мэдлийг удирдан танхимаа бүрдүүлэх үйл явц нь мэргэшсэн гэхээс илүүтэйгээр мэдлэг дутагдсан байдалруу хүргэсэн..

Үүний тод жишээ бол 1996 оноос хойш гүйцэтгэх эрх мэдлийн залгамж чанар, төрийн албаны мэргэшсэн байдал алдагдаж, энэ 2010 онд хүчээ аван 2012 оны сонгуулийн дараагаар дээд цэгтээ тулан намын гэх үндэслэлээр олон мянган төрийн албан хаагчийг халсан.³

Ёорг Паул Мюллерын хэлсэнчлэн хүний эрх, эрх чөлөөнд нэг талаас зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх чадваргүй сул дорой төр нөгөө талаас хуульд

² Үэстминстерийн систем – олонхийн загвар, эрх мэдлийг төвлөрүүлэх тогтолцоо

³ Ч.Даваадаш. Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог ээдрээ. 2015., УБ 15 дахь тал



захирагддаггүй эрх мэдэл нь данхайсан төр аюул учруулдаг гээд ийм төрд дараах шинж байдаг гэжээ.

- Хүчтэй байдлаа алдсан парламент
- Хариуцлагагүй гүйцэтгэх эрх мэдэл
- Хууль тогтоомжийг залгамж чанар, уялдаа муу
- Улс төрийн нөлөөн доорх шүүх эрх мэдэл

Платон Republic бүтээлдээ Сократын тайлбарлаж байгаагаар бол хулгайч дээрэмчдийн бүлэг дотор хүртэл олз омгоо хуваахдаа баримталдаг шударга ёсны тодорхой зарчмууд үйлчилдэг гэжээ.

Энэ бол эрүүгийн ертөнцийн зохион байгуулалттай бүлгийн асуудлыг дурьдаж байгаа хэрэг мэт өнгөц харагдавч өнөөгийн нийгэм дэх төрийн эрх мэдлийг хэрхэн улан доороо гишгэх явц, улс төрийн дүрэмгүй тоглоомын талаар дурьдсан хэрэг гэж ойлгож болно.

Хоёр: Ардчиллыг шинэчлэх трилемма буюу орох орц хайх нь

Итгэлийг олох хэцүү, алдах амархан.

Сидэдхарта Гуатама

Монгол улсад нүүрлээд байгаа улс төр, эдийн засгийн хямралын бодит шалтгаан нь итгэлцлийн хямрал юм. Өөрөөр хэлбэл Засгийн газар, Улсын Их хурал, Шүүх, улс төрийн намуудад итгэх иргэд, ард түмний итгэл суларч энэ нь хэт даамжирч байна.

Итгэлцлийн хямралыг судлаачид үзэхдээ төрийн байгуулалтын институциудад итгэх итгэлийг сулруулснаар хууль дээдлэх зарчмыг алдагдуулж, бүх шатанд хариуцлагыг эзэнгүйдүүлж, эдийн засаг, нийгмийн бүхий л салбар уналтанд ордог гэжээ.

Тиймээс бид дээр дурьдсан хүний төлөө, хүнд үйлчилдэг, хүн өөрөө асуудлыг шийддэг тогтолцооны эрэл хайгуулд гарахаас өөр арга зам үлдсэнгүй.

Магадгүй хүн өөрөө асуудлыг шийддэг тогтолцоо хамгийн итгэлтэй бөгөөд шийдлийн гарц гэж үзэх хандлага орчин үед хүчээ авч байна. Өөрөөр хэлэл Монгол хүнээр асуудлыг шийдүүлдэг Ардчилсан төр гэж ойлгож болно. Үүнийг Судлаач Ж. Фишкин хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй бүтээлдээ Зөвлөлдөх Ардчиллын талаар дурьдсан ба зөвлөлдөөн нь шийдвэр гаргах үндсэн арга зам байдаг ардчиллын хэлбэрийг ойлгоно гэжээ.⁴

Харин зөвлөлдөөн гэдэг нь: хувь хүмүүс олон төрлийн асуудал, нотолгооны давуу талыг дэнслэн бодож, тэнцвэртэй, мэдээлэлтэй, олон ургалч хэлэлцүүлгийн үйл явцыг хэлжээ.

Иймд бид улс төрийн тэгш эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж зөвлөлдөх эрх гэсэн үндсэн хоёр үнэт зүйлийг хэрхэн хэрэгжүүлэх талаар судлах шаардлага гарч байна.

⁴ Ж. Фишкин. Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй. УБ. 2015., 15 дахь тал



Зөвлөлдөх гэх нэрийдлийн дор олон нийтийн бодол санаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн хандлага руу маш хүчтэй хазайж, ард иргэдийн түүхий үзэл бодлыг илүүд үзэж харгалзах хандлага илрэх тал бий.

Тухайлбал, Манай улсад 2014 оны төсвийг батлахаас өмнө Сангийн яамны мэргэжилтэнгүүд бүх сумдаар явж тухайн орон нутагт нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой эрэмбийг гаргасан нь ард иргэдэд шууд чиглэсэн зөвлөлдөөний тогтолцоо нь мэдээлэл муутай хий хоосон зүйлд итгэх байдлыг олон нийтэд өгдөг байна.

Иймд олон нийтийн зөвлөлдөөнийг хэрэгжүүлэх аргачлалыг ашиглах ёстой гэж зөвлөдөг.

Үүний тулд үндсэн хоёр асуудлыг тодорхойлох шаардлагатай ба эхний асуудал нь олон нийтийн ямар санал бодол, асуудлыг зөвлөлдөх ёстой вэ гэдэг байх бол дараачийн асуудал нь хэнтэй зөвлөлдөх вэ гэдгийг шийдэх явдал юм.

Үүнийг шийдсэн тохиолдолд зөвлөлдөх процессыг зөв тодорхойлох ёстой.

1. Мэдээлэл: тухайн асуудалтай холбоотой зүй ёсны баримт, мэдээллийг оролцогчдод түгээх

2. Бодит тэнцвэр: тодорхой байр суурийг эзлэж байгаа талын эсрэг үндэслэл бүхий нотолгоо баримт дэвшүүлэн тавьж байгаа тал оролцох

3. Төрөлжсөн байдал:

хэлэлцүүлэгт оролцогчид нийгэм, олон нийтийн ямар, ямар чухал байр суурийг төлөөлж байгаагаар нь ангилах

4. Ухамсартай шударга байдал: ямар оролцогчид тухайн асуудалд оролцож чин сэтгэлээсээ хандаж байгаад ач холбогдол өгөх

5. Тэгш эрхтэй хэлэлцүүлэг: бүх оролцогчдын дэвшүүлсэн санал хэнийх гэдгээс үл хамааран хэлэлцэх ёстой ба эдгээр таван нөхцөлийг биелүүлсэнээр энгийн хэлэлцүүлгээс хэд дахин ялгарах болно гэжээ.⁵

Дүгнэж үзвэл:

Трилемма буюу гурваас нэгийг нь сонгох хүндрэл болох

- Олон нийтийн оролцоо /тэдний саналыг хэрхэн цуглуулах/
- Улс төрийн эрх тэгш байдал /саналыг хэрхэн үнэлэх, тоолох/
- Зөвлөлдөөн /ард түмний үзэл бодлыг хэрхэн бүрдүүлэх/ гэсэн гурван үнэт зүйлс нь ардчилсан үйл явцын өөрийнх нь загварт ашигладаг.

Бодит байдалд дээрх гурван сонголтын хоёрыг нь бид бүрэн хэрэгжүүлэх боломжтой магадгүй хэрэгжүүлж ирсэн. Харин гурвууланг нь зэрэг хэрэгжүүлвэл шинэчлэлийн тогтсон чиглэлд "ард түмний итгэлийг дагуулан" хөтлөж боломжтой юм.

⁵ Мөн тэнд 69 дэх тал



ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ, ПОСТМОДЕРН

/Захиргааны эрх зүйн хүрээнд/



Ц.Амарсанаа /LLM/

Орчин үеийн эрх зүйн үзэл баримтлал, философийн хөгжил нь дундад зууны үеийн схоластик эрх зүйн философитой салшгүй холбоотой. Эрх зүйн хэм хэмжээнүүд нь хоорондоо зөрчилдөөнийг бий болгож, бие биетэйгээ зөрчилдсөн тохиолдолд хууль, эрх зүйн шударга ёсны шүүлт болгох¹ үзлээс энэ хандлага үүсэлтэй. Тиймээс энэ үеийн сэтгэгчдийн дунд эрх зүйн төрөлх эхэнлэг чанарыг танин мэдэхгүйгээс ахуйд буюу хэт бурханлаг үзэл философиос эрэл хайгуул улам бүр хүчтэй хийгдсээр байсан. Профессор Ж.Робертсын тэмдэглэсэнээр: "Бурхан байх бөгөөд хүмүүний амьдралыг төлөвлөн зохицуулж, хэн бурханы төлөвлөгөөнд зааснаар амьдрах аваас сайн, хэн бурханы төлөвлөснөөс гажвал буруу номтон гэсэн сонгодог жам ёсны эрх зүйн онолд тулгуурлаж байсан?". Тиймээс

¹ Н.Лүндэндорж."Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага".УБ.,2002.38 дах тал.

² J.M.Roberts.Hystory of the World.1993 New York: Oxford University press.p.42

хүний хууль нь дээд бурхан хийгээд байгалийн хуульд нийцэж байх ёстой гэсэн сургаалиас үүдэж³, түүнд нийцээгүй хуулийг Августин /Augustine/ "Lex injusta non Lex" буюу "шударга бус хууль нь угаас хууль биш" хэмээн зарчим болгон тунхагласан. "Хүчин төгөлдөр хууль бүр ямар нэгэн шалтгааны хууль байдаг... шалтгааны хуулийг хүчин төгөлдөр хуулиас ялгаж салгах нь тун төвөгтэй" хэмээн XVI зууны английн хуульч Кристофер Жерман хэлсэн⁴ нь эл үеийн эрх зүйн сэтгэлгээний тод илэрэл мөн.

Харин XVIII-XIX зуунд байгалийн шинжлэх ухаанд гарсан нээлтүүд нь нийгэм хийгээд хүмүүнлэгийн ухааны асуудлуудыг шинээр авч үзэхэд хүргэсэн бөгөөд энэ нь эрх зүйн судлалыг ч мөн тойрсонгүй. Тухайн үед шинжлэх ухааны хүрээнд гарсан гэгээрэл нь хүнийг мистицизм буюу домог, сүсэг бишрэл, байгаль хийгээд дээд ухамсарт захирагдах байдлыг түүний өөрийнх нь оюун ухаанаар чөлөөлөхийг эрмэлзэв. Ингэснээр бидний өөрсдийн амьдралын ирээдүй гагцхүү бидний оюун ухаанаас үүдэлтэй гэх рационал үзэл улам бүр хүчтэй дэлгэрэх болжээ. Үүнд тулгуурлан

³ Т.Аквин мөнхийн жам ёсны бурхны, хүн төрөлхтний гэсэн дөрвөн төрлийн хуулийг заагласан бөгөөд эдгээр нь дээрх дарааллаар бие биедээ захирагдах ёстой ажруу.Thomas Aquinas Summa Theologica. Part II. Question XCVI.4 th article. Дам ишлэв.

⁴ St.Augustine. The Libero Arbitrio.1.v11. дам ишлэв.



орчин үеийн буюу модерн гэх нийгмийн үндэс нь гагцхүү оюун ухаанд итгэх итгэл дээр суурилж гарч ирсэн⁵.

Бурханаас юм уу, түүний хүслээр тогтоосон ямар ч дээд эрх зүй гэж байхгүй. Мөн байгалиас буюу жам ёсны ямар нэг хатуу тогтоосон зарлиг, хэм хэмжээ гэж үгүй бөгөөд түүнд дулдуйдсан ямар ч нийгмийн бүтэц, давхраа гэж байхгүй. Бүгд л оюуны хэрэглүүр, хүний өөрийнх нь бүтээл учраас хүнийг хүнээс өөр хэн ч аврахгүй. "Тиймээс хүмүүсийн нийгмийн хяналтын хэрэглүүр болох эрх зүйн тогтолцоог тэд өөрсдөө бүтээж чадах бөгөөд чадах ч ёстой" гэсэн үзэл санааг рационалистууд дэвшүүлсэн⁶. Үүнд үндэслэж ёс суртахууны үнэт зүйлээс эрх зүйг зааглах ёстой эсэх дээр хуваагддагаас үл хамааран орчин үеийн жам ёсны эрх зүйчид хийгээд позитивистүүд бүгд байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглан салгах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

Байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглах оролдлогыг хамгийн анх английн эрх зүй судлаачид болох Ж.Остин, Ж.Бентам нар хийсэн. Тухайлбал: Ж.Бентам: "Эрх зүй нь өөрт тавигдах шаардлагын дагуу бүтээгдсэн бол эрх зүй бөгөөд дээд тэнгэр хийгээд

бурханд нийцэх албагүй"⁷ хэмээн тэмдэглэсэн бөгөөд цааш нь өөрийн онолыг тодотгон "хуулийг позитив хэмээн нэрлэх шалтгаан нь хүнээс эхэнлэг гэдгийг тодотгож буйн зэрэгцээ бурхны хийгээд байгалийн хуультай өөр өөр ойлголтыг хооронд нь хольж хутгахаас сэрэмжлэв" хэмээн тодорхойлсон. Энэ үндсэн дээр тэрээр, хууль гэдэг бол бүрэн эрхтийн захирамж⁸ хэмээн тодорхойлсон.

Харин Ж.Бентам "Эрх зүйн тогтолцооны хамгийн чухал үүрэг, зорилгыг нэг бол өөрийнхөө хэм хэмжээ зарчмуудын тусламжтайгаар хүмүүсийн хоорондын аливаа нэгэн харилцааг нийгмийн ба хууль зүйн мэргэжлийн ухамсар ба практик эрх зүйн харилцаа болгон хэвшүүлэхэд оршино⁹. Тиймээс аливаа хуулийг шалгах шалгуур нь дээрхтэй уялдаж практик зорилгыг хангах чадвартай байна уу гэсэн үндэслэл болохоос биш дээд хуульд харшлах тухай биш¹⁰" хэмээн үзсэн. Мөн тэрээр "жам ёсны эрх"-ийн талаарх ямар нэг ойлголтоос үргэлж татгалзаж, цааргалж ирсэн бөгөөд түүний судалгаа эрх чөлөө, тэгш эрх, өмч хөрөнгө зэрэг ойлголтуудыг бүхэлд нь үнэ цэнэ, үнэлэмжийнхээ хүрээнд авч үздэг аж. "Эрх" гэдэг бол хууль зүйн ойлголт бөгөөд бид "эрх", "үүрэг"-ийн тухай ярихдаа

⁵ М.Батсуурь."Эрх зүйн хөгжил: Модерн ба постмодерн ба хандлага".УБ.,2006. Шихихутуг сэтгүүл.

⁶ Stuart Henry. Dragan Milovanovit.A.Constitutive Theory of Justice.1991.

⁷ Freeman M.D.M Lloyd's Introduction to Jurisprudence.London.2001.p дам ишлэв

⁸ Law is command of Sovereign

⁹ С.Нарангэрэл."Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо".УБ.,2001.60 дах тал.

¹⁰ Freeman M.D.M Lloyd's Introduction to Jurisprudence.London.2001.p дам ишлэв



юун түрүүнд хуулиар л сэтгэдэг. Хууль л таньд сонгох, сонгогдох, цалин мөнгө авах, цагдаагаар хамгаалуулах эрхийг өгдөг¹¹. Харин жам ёсны эрх гэдэг бол модон хөлтэй хүүхэлдэй¹² хэмээсэн байдаг.

Ж.Бентамын дэвшүүлсэн нэг чухал санаа бол эрх зүйг ашигт чанарын онол хэмээн нэрийдсэн утилитаризмын үүднээс тайлбарлахыг оролдсонд байдаг. Тодруулбал, ашигт чанарын зарим нь эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн аз жаргалыг нэмэгдүүлэх эсхүл хорогдуулах байдлаас нь хамааруулж аливаа үйлдэл бүрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх зарчмыг хэлнэ. Ашигт чанар гэдэг нь ямар нэгэн объект түүнийг хөндөж буй этгээдэд үр өгөөж, давуу тал, цэнгэл, сайн сайхан, аз жаргал бий болгох эсхүл гэм хор, өвчин шаналал, муу муухай, зовлон зүдгүүр учрахаас сэргийлэх шинж чанарыг хэлнэ.

Тиймээс ашигт чанар нь тухайн хүн амын дийлэнх хэсэгт хамаарах ёстой бөгөөд хууль нь хүний амьдралын асуудлуудын дийлэнх хэсгийг шийдвэрлэх чадвартай бол уг хуулийг даган мөрдөх ёстой ажээ¹³. Тэдний үзлийг Австрийн

эрх зүйн онолч Х.Келзен, Английн хуульч Г.Харт¹⁴ нарт үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Х.Келзен¹⁵ эрх зүйг дээд бурханлаг үзлээс салгах явдлыг бүрэн дэмжээд зогсохгүй мөн объектив мэдлэгийн бусад салбараас зааглах оролдлого хийсэн. Аливаа нийгмийн харилцаа өөрийн зохист байдлаар зохицуулагдан өрнөж байгаа нь ид шид биш, гагцхүү эрх зүйн гайхамшигт хүч. "Эдүгээ хууль зүйн шинжлэх ухааныхаа хувьд утгаа алдаж дуусчээ. Учир юу гэвэл хуульчид сэтгэл зүй, биологи эдийн засаг, улс төр, шашин, суртлын холимог бантан болсон төдийгүй эдгээр ухаанаас хэн их хуулснаараа гайхуулах болсон нь дээр өгүүлж буй утгын алдалт болж буй юм"¹⁶ хэмээн эрх зүйг мистицизм төдийгүй нийгмийн баримжаатай судлах хандлагад дайралт хийсэн. Хамгийн гол нь эрх зүйг цэвэр байлгаснаар хэн нэгний хүсэл зориг хийгээд бусад субъектив үнэлэмж шингэхийг хаах ажээ. Харин цэвэр эрх зүй бол хэм хэмжээ нь формаль тэгш байдлын зарчмаар харилцааг зохицуулж, хэн юу хийх ёстой үгүйг зааварлагч хэм хэмжээний нийлбэр

арилгахыг оролдсон. Тэдний үзлээр эрх зүйн мөн чанарыг танин мэдэхийн тулд хийсвэр онолуудад анхаарал хандуулахаас илүүтэйгээр шүүхийн практик анхаарах нь чухал. Эрх зүй нь уг гарвалаараа тэнгэрээс бус, газар дэлхийнх бөгөөд хэрэглэгдэхүйц шинжтэй, эрх зүй бол "тэнгэрт замрах хоосон бодол биш" бөгөөд товчоор "энэ нь шүүхийн шийвдэр юм" гэж тодорхойлсон.

¹⁴ H.L.A.Hart.The Concept of Law.Clarendon Law Series.Second edition. Oxford University press.1994 дэлгэрүүлэн үзэх.

¹⁵ Kelsen H.Pure Theory of Law.Translation from the second.1989. дэлгэрүүлэн үзэх.

¹⁶ Х.Тэмүүжин."Just farst буюу Ёст үг".УБ.,2004. 24 дэх тал.

¹¹ Bentam.J.Anarchical Fallacies.1987.p 73 дам ишлэв "Эрх зүй".УБ.,2004 сэтгүүл.Ч.Өнөрбаяр.

¹² Моиссеев. Философия права. Новосибирск.2003. дам ишлэв."Шихихутуг".УБ.,сэтгүүл.М.Батсуурь.

¹³ Сонгодог позитивистуудын дэвшүүлсэн санааг талархан дэмжиж америкийн реалист гарч ирсэн. Гэхдээ тэд эрх зүйг бурхан хийгээд хүний итгэл үнэмшлээс заагдах хандлагатай нэгддэг боловч эрх зүйг тодорхойлох хандлага дээр эрс өөр байр суурьтай байдаг Тодруулбал прагматизмын үзэл дээр суурилж Оливер Венделл Холмс, Ж.Франк/1889-1957/, К.Левеллин/1893-1962/ нар эрх зүй амьдралаас хэт тасарсан байдлыг



цогц ажээ¹⁷.

Английн эрх зүйн онолч Г.Харт "Эрх зүйн нь горим журмын цогц бөгөөд эдгээр горим журам өөрийн онцлогоос хамааран анхдагч ба хоёрдогч гэсэн үүрэгт хуваарилагдана. Анхдагч горим журам нь хүмүүсийн зан үйлийг тэдгээрийн хүсэл зоригоос үл хамааруулан дэглэж байдаг¹⁸". Тэрээр Ж.Бентамын ашигт чанарын онолын гаргалгаанд суурилж "Бараг оршин буй бүхий л эрх зүйн тогтолцоо нь хоёр нийгмийн зорилгыг хангахад чиглэгддэг буюу эхнийх нь хүмүүсийн амьдралын зайлшгүй хүрээг горим журмуудаар дэглэх. Ингэснээр амьдралын тохиолдол бүрт эрх бүхий этгээдээс тухайн үед хэрхэх тухай шийдвэр гаргуулахаар хандах шаардлагагүй болдог. Харин бүрхэг ойлголттой тулгарахад сөргөлдөх хоёр ашиг сонирхолуудын дундаас тухайн горим журмын бүрхэг хэсгийг тодотгох замаар анхныхаа зорилгыг илүү нээдэг... харин нээлттэй эрх зүйн бүтэц нь тохиолдлоос тохиолдол бүрт хувьсаж байдаг сөргөлдөх хоёр талын ашиг сонирхолыг заримдаа баланслах эрх бүхий этгээд /шүүх/-ээр тогтоолгох явдал байдгийг үгүйсгэх арагүй. Гэсэн хэдий ч дийлэнх үед амьд эрх зүй нь эрх бүхий этгээдэд тохиолдол бүрт шинэ эрэл хайлт

хийх шаарддаггүйгээр асуудлуудыг тогтоосон горим журмын дагуу шийдвэрлэх гарц болж чаддаг¹⁹" гэж номолж, эрх зүйн чиг үүргийг дийлэнх асуудлыг шийдвэрлэх чадвараар хязгаарласан.

Хэдийгээр эрх зүйг нийгмийн баримжаатай судлахаас татгалздаг позитивистүүдийн үзлийг дэмждэггүй ч хэт бурханлаг үзлээс ангид судлах хандлагыг дэмжиж буйгаа профессор Л.Фуллер /Lon Fuller/, Ж.Финнис нар өөрсдийн бүтээлдээ харуулсан. Тухайлбал Л.Фуллер "Эрх зүйн уг гарвалаараа газар дэлхийнх бөгөөд хэрэглэгдэхүйц шинжтэй. Эрх зүй бол тэнгэрт замхрах хоосон бодол биш... Үнэхээр дээд эрх зүй гэж байвал миний өгүүлж буй жам ёсны эрх зүйн үзэл доод буюу хүн төрөлхтөний эрх зүйд хамаарна" хэмээсэн. Цааш нь "Эрх зүйн нэн чухал чиг үүрэг бол хүмүүсийн зан үйлийг өөрсдөө тэдгээр зан үйлээ хянах нийтлэг горим журамд захируулах замаар нийгмийн дэг тогтоох явдал" бөгөөд хэрэв зан үйлийг хянах хуулийн энэ чиг үүргэд нийцээгүй хууль бол хууль биш. Харин энэ чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд горим журмуудын тогтолцоо нь дараах зарчмуудыг бүрэн тусгасан байх ёстой. Үүнд:

- Горим журмууд нь нийтлэг нөхцлөөр илрэх ёстой
- Горим журмууд нь нийтэд

¹⁷ Kelsen H.L. The Concept of Law. Clarendon Law Series. Second edition 1989 дам ишлэв.

¹⁸ Hart H.L. The Concept of Law. Clarendon Law Series. Second edition. Oxford University press. 1989 дам ишлэв.

¹⁹ Hart H.L. The Concept of Law. 129-135



зарлагдсан байх ёстой

- Горим журмууд нь үйлчлэх ирээдүйтэй байх ёстой
- Горим журмууд нь маш ойлгомжтой нөхцлөөр илэрхийлэгдсэн байх ёстой
- Горим журмууд нь бие биеэ малгайлан захирсан байх байх ёстой
- Горим журмууд нь хамрагдаж буй талуудын бүрэн эрхэд үл хамаарах зан үйлийг шаардах эрхгүй
- Горим журмууд нь субъект түүнд итгэл найдвараа алдтал байнга өөрчлөгдөх ёсгүй
- Горим журмууд нь үндсэн хэв маяг бүхий тогтолцоондоо захирагдах ёстой гэжээ. Үүгээрээ эрх зүй нийтлэг шаардлагыг хангах ёстой гэсэн Ж.Бентамын үзлийг баримталсан.

Дээрх сэтгэгчдийн үзлээс дүгнэвэл, эрх зүйн модерн хандлагыг үнэлж баршгүй ач гавъяа нь эрх зүйг мистицизм хийгээд дээд тэнгэрлэг, бурханы хүсэл зоригтой хутгаж байсан сэтгэлгээнээс хүн төрөлхтөнийг салгаад зогсохгүй хууль зүйн хандлагтайгаар судлах гарцыг нээсэнд оршино. Гэхдээ эрх зүй, ёс суртахуун хоёрын хооронд хөшиг бий эсэх асуудал дээр дотроо позитивизм ба жам ёсны эрх зүй онол гэсэн томоохон урсгалд хуваагддаг. Харин тэдний зүгээс эрх зүйд тавьдаг нийтлэг шаардлага

бол амьдралд тохиолдох асуудлын дийлэнхийг нь хэм хэмжээ буюу горим журамд үндэслэн шийдвэрлэх чадвартай байх явдал²⁰.

XX зуун сүүлчид Франкфуртын их сургуулиас гарсан хүчтэй давалгаа нь ганцхан эрх зүй судлалын төдийгүй нийт сэтгэлгээний төвшинд хувьсгал хийв²¹. Тэдний үзлээр объектив бодит байдал гэж байхгүй. Бодит байдал гэдэг бол социал бүтэц бөгөөд энэ нь бидний мэндлэхээс өмнө аль хэдийн угсрагдсан байдаг. Тиймээс бидэнд жам ёсны гэх нэрийн дор хүлээн зөвшөөрөгдсөн үнэн чанартаа зохиомол ертөнц юм. Үүнийг менарратив хэмээдэг. Тухайлбал, марксизм, фрейдийн психианализм, лебирализм гэсэн нэрийн дор хөгжиж буй метанарративүүд биднийг нэг хэвэнд цутган, гагцхүү нэг логикт захируулж, нийгэм даяар өөрийн хяналтыг бүрэн тогтоож чаддаг. Үүний үндсэн дээр жинхэнэ би гэж байхгүй болдог. Амьдарч буй нийгмээ төсөөлөх миний өнцөг өмнө нь байсан бөгөөд хэн нэгэн надад үүнийг өвлөсөн юм.

Түүчнлэн, мэдлэг бол хүч. Хэрэв үнэхээр бодит байдал нийгмийн зохиомол ертөнц байх аваас түүнийг зохиосон, сэдсэн этгээд агуу их эрх мэдэлтэй. Учир нь тэр биднийг өөрөө ямар байдлаар ертөнцийг харахыг хүсэж байна, тийм байдлаар биднийг харахыг

²⁰ "Шихихутуг".сэтгүүл."Эрх зүйн хөгжил: модерн ба постмодерн хандлага" илтгэлээс.

²¹ Теодер Адорно



шаардаж байна. Тэгхээр үүнийг жам ёсны хэмээн нэрийдлээр бидэнд ухуулга хийдэг²². Десконструкци-зохиогчийн хүсэл зоригоос үл хамааран текстэнд дадал туршлагаас ангид сэтгэлгээний хэв маягийг тодорхойлох үйл явц, арга хэрэгсэл мөн. Энэ үндсэн дээр постмодерн хэлбэр нь бидний илүү гүнзгий бодож олсон ертөнц рүү шигдэж, илүү уран сайханы, нийгмийг тайзчилсан, театрчилсан хэв маяг, төрхийг нэгэнтээ олох болсонд²³ Ж.Бодрийяр синволик ертөнц дэх симулякр хэмээн томъёолсон биз.

Тэгхээр дээрхтэй уялдаж постмодерн хандлага эрх зүйтэй ямар хамааралтай гэвэл сэтгэлгээний өөрчлөлт өөрөө нийгмийн өөрчлөлтийг дагуулдаг гэсэн ерөнхий зүй тогтолын өнцгөөс ажиглавал эрх зүй нь нийгмийн хяналтын хэрэглүүр болохын хувьд шууд хамааралтай гэсэн үг. Хүний оюуны хөгжил нь амьдралыг цоо шинэ хуудас, хэмнэлээр дүүргэх болж, түүгээр ч үл барам эрх зүйг энэ харилцааг хамгаалах чадвартай, түүнд хүрч үйлчлэх илүү үр нөлөөтэй байхыг шаардах болжээ. Үүнд тулгуурлан постмодернистууд уламжлалт эрх зүйн онолд шүүмжтэй хандах болсон.

Уламжлалт сэтгэлгээний хэв маяг, түүнд тулгуурласан эрх зүйн онолд няцалт хийхийг зорьсон анхны

ородлогыг нэг нь Английн засгийн газарт хандсан Вольфендены комиссын илтгэл байлаа²⁴.

Эрх зүйн нийтлэг ашиг сонирхолыг хамгаалах ёстой боловч түүгээр бамбай хийн хувь хүний эрх чөлөө, ашиг сонирхолын ертөнцөд халдах эрхгүй бөгөөд энэ нь түүнд нэвтрэх биз биш. Түүгээр ч үл барам эрх зүй нь зүй ёсны хувь ашиг сонирхолыг дэмжих хэрэгсэл мөн. Тиймээс эрх зүйг хэм хэмжээ, горим журам хэмээн үзэх уламжлалт хандлага нь "тэг эсхүл, үгүй" /all of nothing²⁵/ ерөнхий туйлд баригддаг учраас түүний дунд орших асар олон хувилбарт сэтгэх боломжийг хааж²⁶, дээрх чанар нь эрх зүйг хатуу тогтсон позитив гэхээсээ мөн харцангуй уян хатан байхыг үгүйлээд зогсохгүй энэ чадвараар нөлөөтэй эрх зүйн зарчмуудын үүргийг улам бүр өсгөх болжээ. Үүнийг онолын түвшинд боловсруулсан сэтгэгч бол Р.Дворкин /R.Dworkin/²⁷ юм.

²⁴ Хавсралт үзнэ үү № 1

²⁵ Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review, 45.. Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review, 45..

²⁶ "Ба, бөгөөд, энэ тохиолдол, магадгүй, эсхүл" гэсэн нэр асар олон хувилбаруудад хөрвөн сэтгэж чаддагаараа хүний оюун ухаан гайхамшигтай бөгөөд энэ чанараар дээрх ерөнхий нөхцөлд л ажиллах чадвартай зохиомол оюун болох компьютерээс эрс ялгарна.

²⁷ Dworkin R. Law's Empire. Cambridge: Harvard University Press. 1986; Dworkin R. Taking Rights Seriously. Cambridge: Harvard University Press. 1977; Dworkin R. Is Law a System of rules? Harvard Law Review. зэрэг бүтээлд тусгагчдсан. дам ишлэв.

²² "Шихихутуг". сэтгүүл. УБ., 2006. М. Батсуурь. "Эрх зүйн хөгжил: Модерн ба постмодерн хандлага" илтгэлээс.

²³ Моисев С.В. "Философия права". Новосибирск. 2003. с. 188.



ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ.

/Дүгнэлт/

Захиргааны эрх зүйн нэрт судлаач Otto Mayer "Германы захиргааны эрх зүй" гэсэн бүтээлдээ "Үндсэн хуулийн эрх зүйн үе өнгөрч, захиргааны эрх зүйн үе эхэлж байна" гэж бичсэн нь олны анхаарлыг ихээхэн татсан байдаг. Мөн үүний дараа захиргааны эрх зүй судлаач Fritz Werner "Захиргааны эрх зүй бол нарийвчилсан зохицуулалт бүхий Үндсэн хуулийн эрх зүй мөн" хэмээсэн байна²⁸.

Үндсэн хууль нь нийгмийн хамтын амьдралын үндсийг тодорхойлоод зогсохгүй ялангуяа хууль болон хуулийг дагалдан гарах актын эрх зүйн байдал болон эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх зарчмыг нь агуулдаг. Үндсэн хуулийн түүхэн хөгжлөөс тодорхой харж болно. Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн гуравт "Монгол улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага мөн"²⁹ хэмээн түүний чиг үүргийн үндсэн агуулгыг нь хуульчилж өгсөн байна. Үндсэн хуулийн эрх зүйгээр хууль тогтоогч болон захиргааг Үндсэн хуулийг зөрчихийг хориглоод зогсоогүй мөн Үндсэн хуулийн эрх зүйн агуулгыг идэвхитэй хэрэгжүүлэх ёстой бөгөөд ингэснээр Үндсэн хуулийн нөлөөллийг хамгийн дээд хэмжээнд

байлгахыг заасан байдаг. Үндсэн хуулийн ихэнх хэм хэмжээ нь "захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр нарийвчилсан зохицуулалт бүхий Үндсэн хуулийн эрх зүй мөн" гэсэн дүгнэлтэнд хүргэсэн³⁰ болох талтай юм.

Орчин үеийн эрх зүйт төрийн салшгүй нэгэн шинж нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан эрх зүйн механизмыг бүрдүүлсэн байх явдал юм. Захиргааны эрх зүйн харилцааны нэг тал нь заавал хуулиар олгогдсон захирамжлах эрх бүхий этгээд байх бөгөөд төр ба иргэдийн хоорондох эрх зүйн харилцаанд голчлон илэрдэг. Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд болох захиргааны эрх зүйн давуу байдлаас иргэдийн эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн механизм бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Иймд захиргааны үйл ажиллагааг өөр ямар нэгэн хараат бус байгууллагаас хянаж байх шаардлагатай болдог³¹.

Өнөөдөр манай улсад 520 гаруй хууль үйлчилж байгаагийн 230 гаруй хууль нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд аливаа шийдвэр гаргах боломжийг зохицуулсан байна. Гэвч эдгээр хуулиудад бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх үндсэн зарчим, нийтлэг журам, түүнийг биелүүлэх

²⁸ П.Одгэрэл. "Захиргааны эрх зүйн ерөнхий анги". УБ., 2008. 53 дэх тал.

²⁹ Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй. 1992

³⁰ Мөн талд.

³¹ П.Одгэрэл. "Захиргааны эрх зүйн ерөнхий анги". УБ., 2008 он. 57 дэх тал.



үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зохицуулалт байхгүйгээс төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах шаардлага тэр бүр биелэгдэхгүй, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг дур зоргоор гаргаж хохироох явдал цөөнгүй гарч байна. Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, эрх зүйт төрийн зарчим, эрх зүйт хуулийн зарчим (rule of law), хууль дээдлэх зарчим, тэгш эрхийн зарчим, зөрчигдсөн эрхээ шударга шүүхээр хамгаалуулах зарчим яаж тусгалаа олох, ямар байдлаар хэрэгжих нэгдсэн ойлголт, зохицуулалт байхгүй байна. Энэ нь төрийн захиргааны байгууллага иргэдийн эрхийг хөндсөн аливаа шийдвэр гаргахын өмнө тэдний оролцоог хангадаг зохицуулалтыг зарчим байдлаар хуулиар зохицуулаагүйтэй холбоотой. Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа эхлээд 10 гаруй жилийн хугацаанд төрийн захиргааны байгууллага, албан

тушаалтны хууль, хүний эрхийг зөрчсөн цөөнгүй шийдвэрийг хүчингүй болгож, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэм буруутанд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг авч ирсэн нь төрийн байгууллага хууль дээдлэн ажиллах, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчвөл тэдгээрийн шийдвэр хүчингүй болдог гэсэн итгэлийг иргэдэд төрүүлж чадсан байна³². Гэвч Монгол улсын хувьд нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний актын хувьд төдийлөн эрх зүйн сэтгэлгээ хандлагын хувьд бус бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд орж байна. Тухайлбал улс төр, эдийн засгийн хэт давамгай ашиг сонирхол, тодорхой хувь этгээдийн хүсэл сонирхол актын утга агуулгад нөлөөлж байна. Энэ нь нийгмийн хэвшмэл сэтгэлгээнд оруулах талтай байхыг аргагүй үгүйсгэх юм. Тухайлбал эрх зүйн сэтгэлгээний хандлагаас хамаарч нийгэмд горим тогтоох буюу хэм хэмжээ тогтоосон акт агуулга хянаж үзэх шаардлагтай байна.

³² Захиргааны ерөнхий хуулийн төслийн үзэл баримтлал



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



*М.Хатанзориг Шихихутуг ХЗДС-ийн
дадлагажигч багш*

Оршил

Шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэх явдлын ач холбогдол нь тухайн шүүх, шүүхийн хэрэглэж буй хууль тогтоомжоор хамгаалагдаж буй хүний эрхийн үнэ цэнээр хэмжигдэнэ. Эрх зүй, түүний илрэн гарч буй гадаад хэлбэр болох хууль тогтоомжийн оршин буй шалтгаан нь эцэстээ хүний эрхийг хамгаалахад чиглэсэн талаар орчин үеийн хууль зүйн шинжлэх ухааны онолуудад дурьдах болсон. Логикийн хувьд аваад үзэхэд ч

шүүхийн шийдвэр биелэгдэхгүй бол тухайн шүүхээс тодорхой хуулийн заалтыг хэрэглэсний¹ үр дүн, ач холбогдол нь бодитоор хэрэгжихгүй гэдэг нь тодорхой. Монгол улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь захиргааны байгууллага, албан тушаалтнуудын хууль зөрчсөн ажиллагаа болон иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолтой холбоотой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх боломж, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн томоохон алхам байсан. Гэвч аль ч улсын² шүүхэд гарч болох шийдвэр гүйцэтгэлийн “өвчлөл” манай захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд мөн адил үүссэн нь нууц биш. Тухайлбал: 2012 онд Захиргааны хэргийн шүүхээс Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 81 шийдвэрийг гүйцэтгүүлэхээр хүргүүлснээс ердөө 21 нь буюу 26 нь хувь биелэгдэж үлдсэн хэсэг нь биелэгдээгүй байна.³ Тийм ч учраас уг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд дүн

¹ Шүүхээс хууль хэрэглэж хэргийг таслан шийдвэрлэх нь эцэстээ хүний эрхийг хамгаалах зорилготой боловч уг хамгаалалт нь тухайн шүүхийн шийдвэр биелэгдсэнээр л хэрэгжих юм.

² Зарим ардчилсан бус улс орнуудад шүүхийн шийдвэр гармагцаа гарцаагүй биелэгддэг нь тухайн улсын улс төрийн дэглэм, дарангуйлалтай холбоотойгоор тайлбарлагддаг.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2012 оны 4 дүгээр улирлын судалгаа.



шинжилгээ хийхээр энэхүү сэдвийг сонгон авч судаллаа.

Судалгааны зорилго:

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд дүн шинжилгээ хийж тулгамдсан асуудлуудыг тодорхойлон боловсронгуй болгох арга зам, саналуудыг дэвшүүлэхэд судалгааны туйлын зорилго оршино.

Судалгааны аргачлал:

Судалгааг шинжлэх ухааны судалгааны аргууд болох түүхчлэх, статистикийн, харьцуулалтын болон хууль зүйн шинжлэх ухаанд түлхүү хэрэглэгддэг анализ, синтез, индукц, дедукцийн аргуудад тулгуурлан гүйцэтгэсэн болно.

Судлагдсан байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн болон захиргааны эрх зүйн чиглэлээр бичигдсэн ном, бүтээлүүдэд уг асуудлын талаар дурьдсан байдаг боловч судалгааны түвшинд бичсэн, хийж гүйцэтгэсэн ажлууд одоогоор нийтэд ил биш байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн үндэс

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 зүйлийн 5.2-т⁴ зааснаар захиргааны хэргийн шүүхээс гаргасан хүчин төгөлдөр акт нь заавал биелэгдэх шинжтэй байдаг ба хэрэв холбогдогч этгээдүүд актыг

⁴ Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ.

эс хэрэгжүүлвээс мөн зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэх ёстой. Түүнчлэн хуулийн 78 зүйлийн 78.1-т зааснаар хэргийн оролцогчид шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс нь биелүүлж эхлэх үүрэгтэй. Хэрэв сайн дураар биелүүлээгүй бол хуулийн 93 зүйлийн 93.1 хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлэх учиртай.

Дээрх хуулийн заалтуудаас харахад Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа нь ердийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай адил журам, зохицуулалттай байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь хэсэгт: "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр..." гэж заасан байна. Гэтэл ихээхэн ялгаа бүхий зорилго, чиглэлтэй захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ердийн шүүхийнхтэй ижил журмаар явагдаж буй нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үр дүн муутай болгож, иргэдээс засаг төр, шүүхэд итгэх итгэлийг алдруулах сөрөг ойлголтонд хүргэхээр байна. Хэдийгээр захиргааны хэргийн шүүхийн процессын ажиллагаа нь ердийн шүүхийн процессын ажиллагаатай ижил зохицуулалттай



хэдий ч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь адил хэлбэр, журмаар явагдаж болохгүй нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик тоо баримтаас харагдаж байна.⁵

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны тулгамдсан асуудлуудын шалтгаан нөхцлийг тодорхойлох нь

Практик дээрх статистик судалгаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудаас авсан судалгаанууд, эрх зүйн зохицуулалтанд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, ердийн шүүхийнхтэй ижил журмаар зохицуулагдаж боломгүй нь дараах үндэслэлээс харагдаж байна.

Нэг. Хянан шийдвэрлэх маргаан, шүүхээс гарах шийдвэрийн агуулгын ялгаа

Хэдийгээр үйл ажиллагааны зарчим нь адил төсөөтэй боловч шүүхийн хянан хэлэлцэх маргаан нь ялгаатай байдаг. Захиргааны хэргийн шүүх нь нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг бол ердийн шүүх нь хувийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т зааснаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэний

болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байна. ИХШХШТ Хуулийн 6 115 зүйлийн 115.2-т зааснаар шүүхээс гарах шийдвэр нь гагцхүү нэхэмжлэлтэй холбоотой буюу нэхэмжлэлийг хангасан, хэрэгсэхгүй болгосон шинжтэй, нэхэмжлэлийн агуулга нь Иргэний хууль болон ИХШХШТХуулинд зааснаар тодорхойлогддог хувийн эрх зүйн асуудал байна. Гэтэл хувийн эрх зүйгээр нийгмийн харилцааг субъектүүдийн эрх тэгш байдлын үндсэн дээр зохицуулсан байхад, нийтийн эрх зүйн хувьд ихэвчлэн аль нэг тал нь засаглан захирсан шинжтэйгээр оролцдог бөгөөд энэ утгаараа иргэний болон захиргааны хэрэг нь хоорондоо ялгагдана. Тухайлбал:

- Иргэний хэрэгт тэгш эрхтэй талуудын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаан хамаардаг учраас харилцааны нэг талд заавал захиргааны байгууллага, албан тушаалтан байхыг шаарддаггүй “хэвтээ” шинж бүхий харилцаа байдаг. Гарч буй шийдвэр нь ихэнх тохиолдолд эд хөрөнгө гаргуулах тухай агуулгатай байна.⁷

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

⁷ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны эхний хагас жилийн тайлангаар Ердийн шүүхэд нийт 18360 хэргээс хамгийн их шийдвэрлэгдсэн хэрэг 6808-аар иргэний эрх зүйн маргаан байхад, Захиргааны хэргийн шүүхэд нийт 539 хэргээс хамгийн их буюу 108 нь гэзрын маргаантай холбоотой хэргүүд байна.

⁵ Оршил хэсэгт дурьдсанчлан 2012 онд Захиргааны хэргийн шүүхээс Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 81 шийдвэрийг гүйцэтгүүлэхээр хүргүүлсэнээс ердөө 21 нь буюу 26 нь хувь биелэгдэж үлдсэн хэсэг нь биелэгдээгүй байна.



- Захиргааны хэрэгт захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээрээ иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хөндсөн тухай маргаан байна. Хэргийн нэг талд нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэх буюу хариуцагч тал нь мөн захиргааны субъект байна. /босоо харилцаа/

Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтын асуудал

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар Монгол улс дахь шүүхүүдийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд заасны дагуу явагддаг. Гэтэл хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалтанд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд бэрхшээлтэй дараах асуудлууд байна:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /цаашид ШШГТХ гэнэ/ нь 2002 оны 01 сарын 10 өдөр буюу захиргааны хэргийн дагнасан шүүх бий болж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнө хүчин төгөлдөр болсон учраас захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаар

тусгайлсан заалт байдаггүй.

2. ШШГТХуулийн заалтуудад /15, 16, 17, 21 гэх мэт/ захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой агуулгыг тусгаагүй орхигдуулжээ. Тухайлбал, дээр дурьдсанчлан ердийн шүүхийн шийдвэр ихэвчлэн төлбөр гаргуулахтай холбоотой учраас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх, дуусгавар болгох зэрэг заалтуудад зөвхөн төлбөртэй холбоотой агуулгаар зохицуулагдсан. Мөн шийдвэр гүйцэтгэгчид эрх олгосон заалтууд /4 дүгээр бүлэг/ нь зөвхөн эд хөрөнгө гаргуулахтай холбоо бүхий зохицуулалттай аж.
3. ШШГТХуулинд зааснаар “төлбөр төлөгч, төлбөр авагч” нарыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд гэх бөгөөд тэдгээрийн эрх, үүрэг нь ч мөн адил төлбөр гаргуулах процесстэй холбоотойгоор хуульчлагдсан байна.
4. Аймаг, нийслэлийн засаг дарга нар, тамгын газруудтай холбоотой захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн шинжээч нар оролцох боломжгүй. Учир нь ШШГТХуулийн 33.4.1 хэсэгт зааснаар оролцогч нь



албан тушаалын болон бусад байдлаар нөлөө үзүүлэхээр байвал шинжээч нь татгалзан гарах зохицуулалттай. Түүнээс гадна Засгийн газрын тогтоолын дагуу шүүхийн шинжилгээний хүрээлэн нь Нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарна.

5. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд хамгийн өндөр хувь эзэлдэг, биелэгдэхэд бэрхшээлтэй байдаг тодорхой үйл ажиллагаа гүйцэлдүүлэх, эсвэл гүйцэлдүүлэхгүй байх чиглэлээр хэд хэдэн заалт байгаа боловч /9 бүлэг/ тэдгээр мөн л иргэний хэрэгтэй холбоотой буюу орон байрнаас гаргах, байр сав чөлөөлүүлэх тухай заасан байна. Харин захиргааны хэрэгт холбогдуулж болох 2 заалт байгаа нь огт хангалтгүй буюу ердөө мэдэгдэл хүргүүлэх, сануулах тухай агуулгатай байдаг. Гэтэл сануулах, мэдэгдэл хүргүүлэх нь албадан гүйцэтгэх буюу шийдвэрийг шууд биелүүлж буй шинжгүй байна.

Гурав. Бүтцийн удирдлага, зохион байгуулалттай холбогдсон асуудал

Практикт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хараат бус байдалтай холбоотой нэгэн томоохон асуудал бий. Засгийн газрын 2012 оны 190 дугаар тоот тогтоолд зааснаар Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын

хүрээнд нийт 32 хэрэгжүүлэгч агентлаг ажиллаж байгаа бөгөөд үүнд Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний хүрээлэн мөн багтаж байгаа юм. ШШГТХуулинд зааснаар шинжээч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй боловч шийдвэр гүйцэтгэгч татгалзан гарах зохицуулалтгүй. Түүнчлэн уг хуулийн 142.1-т заасан субъектүүд⁶ шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хяналт тавихаар хуульчилсан байна. Албан тушаалын байдлаар нөлөөлж болохуйц энэ нөхцөлд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа болон шийдвэр гүйцэтгэгчийн хараат бус, бие даасан байх зарчим хангагдахгүй байгаагаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа биелэгдэхгүй байгаа гэж үзэх үндэслэлтэй.

Дөрөв. Хариуцлагын тогтолцоотой холбоотой асуудал

ШШГТХ-н 90 зүйлийн 90.2, ЗХХШТХ-н 5 зүйлийн 5.3 дахь хэсгүүдэд зааснаас үзэхэд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, санаатайгаар зайлсхийсэн этгээдэд:

1. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 зүйлийн 30.3-т зааснаар 500-10000 төгрөгөөр торгох,
2. Эрүүгийн хуулийн 258 зүйлд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэн хэмжээний

⁶ Хууль зүйн яам, Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга.



төгрөгөөр торгох, 100-250 цаг хүртэл албадан ажил хийлгэх, 1-3 сар баривчлах ял оногдуулах, боломжтой байна.

Гэтэл захиргааны хэргийн биелэгдээгүй байгаа шийдвэрүүдийн дийлэнх хувийг эзэлж буй ашигт малтмал, газар, татварын маргаануудын үнэлэмжтэй харьцуулахад дээрх торгуулийн хэмжээ дэндүү өчүүхэн гэдэг нь харагдаж байна. Түүнчлэн цагдаагийн газар нь дээд шатны байгууллагуудын удирдлага дор ажилладаг учраас эрүүгийн хэрэг үүсгэх, байцаан шийтгэх ажиллагааг шуурхай, үнэн зөв явуулах үндсэн чиг үүрэгт нь саад учруулж болох магадлалтай. Түүнчлэн шүүхээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахад хяналт тавих боломж тун бага, хуулинд тусгагдсан ганц зохицуулалт нь ЗХХШтХуулийн 78.2-т "Захиргааны хэргийн шүүх шийдвэртээ биелүүлэх арга, журмыг заана" гэснээр хязгаарлагдаж байна.

Дүгнэлт

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой одоогийн эрх зүйн зохицуулалт хийгээд практик хүчин зүйлсүүдэд хийсэн судалгаанд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна:

1. Нийтийн болон хувийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн агуулга, үр дагавар, субъект нь ялгаатай байдгийг онолын

түвшинд шүүхийн практиктай уялдуулан судлах улам төгөлдөржүүлэн, эрүүлжүүлэх шаардлагатай байна.

2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны онцлогийг тусгасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, ингэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд нэмэлт оруулах, эсвэл бие даасан хууль гаргаж мөрдөх нь зүйтэй.

3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг дагнан байгуулах нь зүйтэй. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хараат бус, бие даасан байх, бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд захиргааны шүүхээс хяналт тавих боломж нөхцлийг ч мөн анхаарах шаардлагатай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2012, 2013 оны судалгаанаас үзэхэд шийдвэрийг биелүүлдэггүй албан тушаалтнууд нь засаг дарга, тэдгээрийн тамгын газрын дарга нар, сайд нар ихэвчлэн байгаа нь эл асуудал албан тушаалын нөлөөлөлтэй холбоотой гэдгийг харуулж байна. Түүнчлэн, ЗХХШтХуулийн 78.2-т зааснаар шүүхээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны заавар, журмыг тогтоож өгдөг байх нь эл ажиллагаанд шүүхийн хяналтыг



илүү бодитой болгоно.

4. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй. Тухайлбал, эрүүгийн хариуцлагын санкцыг илүү үйлчлэлтэй, үр нөлөөтэй, мэдэгдэхүйц болгох, захиргааны шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага бий болжээ. Одоогийн зохицуулалтаар шийдвэр гүйцэтгэгч мэдэгдэх хуудас өгөх, сануулахаас өөр зүйл хийж чадахгүй байна.
5. Захиргааны хэргийн шүүхийн мэргэшсэн шийдвэр гүйцэтгэгч нарыг бэлтгэх шаардлагатай. Дээр дурьдсанаар ердийн шүүхээс гарч буй шийдвэрүүдийн дийлэнх нь эд хөрөнгө гаргуулах тухай байдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нар ч мөн энэ чиглэлээр сүрхий мэргэшжээ.
6. Одоогийн нөхцөлд шийдвэр гүйцэтгэх байгууллагаас мэдээ, тайлангаа захиргаа болон иргэний хэрэг тус бүрээр ялгамжтай, схемтэй гаргаж

байх шаардлагатай бөгөөд захиргааны хэргийн тайлан иргэний хэргийн тайланд багтаж гардаг нь судалгаанд ихээхэн хүндрэл учруулж байна.

Эцэст нь: захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт тухайн шүүхийн нүүр царай, ач холбогдлыг харуулах нэн чухал ойлголт бөгөөд эрх зүйн философи, хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун, үзэл баримтлалд ихээхэн ач холбогдол агуулна. Гэтэл холбогдох судалгаануудаас эл шүүхийн шийдвэрийн биелэлт тун хангалтгүй байгаа нь харагдаж байгаа бөгөөд уг судалгаанд энэхүү асуудлын шалтгаан нөхцөл, түүнийг шийдвэрлэх, боловсронгуй болгох аргазамыг нээнирүүлэхийг зорьсон, ийм ч учраас зарим санаануудыг зориглон дэвшүүллээ. Эдгээр нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт, албадан гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй, хараат бус, бие даасан, шуурхай болгох, иргэд, нийгмийн төрд, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх цаашлаад захиргааны аппаратыг хүнд суртал бусад сөрөг үйлдлүүдээс ангижруулах, урьдчилан сэргийлэх онцгой ач холбогдолтой.